**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**/2017 оны жилийн эцсийн байдлаар/**

**2017.11.25.** **Булган**

## НЭГ. ХҮН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ

**Гэр бүлийг дэмжих, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.**

| Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | Арга хэмжээний дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) 2017 он: Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **1.1. Боловсрол:** ***Иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлж, суралцах, хөгжих таатай орчныг бүрдүүлэн багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг дээшлүүлж, оюунлаг, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.*** | | | | | | | | |
| **/1/** 1.1.1. Боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах аргыг сайжруулах замаар боловсролын салбарын хүний нөөцийг бэхжүүлнэ. | 1 | 1.1.1.1. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дэмжих, сурагчдын сурах идэвхийг өрнүүлэх зорилгоор “Амжилтын галт тэрэг” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТ, Төсөл, | Багш нарын идэвх, санаачлага, хариуцлага сайжирч, ажлын үр дүн бодитоор нэмэгдсэн байна. | Хөтөлбөрийн төслийг боловсруулан сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нараас санал авч 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөн, Иргэний танхимаар болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 135 дугаар тогтоолоор батлагдсан. | 40 |
| | 2 | 1.1.1.2. Ур чадвар, ажлын амжилтаараа | 2016-2020 | НБХ, БСУГ, | Улс, ОНТ | Мэргэжил дээшлүүлсэн | Ур чадвар, ажлын амжилтаараа манлайлж буй багш, удирдах ажилтныг үе шаттайгаар | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэргүүлж байгаа багш, удирдах ажилтныг гадаад, дотоодын урт, дунд, богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах, Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх | | СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | | багш, удирдах ажилтны тоо өссөн байна. Боловсролын салбарын удирдах ажилтны залгамж халаа бэлтгэгдсэн байна | сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх зэрэгт дэмжлэг үзүүлэх, урамшуулах зорилгоор тусгайлан журмыг боловсруулахаар “Амжилтын галт тэрэг” хөтөлбөрт тусгасан. 2017 он гарснаар сургалтын менежерт 2 удаа, захирлуудад 1 удаа, цэцэрлэгийн эрхлэгч нарт 1 удаагийн сургалт, семинарыг хийсэн. Багш нараас менежментийн чиглэлээр суралцах сонирхолтой хүмүүсийн судалгааг авахад 26 хүн хүсэлт гаргалаа. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран “Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны манлайлал” сургалтад сургалтын менежерүүдийг хамруулсан. Японы Морияа хот, ОХУ Красноярск хотуудад боловсролын удирдах ажилтныг туршлага солилцох уулзалтад хамруулснаас гадна, Булган сумын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчдийг ОХУ-ын Улан-Үдэ хотын Багшийг коллеж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцуулж, БСШУСЯ-тай хамтран ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат, Шилийн гол аймгуудад 16 багшийг туршлага судлууллаа. 2016 оны 11 сараас хойш 32 төрлийн сургалт, семинарт давхардсан тоогоор 2115 багш, удирдах ажилтныг хамруулжээ. | |
| | 3 | 1.1.1.3. Анги удирдсан болон ахмад, залуу багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулах, “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г ХХҮГ-тай хамтран зохион байгуулах | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, Цэцэрлэг | Улс, ОНТ, | “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-г ахмадын зөвлөх үйлчилгээ хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж, сум бүр “Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ”-ний багтай болсон байна. | Сургууль бүрт “Зөвлөн туслагч-Өвлөн суралцагч” аяныг зохион байгууллаа. Ахмад, залуу үеийн холбоог сайжруулах зорилгоор зөвлөн туслагч нарын багийг ахмад багш нараар бүрдүүлэн аймгийн төвийн болон урд бүсийн 8 сумын сургуулиуд дээр 2 багшийг ажиллуулж “Тайлбартай дасгалын арга”-ын тухай болон химийн багш нарт сургалт зохион байгууллаа. Цаашид тэднийг урамшуулах үйл ажиллагааг нь идэвхижүүлэх чиглэлээр ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрүүдэд холбохоор зорьж байна. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан 41 багшид “Анги удирдсан багшийн манлайлал ба сурагчдын мэргэжил сонгоход туслах арга зүй” гэсэн сургалтыг “Сэрүүлэг” дээд сургууль, “Монголын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүний нөөцийн хөгжлийн ассоциаци"-тай хамтран зохион байгуулсан. | |
| | 4 | 1.1.1.4. СӨБ, ЕБС-иудыг мэргэжлийн багшаар бүрэн хангах, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг татан ажиллуулах ажлыг зохион байгуулах, хөрш орнуудад сургаж бэлтгэх | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, | Боловсролын байгууллага мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан байна. | Мэргэжлийн багшийн хангалт 94.7 хувьтай байна. Булган сумын 640 хүүхдийн суудал бүхий 3-р сургууль шинээр байгуулагдаж байгаатай холбогдуулан тус сургуулийг мэргэжлийн ур чадвар өндөртэй багшлах боловсон хүчнээр хангах ажлыг зохион байгуулахаар судалж байна. Багш нарын мэргэжлийн ур чадвар, заах аргыг нэмэгдүүлэх зорилгоор хөрвөх сургалтад хамруулах ажлыг БМДИ, ТББ-уудтай хамтран зохион байгуулж байна. ОХУ-ын Улан-Үдэ хотын Багшийн коллежид 2017 оны 9-р сараас 2 хүүхдийг хөгжмийн багш мэргэжлээр сургаж эхэлсэн бөгөөд 12-р сараас зарим багш нарыг сургахаар тохиролцсон. | 70 |
| | 5 | 1.1.1.5. Сургууль, багш, БСУГ харилцан зөвшилцсөний үндсэн дээр сургуулийн удирдлага, багш нарыг солилцох, сэлгэн ажиллуулах, хөрш болон бусад орнуудын сургуулиудтай багш солилцох ажлыг зохион байгуулах | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, | Шинэ арга барил, менежментээр шинэчлэн удирдах нөхцөл бүрдүүлнэ. | Булган сумын зургаан цэцэрлэгийн эрхлэгч, Сэлэнгэ, Бугат, Хангал, Хялганат, Спортын дунд сургуулийн захирлуудыг 2016 оноос эхлэн үе шаттайгаар сэлгэн ажиллуулж байна. Орхон аймгийн БСУГ-тай хамтран сургууль, цэцэрлэгүүдийн багш нарыг харилцан туршлага солилцон ажиллуулах ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн зохион байгуулахаар хамтын ажиллагааны гэрээнд тусгасан. ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат хот, Улаанхад хот, Шилийн гол аймаг, ОХУ-ын Красноярск, Японы Морияа зэрэг хотуудтай хамтын ажиллагааны түвшинд боловсролын салбарт багш солилцох хөтөлбөрийг хэрэгжүүлэх санал тавиад байна. | 70 |
| **/2/** 1.1.2. Бүх шатны боловсролын сургалтын чанар, үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 6 | 1.1.2.1. Сурагчдын сурлагын чанар, үр дүн, сэтгэн бодох чадвар, оюуны спортыг дэмжих зорилгоор "Оюунлаг Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, | Дунд, ахлах ангийн сурагчдын сургалтын чанар нэмэгдсэн байна. | ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 34-р тогтоолоор "Оюунлаг Булган" хөтөлбөрийг баталсан бөгөөд тус хөтөлбөр Шатар, Ном, Мэтгэлцээн, Ой тогтоолт гэсэн үндсэн дэд хэсгүүдээс бүрдэж байна. Уг хөтөлбөрийг 2017 онд хэрэгжүүлэхэд ОНТ-ийн 32.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан.<br>-Мэтгэлцээн дэд хэсгийн хүрээнд сургагч багш 16, мэтгэлцэгч сурагч 60 хүүхдийг сургалтад хамруулан аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 баг амжилттай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцлоо.<br>-Ой тогтоолт дэд хэсгийн сэдэлжүүлэх сургалтыг бүх сумдаар зохион байгуулж, сургуульд ажиллах сургагч багш нарыг сонгон сургагч багшаар бэлтгэх нэгдсэн сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 30 багш хамрагдсан. “Ой тогтоолт”-ын сургалтыг сургууль бүр дээр 7 хоногт 2 удаа хичээллүүлж байна. Аймгийн төвийн болон урд, хойд 12 сумын сургуулиуд дээр очиж хөтөлбөрийн явцад мониторинг хийж, сургалт зохион байгуулаа. Энэ үеэр 2016-2017 оны хичээлийн жилд сургалтад хамрагдсан 7, 11 ангийн сурагчид буюу одоогийн 8, 12 ангийн сурагчдаас шалгалт авч тэнцсэн сурагчдад сертификат олгосон. Шатрын спортыг хөгжүүлэх, сурагчдын авъяасыг нь дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Зүүн Азийн Аварга шалгаруулах Шатрын тэмцээнд аймгаа төлөөлөн 3 сурагч амжилттай оролцлоо. | |
| | 7 | 1.1.2.2. Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн хөгжлийн танхим ажиллуулах, хүүхэд багачуудын авьяас чадвар, бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж, техник сэтгэлгээг нээн хөгжүүлэх хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, секцийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулах | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, | Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн 80-аас доошгүй хувь нь дугуйлан, секцийн үйл ажиллагаанд хамрагдсан байна. | Хичээлээс гадуурх сургалтын ажлын хүрээнд сургуулиуд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, жүдо бөх, самбо бөх, чөлөөт бөх, үндэсний бөх, хөнгөн атлетик, тэшүүр, шагайн харваа, нум сум, уртын дуу, бүжиг, хөгжим, мэтгэлцээн, сийлбэр, уран уншлага, гар зураг, бокс, найрал дуу, морин хуур, гимнастик, уран нугаралт зэрэг нийт 80 гаруй дугуйлан секцүүдийг хичээллүүлж байна. Японы сайн дурын гишүүн Нагаминэ Чихиро, Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн С.Дэлгэрмаа нар хамтран 4-р ангийн 30 сурагчдад соробан сампингийн дугуйланг 7 хоногт 4 цаг, 3-р ангийн 30 сурагчдад цаасан урлалын дугуйланг 7 хоногт 3 цагаар хичээллүүлж байна. Сурагчдын урлаг, гоо зүйн мэдрэмж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор “Бидний гоёл-2017” тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. | 100 |
| | 8 | 1.1.2.3. Улсын “Математикийн олимпиад”-ыг зохион | 2017 | БСУГ, СЗДТГ, Сургууль | Улс, ОНТөсөв, | Олимпиадын бэлтгэл ажлыг | МУ-ын гавьяат багш Д.Шагдарын нэрэмжит “Монголын математикийн 53 дугаар олимпиад”-ыг 2017.05.03-07-ны өдрүүдэд амжилттай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | , цэцэрлэг | | хангаж, чанартай зохион байгуулах, Математик сургалтын чанар нэмэгдэж, мэргэжлийн багш нарын заах арга, ур чадвар сайжирсан байна. | зохион байгууллаа. Тус олимпиадад нийт 21 аймаг, 9 дүүргийн 42 баг, 162 сурагч, 66 багш, нийт 228 оролцогч оролцож шилдгүүдээ шалгаруулсан. Тус олимпиадад бэлтгэж аймгийн математикийн сургалтад ихээхэн анхаарсны дүнд тодорхой үр дүн гарч багийн дүнгээр 12-р байрт шалгарлаа. Цаашид хүрсэн үр дүн, хичээл зүтгэлээ улам бүр ахиулан ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллах шаардлага байна. | |
| | 9 | 1.1.2.4. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, сургалтын төв байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын оролцоо дээшилсэн хамтын ажиллагааны түвшин ахисан байна. | “Нээлттэй тархи” ТББ-тай хамтран ”Оюунлаг Булган” дэд хөтөлбөрийн “Ой тогтоолт” дэд хэсгийг, “Илтгэгч, мэтгэлцэгчдийн холбоо”-той хамтран “Мэтгэлцээн” дэд хэсгийг, “Шатрын холбоо”-той хамтран “Шатар” дэд хэсгийг, Номын дэлгүүрүүдтэй хамтран “Ном” дэд хэсгийг тус тус хэрэгжүүлж байна. Түүнчлэн Математикийн сургалтыг сайжруулах чиглэлээр УБ хотын “Олонлог” төв сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна. “Глоб Интернейшнл” байгууллагатай хамтран Булган сумын 1-р, Бугат, Орхон сумын сургуулиудад “Боловсролын салбарын ил тод байдал-эгэх хариуцлага” төслийг хэрэгжүүлж байна. | 90 |
| | 10 | 1.1.2.5. Аймгийн тэргүүлэх чиглэлийн судлагдахууныг тодорхойлж, орон нутгийн онцлогийг тусгасан чиглэлийг хэрэгжүүлэх | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв | Математик, Гадаад хэл, Монгол хэл, Байгалийн ухааны хичээл тус бүрээр чиглэл боловсруулж хэрэгжүүлсэн байна. | Аймгийн тэргүүлэх чиглэлийн судлагдахуун нь Математик, Англи хэл, Монгол хэл, Байгалийн ухааны хичээлүүд бөгөөд тус судлагдахуунуудын сургалтын чанар, багшийн ур чадварыг нэмэгдүүлэх талаар тусгайлан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд Булган сумын 3-р сургуулийг Байгалийн ухаан, Гадаад хэлний гүнзгийрүүлсэн хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Түүнчлэн 2019 онд Улсын Химийн олимпиад, 2020 онд Улсын Физикийн олимпиадуудыг Булган аймагт зохион байгуулах | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна. | |
| | 11 | 1.1.2.6. Орон нутгийн онцлогийг тусгасан сурах бичиг бэлтгэх, сургалтанд нэвтрүүлэх | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв | Сурах бичиг хэвлэгдэж, сургалтанд нэвтэрсэн байна. | Аймгийн 80 жилийн ой угтсан 80 бүтээлч ажлын нэг болох “Анхдагч Булган” сурах бичгийг зохиох ажлын хэсэг Засаг даргын захирамжаар байгуулагдан Бага, дунд, ахлах ангийн агуулгаар бэлтгэж байна. 2017-2018 оны хичээлийн жилээс сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа бөгөөд 3-р улиралд Бага ангийн сурах бичиг сурагчдын гар дээр бэлэн болно. | 40 |
| /3/ 1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг бүх шатны боловсролд хамруулах, насан туршийн боловсролын бүтэц, үйл ажиллагааг шинэчилж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна. | 12 | 1.1.3.1. Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, бүх шатны боловсролд хамруулах талаар дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Судалгаанд байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулсан байна. | 2015 онд хийгдсэн сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношилсон суурь судалгаанд үндэслэн сургуулийн гадна, сурах эрхээ эдэлж чадахгүй байгаа сурагчдын судалгааг нарийвчлан гаргах, сургуульд хамруулах, сургагч багш нарыг бэлтгэх ажил судлагдаж байна. 2017-2018 оны хичээлийн жилд Хөгжлийн бэрхшээлтэй ЕБС-д 120 хүүхэд, албан бус боловсролд 20 хүүхэд суралцаж байна. | 70 |
| | 13 | 1.1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ | Улс, ОНТөсөв, | Сум тус бүрээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэнэ. | Төрийн албан хаагчдад сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахдаа дохионы хэлийг ашиглан тэдэнтэй ойлголцоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор "Дохионы хэлний анхан шат”-ны сургалтыг зохион байгууллаа. | 40 |
| | 14 | 1.1.3.3. Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөтгөх, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, Спортын холбоод | Улс, ОНТөсөв, | Насан туршийн боловсролын төвийг байгуулж, сум бүр салбар төвтэй болсон байна. | Насан туршийн боловсролын төвийг 2017 оны 6 дугаар сарын 1-нээс 3 хүний орон тоотойгоор байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаН БСУГ-ын дэргэд үйл ажиллагаа нь эхлүүллээ. | 70 |
| /4/ 1.1.4. Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчныг тохижуулах, хүүхдэд ээлтэй сурах | 15 | 1.1.4.1. Хүүхдийн бие бялдар, оюун ухааны хөгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль | Улс, ОНТөсөв, Төсөл, | Сургууль, цэцэрлэгийн 70,0-аас доошгүй хувь | 2017 онд боловсрол, соёлын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж, төсвийн тодотголоор 741.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдсэнээр салбарын хэмжээнд тулгамдсан зарим | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| орчин бүрдүүлж, “Цахим сургууль-Цахим сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр сургууль, цэцэрлэгүүдийг үе шаттайгаар хангах | | , цэцэрлэг | хөтөлбөр | нь сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | асуудлыг шийдвэрлэлээ. Энэ хөрөнгөөр сургууль, цэцэрлэгүүд сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмж авч сургалтадаа ашиглаж байна. “Оюунлаг Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, Хялганат тосгоны “Хараацай” чуулгын амьд хөгжмийн хамтлагийг цахилгаан хөгжим, Тэшиг сумын сургуульд даралтат хөгжим тус тус өглөө. Булган сумын 2-р цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтад орсонтой холбогдуулан гал тогооны тоног төхөөрөмж, хоолны халуун баригч зэргийг шийдвэрлээд байна. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 17 сургууль хамрагдаж 87.4, “STEM” хөтөлбөрт 21 сургууль хамрагдаж 106.7 сая төгрөгийн 432 багц хэрэглэгдэхүүн авсан. Мөн БСШУС-ын яамны хөрөнгө оруулалтаар 208.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ. | |
| | 16 | 1.1.4.2. Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрыг халуун устай болгож амьдрах орчин нөхцлийг сайжруулах | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг ээлж дараагаар шийдвэрлэсэн байна. | Орон нутгийн төсвөөс 28.0, “Өвсний үндэс” хөтөлбөрөөс 161.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Тэшиг сумын сургуулийн дотуур байрны их засвар, ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэсэн. Хутаг-Өндөр сумын сургууль дотуур байранд 140.0 сая төгрөгийн их засвар хийгдэж, ариун цэврийн байгууламж, халуун усны асуудлыг шийдэж сурагчдын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн байна. 2017 онд Хишиг-Өндөр, Рашаант сумдын дотуур байранд Дэлхийн зөн, Мобиком, ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар ариун цэврийн байгууламж барьж ашиглалтад хүлээн авсан. Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн Ариун цэврийн байгууламж байгуулах ажлыг Германы хамтын ажиллагааны байгууллагатай хамтран шийдэхээр болсон. | 100 |
| | 17 | 1.1.4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хэрэглэгдэхүүн, багш сурагчдын бүтээл, | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбө | Сургууль тус бүр багш сурагчдын бүтээл, шилдэг | Бага боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, туршлагыг CD-д хуулж авсан. /122 хичээл/ Аймгийн бүх сургуулиудад “Ухаалаг самбар” олгож, зайны сургалтын тоног төхөөрөмжөөр 8 сургуулийг хангаж онлайнаар харилцан | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сан бий болгох | | | р | тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сантай болсон байна. | суралцах боломжийг бүрдүүллээ. Багш нарын арга туршлага, заах арга, ур чадварыг сурталчлах, дэлгэрүүлэх зорилгоор цахим сан бий болгож teacher.mn, youtube.com сошиал сувгуудаар түгээж байна. Цаашид мэдээллийн нэгдсэн сайт бий болгохоор төлөвлөн ажиллаж байна. | |
| | 18 | 1.1.4.4. Бүх сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернэтэд холбох, сургуулийн дотуур байруудыг камержуулах, багш нарыг цахим сургалтын арга зүйд сургах | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернетэд бүрэн холбосон байна. | Сургууль, цэцэрлэгүүд бүрэн интернэтэд холбогдсон. Цаашид БСШУСЯ, “ZTE” ХХК-иуд хамтран хэрэгжүүлж буй “Шинэ зууны боловсрол-2” төслийн хүрээнд өндөр хурдны шилэн кабелийн өргөтгөлийн ажил хийгдэж багш бүрийн ширээнд интернэтийн үзүүр холбох ажлыг эхлүүлээд байна. Сургуулийн дотуур байруудыг камержуулах ажил 80%-тай явагдаж байна. Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Хялганат, Сайхан, Хутаг-Өндөр, Баян-Агт сумуудад зайны сургалтын тоног төхөөрөмжийг суурилуулж сургалтад ашиглаж байна. | 90 |
| **/5/** 1.1.5. Боловсролын салбарын байгууллагуудын барилгын өргөтгөл барих, их засвар хийх, хатуу, зөөлөн эдлэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. | 19 | 1.1.5.1. Боловсролын салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах | 2016-2020 | БСУГ, СЗДТГ, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр Иргэдийн оролцоо | Дуусаагүй барилгууд ашиглалтанд орсон байна. | Гурванбулаг сумын 240 хүүхдийн сургуулийн шинэ барилгыг 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн ашиглалтад хүлээн авсан. Мөн Булган сумын 2-р цэцэрлэгийн 150 хүүхдийн шинэ барилгыг 2017 оны 5-р сард ашиглалтад хүлээн авлаа. Сайхан сумын гал тогоо бүхий дотуур байрны барилгыг ОНТ-ийн 551.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар концессийн гэрээгээр барьж ашиглалтад хүлээн авсан. Булган сумын 640 хүүхдийн шинэ сургуулийн барилгын ажлыг энэ оны 12-р сард ашиглалтад хүлээж авахаар төсөвт 1.8 тэрбум төгрөг туссан. Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил 2017 онд 1051.1 сая төгрөг тусгагдаж ажлын явц 80 хувьтай, 2018 онд 1268.1 сая төгрөг төсөвт тусгагдаж 7-р сард ашиглалтад хүлээн авна. Тэшиг сумын 240 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил 70 хувьтай бөгөөд 2018 оны төсөвт 200.0 сая төгрөг туссан. | 90 |
| | 20 | 1.1.5.2. Бүрэгхангай, | 2016- | НБХ, | Улс, | Цэцэрлэгийн | - Сэлэнгэ сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн шинэ | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гурванбулаг, Сэлэнгэ, Тэшиг сумдын болон Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих | 2020 | БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж, барилга ашиглалтанд орсон байна. | барилгын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-750.0 сая/<br>- Гурванбулаг сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-948.0 сая/<br>- Бүрэгхангай сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-600.0 сая/<br>- Тэшиг сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр барихаар шийдвэрлэгдсэн.<br>- Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын их засварын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-250 сая/ 2013 онд 60 сая төгрөгөөр засвар хийсэн ч санхүүжилт зогссон. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй байна. | |
| | 21 | 1.1.5.3. Бугат сумын сургуулийн барилгыг шинээр барих | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургуулийн барилгын зураг төсөв хийгдэж, барилга ээлж дараалалтайгаар ашиглалтад орсон байна. | Бугат сумын 180 хүүхдийн сургуулийн шинэ барилгын зураг төсвийг УБ хотын “Зөв чиглэл” ХХК-иар хийлгэж бэлэн болгосон. /Нийт төсөвт өртөг-1.5 тэрбум төгрөг/. 2018 оны улсын төсөвт 924.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн. | 100 |
| | 22 | 1.1.5.4. Дашинчилэн, Рашаант сумдын сургуулийн дотуур байрыг шинээр барих, Хялганат тосгоны сургуулийн дотуур байранд өргөтгөл хийх | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургуулийн дотуур байрны барилгын зураг төсөв хийгдэж, барилга ээлж дарааалалтайгаар ашиглалтанд орсон байна. | Рашаант сумын 150 хүүхдийн ортой дотуур байрны өргөтгөлийн зураг төсөв хийгдсэн. /Төсөв-2.3 тэрбум/<br>Дашинчилэн сумын дотуур байрны өргөтгөлийн зураг төсөв хийгдсэн. /Төсөв-2.1 тэрбум/<br>Хялганат тосгоны дотуур байрны өргөтгөлийн зураг төсөв хийгдсэн. /Төсөв-2.0 тэрбум/<br>Саналаа БСШУСЯ-нд хүргүүлсэн. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй. | 0 |
| | 23 | 1.1.5.5. Сайхан, Сэлэнгэ, Баян-Агт, Гурванбулаг, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Орхон сумын | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургуулийн засварын ажлыг хийж, ашиглалтад | Дашинчилэн сумын сургуулийн их засварын ажлыг 104.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Хишиг-Өндөр сумын сургуулийн их засварын ажлын зураг төсвийг боловсруулсан. /Төсөв-924.0 сая/<br>Сэлэнгэ сумын сургуулийн их засварын зураг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулийн барилгад их засвар хийх | | | | орсон байна. | төсөв хийгдсэн. /Төсөв-690.1 сая/<br>Сайхан, Баян-Агт, Гурванбулаг, Хутаг-Өндөр, Орхон сумдын сургуулийн их засварын зураг хийгдээгүй. 2018 онд зураг төсвийг шийдүүлэхээр хөрөнгийг шийдвэрлээд байна. | |
| | 24 | 1.1.5.6. Бугат, Рашаант сумдын болон Булган сумын 1-р багийн цэцэрлэгийн сүрлэн барилга, 4, 6-р цэцэрлэгийн барилгад их засвар хийх | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж, ашиглалтад орсон байна. | - 1-р багийн сүрлэн цэцэрлэгийн барилга дахин ашиглах боломжгүй болсон тул БОАЖЯ-ны шугамаар гадаадын хөрөнгө оруулалтаар 100 хүүхдийн цэцэрлэг барихаар гэрээ байгуулсан. 1-р багийн салбар бүлгийг аймгийн ЗДТГ-ын дэргэд шилжүүлэхээр зураг төсвийн 25.0 сая төгрөгийг шийдвэрлэж “Өрх” ХХК-аар хийлгэж байна.<br>- Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг TIKA байгууллагын хөрөнгө оруулалтаар 84.0 сая төгрөгийн их засварын ажлыг хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан.<br>- 4-р цэцэрлэгийн их засварын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-223.1 сая/ 2018 оны БСШУС-ын сайдын багцад тусгуулахаар санал хүргүүлсэн.<br>- Рашаант сумын цэцэрлэгийн их засврын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-522.4 сая/<br>- Бугат сумын цэцэрлэгийн их засварын зураг төсөв хийгдээгүй. | 70 |
| | 25 | 1.1.5.7. Гурванбулаг, Сайхан, Бүрэгхангай сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх | 2016-2020 | НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургуулийн дотуур байранд их засвар хийж, ашиглалтанд орсон байна. | - Сайхан сумын дотуур байрны гал тогооны барилгын их засвар, барилга угсралтын ажлыг Орхон аймгийн “АНЭРД” ХХК концессийн гэрээгээр гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.<br>- Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны өргөтгөл хийх зураг төсөв хийгдсэн. /Төсөв-587.6 сая/<br>- Гурванбулаг сумын дотуур байрны их засварын зураг төсөв хийгдсэн. /Төсөв-124.3 сая/ 2018 оны ОНТ-д хөрөнгийн эх үүсвэрийг тусгасан. | 70 |
| | 26 | 1.1.5.8. Тэшиг сумын сургуульд спорт заал шинээр барих, Хангал, Баяннуур сумын сургуулийн спорт заалыг засварлах | 2016-2020 | | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Сургуулийн спорт заал ашиглалтанд орсон байна. | Хангал сумын ЗД, сургуулийн удирдлага санаачлага гарган Орон нутагтаа мод бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн тусламжтайгаар дээврийн банз, палк, шалны банз мод бэлтгэн сургуулийн спорт заалны дээврийг бүрэн засварлаж | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 27 | | | | | | дууссан. Баяннуур сумын сургууль орон нутгийн удирдлага, төгсөгчидтэйгээ хамтран “Бид чадна” төсөл бичиж засварын ажлыг хийсэн. БСУГ-аас төсөвт нь 15.0 сая төгрөгийн зохицуулалт хийн зарим эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Төсвийн тодотголоор 23.0 сая төгрөгөөр спорт заалны зориулалтын хулдаас авч өгөхөөр төлөвлөөд байна. Тэшиг сумын сургуулийн Спорт заал барих зураг төсвийг боловсруулах хөрөнгийн эх үүсвэрийг 2018 оны ОНТ-т тусгасан. | |
| | 27 | 1.1.5.9. Сурагчдын дотуур байр, цэцэрлэгийн бүлгүүдийн хатуу, зөөлөн эдлэлийг ээлж дараалан шинэчлэх | 2016-2020 | | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр Иргэдийн оролцоо | Хатуу зөөлөн эдлэлийн 80 хувийг шинэчлэнсэн байна. | Бүх цэцэрлэгийн нэг ээлжийн зөөлөн эдлэлийг 47.0 сая төгрөгөөр бүрэн сольсон. Дашинчилэн сум дотуур байрандаа 80 ширхэг модон ор авсан.<br>Сайхан сумын сургуулийн шинэ дотуур байранд 7 сая төгрөгөөр шинэ ор авсан. Мөн БСШУСЯ-наас 34.9 сая төгрөгийн хатуу эдлэл, гал тогооны хэрэгсэл нийлүүлэгдсэн. | 70 |
| **<u>1.2.Эрүүл мэнд:</u>**<br>***Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежментийг сайжруулан, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нотолгоонд суурилсан, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчилж, материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэн, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгож, иргэдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ.*** | | | | | | | | |
| **/6/** 1.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тандан судалж, хяналтын тогтолцоог сайжруулан эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион | 28 | 1.2.1.1. Эрүүл мэндийн боловсрол-Настны эрүүл мэнд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх | 2016-2020 | ЭМГ | ОУБ-0.8 сая Төсөл, хөтөлбөр-1.2 сая ₮ | -Иргэдэд эрүүл мэндийн боловсролын түвшинг тогтоох суурь судалгаатай болно.<br>-Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг суурь түвшингээс | “Эрүүл мэндийн хөтөч” аймгийн дэд хөтөлбөрийг ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын 2017 оны 35 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг боловсруулах явцад 15-61 насны 3700 иргэдээс эрүүл мэндийн боловсролын түвшин тогтоох судалгаа авсан. Судалгаанд оролцсон иргэд өөрсдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг сайн гэж 29 хувь, дунд гэж 61 хувь, муу буюу огт хангалтгүй гэж 10 хувь нь үнэлсэн байна. Иргэдэд эрүүл мэндийн боловсролын мэдээлэл, сургалт, сурталчилгаа нэн шаардлагатай гэж 81 хувь нь хариулсан бол дунд зэрэг буюу ач холбогдолгүй гэж 19 хувь нь хариулжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулан, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ. | | | | | | жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ | төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, хөтөлбөрийн чиглэлээр 8 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 230 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн дунд хөдөлгөөнт болон суурин хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 19 чиглэлээр 248 удаагийн сургалт сурталчилгааг нийт 23726 иргэний дунд зохион байгуулсан байна. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжид эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны 9430 ширхэг санамж, 496 ширхэг зурагт хуудас, 113 ширхэг сонины нийтлэл, 97 ширхэг ном, тохимол, давхардсан тоогоор 10152 ширхэг гарын авлага материалаар хангалаа. | |
| | 29 | 1.2.1.2. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг нэмэгдүүлж, багийн Засаг дарга, багийн эмч нарын уялдаа холбоог сайжруулах | 2016-2020 | ЭМГ, ЭМБ-ууд | Улсын төсөв, ОНХС | Эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын түвшинг 2016 оныхоос 15 хувиар нэмэгдүүлнэ | Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлэх заалтыг аймаг, сумын Засаг дарга нарын “Хамтран ажиллах үр дүнгийн гэрээ”-нд тусган, дотоодын хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих хүн амын 74.2 хувийг хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар өссөн байна. Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 81.3 хувь, чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 79.2 хувь нь хамрагдсан. Умайн хүзүүний өмөнгийн үзлэгт хамрагдвал зохих 3340 иргэнээс 1892 /56.6 хувь/, хөхний өмөнгийн үзлэгт хамрагдвал зохих 10549 иргэнээс 8374 /79.4 хувь/-ийг хамрууллаа. Эрт илрүүлгийн үзлэгээр шинээр оношлогдсон иргэдийг эмчийн хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх ажлыг шат дараатай хийж байна. Нийт багийн Засаг дарга болон багийн эмч нарын нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж, 90 хүнийг хамруулсан. Сумын ЭМБ-ууд багийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 30 | 1.2.1.3. “Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үндэсний стратеги”-ийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, анхан шатны ЭМБ-уудыг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах | 2016-2018 | ЭМГ, ЭМБ-ууд | ОНХС-29.9 сая, ТББ-аас 30.0 сая ₮ | -Эрт илрүүлэг үзлэгт жил бүр насанд хүрэгчдийн 20 хувийг хамруулна. | Элэгний B, C вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэн, “ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, эмч, эмнэлгийн болон хууль, хүчний байгууллагын нийт 815 ажилтан албан хаагчдыг хамруулсанаас 74 албан хаагч B,C вирусын халдвартай гарсныг эмчийн хяналтад авч, үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулллаа. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг Булган нэг үе клубын үйл ажиллагаатай уялдуулан “Хавдаргүй Булган” аяныг зохион байгуулж ОНТ-өөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аяны үеэр 25-аас дээш насны нийт 11962 иргэнийг B,C вирусын шинжилгээнд хамруулснаас B вирустэй 1186, C вирустэй 1358, B, C хавсарсан 79, элэгний хавдрын сэжигтэй 58 иргэнийг оношилж 3-р шатлалын эмнэлэгт илгээсэн. Аймгийн хэмжээнд 40-65 насны 16468 иргэн B, C вирусын шинжилгээнд хамрагдахаас 9476 буюу 57.5%-ийг хамруулж 2251 иргэн эерэг гарсныг үнэ төлбөргүй эмчлэн эрүүлжүүлж байна. | 100 |
| | 31 | 1.2.1.4. “Амны хөндийн эрүүл мэнд” аян зохион байгуулах | 2016-2020 | ЭМГ, ЭМБ-ууд | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Амны хөндийн өвчлөлийг 2016 оны түвшингөөс жил тутам 5 хувиар бууруулна. | “Эрүүл шүд” сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, урьдчилан сэргийлэх үзлэгт 2416 хүүхдийг хамруулсан. Нийт үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн шүдний цоорлын тархалт 91.6 хувь байна. Аяны үеэр 972 хүүхдийн шүдний цоорлыг эмчлэн эрүүлжүүлж, хүүхэд, цэцэрлэгийн багш болон эцэг, эхчүүдэд “Хүүхдийн шүдийг хэрхэн хамгаалах вэ” сэдвээр сургалт зохион байгуулж, 3 нэр төрлийн 1700 гаруй гарын авлагаар хангалаа. “Бадрал сан”-гийн санхүүжилтээр АШУҮИС-ийн Нүүр, ам судлалын нарийн мэргэжлийн эмч нартай хамтран амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шүд цооролтын эмчилгээг зохион байгуулсан. Үзлэгт нийт 420 гаруй иргэдийг хамруулан, үзлэгээр шүд цооролтын эмчилгээ 167, ломбо 172, чулуу түүх, өнгөлгөө эмчилгээ 153, шүд авах 208, эрүү нүүрний гажиг заслын зөвлөгөө 26 хүнд өгч, амны хөндийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Мөн Гурванбулаг, Могод сумдад амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шүд цоорoлтын эмчилгээг зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 1311 иргэн хамрагдсанаас эрэгтэй 504, эмэгтэй 807 иргэд байна. | |
| | 32 | 1.2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн олон талт арга хэмжээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, "Эрүүл мэндийг дэмжигч" төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, өрх гэр бүлийн тоог 2016 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ. -Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын холбоо"-ны үйл ажиллагаа тогтолжино. | Ажлын байранд эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын уулзалт ярилцлагыг 31 удаа зохион байгуулан мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажилласан. 2017 оны байдлаар "Улсын гэрчилгээ"-тэй эрүүл мэндийг дэмжигч байгууллага 3, Орон нутгийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага 21, Эрүүл мэндийг дэмжигч өрх 1840, Эрүүл мэндийг дэмжигч иргэн 3607 байна. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын болзлыг шинэчлэн 2017 оны 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 24 "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжигч төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд болзолт уралдаан өдөрлөг, уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил 13 удаа, сарын аян 10, уралдаан тэмцээн 4 удаа зохион байгуулсан. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэн, нийтийг хамарсан 36 арга хэмжээг зохион байгуулж, 6840 иргэнийг хамруулсан. "Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэн, төрийн болон төрийн бус 54 байгууллагуудтай "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулан, ажилтан албан хаагчдыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэн, зөв хандлага, дадал эзэмшүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. | 100 |
| | 33 | 1.2.1.6. "Эх хүүхдийн эрүүл мэнд" стратегийг | 2016-2020 | ЭМГ, ЭМБ-ууд | Улсын төсөв, | -Стратеги 90 хувиас дээш | Эх, нярайн эрүүл мэнд стратегийг орон нутагт хэрэгжүүлэн, төрөх эмэгтэйчүүд, нярайн эмч, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх | | | ОНХС, Хандив, туслам ж | хэрэгжсэн байна. -1000 амьд төрөлтөнд ноогдох нялхасны эндэгдлийн тохиолдлыг 2016 оны мөн үеэс 4 промилээр, амьгүй төрөлтийн тохиолдлыг 25 хувь, гэрийн төрөлтийн тохиолдлын тоог 50 хувь бууруулна. | эмнэлгийн мэргэжилтнүүдийг 5 удаагийн сургалтад хамруулж, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулснаар:<br>- Жирэмсний эрт үеийн хяналт 86.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3.5 хувиар өссөн.<br>- Амьгүй төрөлтийн тохиолдол бүртгэгдээгүй байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан.<br>- Перинаталь эндэгдлийн түвшин 2017 оны 10 дугаар сарын байдлаар 6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3-аар буурсан.<br>- Гэрийн төрөлт 4 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс нэгээр нэмэгдсэн.<br>- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зайн оношлогоог зүрх судас, эх нярайн чиглэлээр нэвтрүүлэн, үндэсний нарийн мэргэжлийн клиникүүдтэй хамтран ажиллаж, 15 өвчтөнд зөвлөгөө авч, ургийн гаж хөгжлийн 3 тохиолдлыг онлайнаар илрүүлсэн. | |
| ***/7/*** 1.2.2. Халдварт өвчний тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулна | 34 | 1.2.2.1. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг шат дараатай зохион байгуулж, өвчлөлийн түвшинг бууруулах | 2016-2020 | ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, туслам ж | -Эрт илрүүлгийн үзлэгийн хамралтыг 85 %-д хүргэнэ. Эдгэрэлтийн түвшинг 2016 оныхоос 3 %-иар нэмэгдүүлнэ. | Сүрьеэ өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сумын эмч нарын холбоо”-той хамтран нийт сумдын удирдлагууд, их, бага эмч, Нэгдсэн эмнэлэг, ЭМГ-ын холбогдох эмч, мэргэжилтэн 60 иргэнийг оролцуулсан сургалт зохион байгууллаа. Өвчлөлийг эрт илрүүлэх, эмчилгээний хяналтыг сайжруулах, онош баталгаажуулах сорьц тээвэрлэлтийн чанар, тоог нэмэгдүүлэн 145 сорьцыг мэргэжлийн дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Оношийн баталгаажилт 90%-д хүрлээ. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх “Туберкулины сорил”-д Эрүүл мэндийн байгууллагын 306 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсны 97.3% нь сөрөг гарсан байна. | 100 |
| | 35 | 1.2.2.2. Бэлгийн замаар дамжих халдвар, нэн ялангуа тэмбүү өвчнийг бууруулахад хавьтал судлалын ажлыг эрчимжүүлэх | 2017-2020 | ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, туслам ж | -Нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 20%-д | Аймгийн хэмжээнд 15-55 насны 3577 иргэнийг БЗДХ-ын илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулж, 235 тохиолдлыг шинээр илрүүлэн, 415 хавьтлыг судалгаанд хамруулан, эмчлэн эрүүлжүүлж байна. Глобаль сантай хамтран 16-40 насны 8000 иргэнийг БЗДХ илрүүлэх үзлэг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргэнэ. | шинжилгээнд хамруулах бэлтгэл ажлын хүрээнд сумдын 38 их эмч, лаборант нарыг сургалтад хамруулан, оношлуур, дагалдах хэрэгслээр хангасан. 2017 оны 11 дүгээр сарын 01-ээс үзлэг шинжилгээнд иргэдийг хамруулж эхлээд байна. | |
| | 36 | 1.2.2.3. "Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд" зарчмыг баримтлан, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөц хангамжийг сайжруулах | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Жил бүр 2 суманд бэлэн байдлын үзүүлэх сургууль хийж, сум бүрт салбар дундын баг байгуулна. | Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын салбар хоорондын мэдээ солилцох, хариу арга хэмжээ авах журам"-ын төслийн хэлэлцүүлэгт Зоонозын салбар зөвлөлийн гишүүд 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. ЗӨСҮТ болон Сэлэнгэ аймгийн ЗӨСҮТ-ийн салбар төвийн мэргэжилтнүүд орон нутагт ажиллаж, сумдын ЭМБ-уудын 120 гаруй мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан. ЭМГ-ын даргын 2017 оны А/15 дугаар тушаалаар халдварт өвчний голомтод ажиллах мэргэжлийн багийг шинэчлэн томилсон. Дашинчилэн, Сайхан сумуудад "Шувууны томуу өвчин"-ий үеийн бэлэн байдлыг ханган ажиллах талаар үзүүлэх сургалт зохион байгуулж, эмнэлэг дэлгэн ажиллуулах үйл ажиллагааг онцгой комиссын удирдлага штабын 11 гишүүн бэлэн байдлыг үзэж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Энэ үзүүлэх сургалтад сумын онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нийт 160 хүн оролцлоо. | 100 |
| | 37 | 1.2.2.4. Дамжуулагчаар дамжих халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, голомттой бүс нутагт тандалт судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, өвчлөлийн талаарх эргэн мэдээллийн тогтолцоог сайжруулах | 2016-2020 | ЭМГ, АНЭ, сумын ЗДТГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Голомттой бүс нутагт тандалт судалгаа хийгдсэн байна. | 2017 онд хачигт халдварын 1550 хүн тун вакциныг татан авч, голомттой бүс Бугат, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Тэшиг, Булган сум, Хялганат тосгоны Хилийн цэргийн анги, Хууль хяналтын байгууллага, Мэргэжлийн хяналтын газар, УЦУОШГазар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг байгууллага болон голомттой газрын нийт 1475 иргэдийг хачигт энцефалитаас сэргийлэх вакцинд хамруулаад байна. Халдварт өвчний мэдээлэлд дүгнэлт хийж, анхан шатны нэгжид 7 хоног тутмын мэдээллийг хүргүүлэн ажиллаж, халдварын голомттой Бугат суманд мэргэжлийн байгууллага тоошил хийсэн. Бугат суманд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сэлэнгэ аймгийн ЗӨСҮТ-тэй хамтран голомтын тандалт судалгааг зохион байгуулсан. Тандалт судалгааны үеэр голомтоос хачиг түүвэрлэж хүн амын дундах тархалтыг тогтоох зорилгоор 56 ийлдэс цуглуулсан. Хачгаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг тухай бүр боловсруулж, Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 6 удаагийн зөвлөмж хүргүүлсэн. Хачигт халдвараас сэргийлэх сурталчилгааны материалыг боловсруулан хүнсний зах, худаг, дэлгүүрүүдийн гадна байршуулсан бөгөөд хачигт халдвараас урьдчилан сэргийлэх мэдээллийг 2 байгууллагын мэдээллийн цагаар нийт 65 хүнд танилцуулсан. Хачигт халдвараас сэргийлье, хачиг биеэс авах арга зэрэг 4-н төрлийн видео сургалтын материалыг төв гудамжны мэдээллийн дэлгэцээр 7 хоногийн турш явуулсан. | |
| | 38 | 1.2.2.5. Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн дархлалын түвшинг үнэлж, дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2017-2018 | ЭМГ | Улсын төсөв, ОНХС | - Дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн дархлалын түвшин тогтоогдоно.<br>- ЭМБ-уудын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна. | ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын алба, аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран "Улаанбурхан-Улаануудˮ өвчний эсрэг дархлалын түвшин тогтоолгох судалгааг Булган сумын 6-р багийн 40 хүнээс авсан байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн ЭМБ-уудын 50%-д вакцин биобэлдмэлийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтэд дотоодын хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган, Бугат сумын вакцин хадгалах хөргөгчийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>ХӨСҮТ-ийн хөрөнгө оруулалтаар ЭМГ-ын хүйтэн хэлхээний өрөө, Баяннуур, Орхон сум, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийг вакцин, биобэлдмэл хадгалах хөргөгчөөр хангасан. Заавал хийх дархлаажуулалтын нэгжийн тоног, төхөөрөмжийн хангалт бүрэн шинэчлэгдсэн. | 100 |
| **/8/** 1.2.3. Өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт | 39 | 1.2.3.1. "Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг хэрэгжүүлэх | 2017-2020 | ЭМГ | Улсын төсөв, ОНХС, | -ИТХ-аар бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлсэн | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх "Аймгийн дэд хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 тоот тогтоолоор батлуулан ажиллаж байна. Уг хөтөлбөрт сум, өрхийн ЭМТ-ийг хөгжүүлэх стратеги бүрэн тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| болон уламжлалт анагаах ухааны аргыг хослуулан хөгжүүлж, тоног төхөөрөмжийг сайжруулна. | | | | | | байна. | | |
| | 40 | 1.2.3.2. Сум, багийн түвшинд “Аймгийн Засаг даргын нэрэмжит” нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулах | 2016-2020 | АЗДТГ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, | -Жил бүр орон нутгийн хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулна. | Аймгийн Засаг даргын нэрэмжит төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээг Тэшиг, Дашинчилэн, Могод, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Баяннуур, Бүрэгхангай Булган сумын иргэдэд дотор, мэдрэл, хүүхэд, эмэгтэйчүүд, эхо, нүд, шүд чиглэлээр 3501 иргэдийг үзлэгт хамруулж, өвчтэй илэрсэн иргэдийг шат дараатай эмчлэн эрүүлжүүлж байна. Төрийн албан хаагчдын сарын аяны хүрээнд төрийн захиргааны 19 байгууллагын 190 албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгууллаа. | 70 |
| | 41 | 1.2.3.3. Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлж, мэргэжилтэнүүдээр ханган, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | 2016-2020 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Эмийн бус эмчилгээний чанар сайжирна.<br>-Эмийн эмчилгээний зардал буурна.<br>-Бүх сумдыг уламжлалт анагаах ухааны эмчээр хангана. | Уламжлалт анагаах ухаан, нөхөн сэргээх тусламж үйлчилгээний чиглэлээр анхан шатны 11 эрүүл мэндийн байгууллагуудад 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. 2017 онд уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, бариа заслын чиглэлээр 3 эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Уламжлалт анагаах ухаан, нөхөн сэргээх тасаг нийт ЭМБ-уудыг мэргэжил арга зүйгээр ханган 7 нэр төрлийн эмийг эмчилгээнд хэрэглэж байна. | 70 |
| | 42 | 1.2.3.4. Сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын “Яаралтай тусламж”-ийн хэсгийг стандартын шаардлагад нийцүүлэн цогц байдлаар иж бүрэн зохион байгуулж, эрсдэлийн түвшинг бууруулах | 2016-2020 | НБХ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Хоног болоогүй нас баралт буурна. | Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудын хүлээн авах, яаралтай тусламжийн бэлэн байдалд үнэлгээг хийж яаралтай тусламжийн тасгийг стандартын дагуу зохион байгуулан, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашинаар хангасан. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт аймгийн хэмжээнд 95%, тоног төхөөрөмжийн хангалт 80%-тай байна. Сумын ЭМТ-үүд Яаралтай тусламж хариуцсан 1 эмчийг тусгайлан үүрэгжүүлж ажиллуулж байна. Сумын ЭМТ-үүдийн мэргэжилтнүүдийн яаралтай тусламж үзүүлэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор 16 сумыг хамруулсан 2 удаагийн бүсчилсэн сургалтыг нийт 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамруулан хийсэн. Сумын 16 ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн яаралтай тусламжийн мэдлэг, ур чадварыг үнэлэн, ажлын байран дээрх сургалтыг улиралд 1 удаа хийсэн. Сумдын Эрүүл мэндийн байгууллагуудад 2017 оны 10 дугаар сарын байдлаар хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 3 буюу 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| | 43 | 1.2.3.5. Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх | 2016-2020 | НБХ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Анхан шатны тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг оролцуулна. | Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 3 сувилал, 5 үүдэн эмнэлэг, 16 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2017 онд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чиглэлээр Баян-Агт суманд хүүхдийн нарийн мэргэжлийн хувийн хэвшлийн үүдэн эмнэлэг, Булган суманд шүд, эрүү нүүрний тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн үүдэн эмнэлэг, Баяннуур, Дашинчилэн сумдад хувийн хэвшлийн эмийн сан шинээр үйл ажиллагаа явуулж эхлээд байна. | 40 |
| **/9/** 1.2.4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ. | 44 | 1.2.4.1. Хоёрдахь шатлалын эмнэлгийн стандартын түвшинд мэргэжлийн байгууллагатай хамтран үнэлгээ хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнээр шат дараатай хангах | 2016-2020 | ЭМЯ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Стандартын хэрэгжилт 2016 оныхоос нэмэгдсэн байна.<br>-Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнээр 100 хувь хангагдсан байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалт 77 хувь, сувилагч 51 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 58.3 хувьтай байна. Сургалтын баазыг бэхжүүлж, сургалтын муляж /хүүхэд, том хүний/, төхөөрөмжөөр хангагдсан. Улсын МХЕГ-ын хамтарсан гүйцэтгэлийн хяналт шалгалтаар АНЭ "Бага эрсдэлтэй" үнэлэгдэн, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар нэмэгдсэн. 2 дахь шатлалын нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэхээр мэдрэл, гэмтэл, мэс засал, дүрс оношилгооны эмчийн үндсэн мэргэшлийн сургалтад их эмч нартай гэрээ байгуулан суралцууллаа. | 70 |
| | 45 | 1.2.4.2. "Яаралтай тусламжийн тасаг"-ийг стандартын түвшинд нийцүүлэн, нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх | 2016-2020 | НБХ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Хоног болоогүй нас баралт буурна. | "Яаралтай тусламжийн тасаг"-ийг стандартын түвшинд тохижуулан улсын төсвөөс 349.9 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж, тасагт нэн шаардлагатай 10 нэр төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон амилуулах тусламжийн иж бүрдлээр хангасан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зайн оношилгоог зүрх судас, эх нярайн чиглэлээр нэвтрүүлэн, үндэсний нарийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжлийн клиникүүдтэй хамтран ажиллаж, 15 өвчтөнд зөвлөгөө өгч, ургийн гаж хөгжлийн 3 тохиолдлыг онлайнаар илрүүлсэн. | |
| | 46 | 1.2.4.3. “Гемодиализын эмчилгээ”-г нэвтрүүлэх | 2016-2020 | НБХ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна. | Эрүүл мэндийн сайдын 2015 оны 112 тоот тушаалыг баримтлан аймгийн хэмжээнд 2 Гемодиализ эмчилгээний 2 аппаратаар бөөр орлуулах эмчилгээг нийт 21 өвчтөнд хийж АВ фистултай 8, графт судастай 1, тунель гуурстай 1 эмчлүүлэгч эмчилгээнд хамрагдсан ба судасны хүндрэл гараагүй байна. 273 удаагийн сеанс бүхий 1092 цагийн эмчилгээг чанартай хийж гүцэтгэсэн. Гемодиализ эмчилгээний талаар мэдээллийг иргэдэд тогтмол хийж, амбулаторийн үзлэгээр 367 иргэнд үйлчилж, бөөрний архаг дутагдалтай иргэдийг хяналтад авч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100 |
| | 47 | 1.2.4.4. “Дурангийн кабинет”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, Дурангийн мэс заслыг нэвтрүүлэх | 2016-2020 | НБХ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний чанар сайжирна.<br>-Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна. | Дурангийн мэс заслын нарийн мэргэжлийн эмч, сувилагчдыг төрийн санхүүжилтээр суралцуулж байна. “Дурангийн кабинет”-д 13 сая төгрөгийн дурангийн ариутгалын багаж, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн. | 70 |
| | 48 | 1.2.4.5. “Цусны төв”-ийг байгуулах. | 2016-2020 | ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Цусны донорыг 2 %-д хүргэнэ. | “Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5” хөтөлбөрийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн цусны төвийг байгуулан, ашиглалтад оруулж, нэн шаардлагатай 8 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. “Цусны салбар төв”-ийн лаборатори нь нийт суурин 10.5л, явуулын 15.0л цус цуглуулснаас 24.5л буюу 162 нэгж савлалт үйлдвэрлэлд тэнцсэн. Цуглуулсан цус, сийвэнгийн нэгж бүрийг ариун цэврийн болон чанарын хяналтын шинжилгээнд 100% хамруулсан. Хөлдөөсөн шинэ сийвэнд 8-р фактор тодорхойлж байна. Нийт 8 нэр төрлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 25.5л буюу 162 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж, эмчилгээнд 101 нэгж цус цусан бүтээгдэхүүн хийгдсэн. | |
| | 49 | 1.2.4.6. Донорын эгнээг өргөтгөх сайн үйлсийн аянг зохион байгуулж, хэвшүүлэх. | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ, төрийн болон төрийн бус байгууллага | Улс, ОНТөсөв | Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна. | Донорын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэн аймгийн УЗН-тэй хамтран Хутаг-Өндөр сумын Сум дундын эмнэлэг, Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль, Ус цаг уур орчны шинжилгээний газар, аймгийн Төв номын сан зэрэг албан байгууллагад донорын өдөрлөг зохион байгуулж, нийт 17 донор шинээр элсүүлэн, 12 литр цус бэлтгэж нөөцөлсөн. Сар бүрийн 3-нд цусаа бэлэглэх өдрийг тэмдэглэн, 5 байгууллагын 150 гаруй иргэнд сургалт зохион байгуулан, 34 донорт үзлэг хийж, 13 донороос цус авсан. Эмнэлгийн эмч, сувилагч нарт “Аюулгүй цус сэлбэлтийн талаар”, “ЭМС-ын 2017 оны А/03 тоот тушаал” сэдвээр сургалт 3 удаа зохион байгууллаа. | 100 |
| | 50 | 1.2.4.7. Эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайны оношилгоог нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 2016-2020 | НБХ, ЭМГ, АНЭ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын СДЭ-үүдэд алсын зайн оношлогоог нэвтрүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зайн оношилгоог зүрх судас, эх нярайн чиглэлээр нэвтрүүлэн, үндэсний нарийн мэргэжлийн клиникүүдтэй хамтран ажиллаж, 15 өвчтөнд зөвлөгөө өгч, ургийн гаж хөгжлийн 3 тохиолдлыг онлайнаар илрүүлсэн. Тэшиг сумaнд Солонгос улсын KOFIH, ДЭМБ-ын хамтарсан санхүүжилтээр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төсөл хэрэгжин эхо, зүрхний цахилгаан бичлэг, сахар, холестрины аппарат бусад оношлууруудын хамт өгсөн. Энэ төслийн хүрээнд зорилтот 18-45 насны 1800 иргэдийг эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулсан. Зүрх судасны кабинетаар нийт 2000 хүн үзлэгт хамрагдаж, алсын зайн оношилгоогоор нийт 28 өвчтөнийг оношлуулж, зүрхний хагалгааны асуудлыг шийдвэрлүүлж, 26 хүнийг зүрхний шигдээсийн хагалгаанд 3 үйлчлүүлэгчийг зүрхний хавхлаг солиулах, стиент тавиулах хагалгаанд оруулсан. Алсын зайн оношилгоогоор 10 аймгийн 24 өвчтөний материалыг судалж, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан. | |
| | 51 | 1.2.4.8. “Эмчилгээний хоолны газар”-ыг байгуулах | 2017-2020 | ЭМГ, АНЭ | 0.5 сая | -Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн стандарт хангагдана. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын урсгал засварыг хийснээс гадна, Туркын хамтын ажиллагааг зохицуулах агентлаг, Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулалтын газраас хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартаар 76.0 сая төгрөгийн их засварын ажлыг хийсэн. | 100 |
| | 52 | 1.2.4.9. “Уламжлалт анагаах ухааны төв”-ийг байгуулж, уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэх | 2016-2020 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | -Эмийн эмчилгээний зардал буурна.<br>-Нөхөн сэргээх эмчилгээний үр дүн сайжирна. | Уламжлалт анагаах ухааны төвийг хөгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “Эрүүл мэнд хөтөч” хөтөлбөрөөс 2.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 нэр төрлийн шаардлагатай тоног төхөөрөмж, эд зүйлсийг авч, уламжлалт, сэргээн засах эмчилгээний тасаг, ахмадын кабинетийг тохижуулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаториор 1452, тасагт 118 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. 2017 онд уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, бариа заслын чиглэлээр 3 эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулсан. | 40 |
| | 53 | 1.2.4.10. “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет”-ийг байгуулж, эрчүүдийн дунд тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах | 2016-2020 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, Хандив, тусламж | -Эрэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийн түвшинг 2016 оныхоо бууруулна. | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих сарын аяныг 3-р сард зохион байгуулан, 200 гаруй эрэгтэйчүүдийг нарийн мэргэжлийн үзлэгт хамруулсан. Эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчилгээний чиглэлээр Улаанбаатар хотын Гарьд магнай эмнэлэгтэй хамтран ажиллаж байна. | 40 |
| | 54 | 1.2.4.11. Лабораторийн чадавхийг сайжруулах | 2017-2018 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Стандартын хэрэгжилт сайжирна. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн тасгийг нэн шаардлагатай урвалж бодисоор бүрэн хангаж, Иммунологийн бүрэн автомат аппаратыг ашиглалтад оруулан оношилгооны нэр төрлийг 3-аар нэмэгдүүлсэн. Стандарт тоног төхөөрөмжийн хангалт 70 хувьтай байна. | 70 |
| **/10/** 1.2.5. Сувилахуйн тусламж үйлчилгээ, сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг аргуудыг | 55 | 1.2.5.1. Эрүүл мэндийн байгууллагуудад сувилгаа асаргааны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | 2016-2018 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, Хандив, тусламж | Сувилахуйн тусламж үйлчилгээнд жил бүр 2-3 шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. | Эх, хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний ээлтэй орчин бүрдүүлэх “Бүтээмж” 45 хоногийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Тус аяныг зохион байгуулснаар эх, хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, сайжруулан, эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн идэвхи санаачлага нэмэгдэж төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран 8 | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| нэвтрүүлнэ. | | | | | | | хүүхдийн өрөөг тохижуулж, 4 сувилагчийн пост, 3 Эрүүл мэндийн төвийн төрөх өрөөг шинэчлэн орчин үеийн загварт нийцүүлэн завсарласан. Хялганат тосгоны Эрүүл мэндийн төвийн хүлээн авах яаралтай тусламжийн өрөөг улсын стандартын жишигт нийцүүлэн зохион байгуулснаар Сувилахуй амьдрал төвөөс стандартын жишигт нийцсэн батламж олгосон. Ходоодны хаймсуур тавих, ходоодны хаймсуураар хооллох, хүчилтөрөгч өгөх, өвчтөний тэргэнцэр хэрэглэх, хүзүүний дасгал хийх үйлдлийн технологийн заавар, гарын авлагыг шинээр боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. | |
| | 56 | 1.2.5.2. “Туслах сувилагч”-ийг бэлтгэн, сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх, сэргээн засах, уламжлалт сувилгааг өргөжүүлэх | 2017-2020 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, Хандив, тусламж | Туслах сувилагчийн тоог 50 хувиар нэмэгдүүлнэ. Хөнгөвчлөх эмчилгээний удирдамжийн хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ. | Хөнгөвчлөх эмчилгээнд нийт 657 өвчтөн хамрагдсан. Шинэ оношлогдсон хавдрын тохиолдол 138, амбулаториор 583, стационариар 59 иргэн, гэрээр үзлэг хийсэн 15 өвчтөн байна. Улсын хэмжээнд туслах сувилагчийн ажлын байрны тодорхойлолт, цалингийн жишиг шинэчлэн батлагдаагүй байгаа тул нэмж туслах сувилагч бэлтгэх боломжгүй байна. Аймгийн хэмжээнд туслах сувилагчийн сургалтад хамрагдсан 33 ажилтан байна. | 40 |
| | 57 | 1.2.5.3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх “Өдрийн эмчилгээний төв”-ийг байгуулах | 2016-2020 | Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд | Улсын төсөв, Хандив, тусламж, НХҮХ | “Өдрийн эмчилгээний төв”-тэй болсон байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийг түшиглэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Өдрийн эмчилгээний өрөө”-г тохижуулан 10 дугаар сарын байдлаар 30 гаруй хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлж, эцэг эх асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулсан. Мөн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах” сарын аяныг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан, аймаг, сумын ЗДТГазартай хамтран тэдний эрүүл мэндийн боловсрол, нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлсэн олон арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулан ажилласан. Тус арга хэмжээний үеэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхэд, сэтгэцийн эмч нар | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө зөвлөмжийг өгч, эрүүл мэндийн сурталчилгааны материалыг тараан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг витаминжуулалтанд хамруулсан. | |
| **/11/** 1.2.6. Эм зүйн шинжлэх ухааны шинэ аргуудыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны эмчилгээнд нэвтрүүлнэ | 58 | 1.2.6.1. Эрүүл мэндийн байгууллагуудад эм зүйн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөн, эм зүйн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2016-2020 | ЭМГ, ЭМБ, ЭХБ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 90 хувьд хүрсэн байна. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмийн эргэлтийн сангуудад үнэлгээ хийсэн. Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж 88.5 хувьд хүрсэн. “Эмийн багваахай” эмийн сангийн эм зүйчийг “Эм зүйн албаны менежмент”-ийн 6 сарын курст суралцуулж мэргэшүүлсэн. “Мөнхийн тун” эмийн сан “Эмийн санд тавих нийтлэг шаардлага“ MNS 5260:2015 стандартад заагдсан тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 70 |
| | 59 | 1.2.6.2. Эм зүйн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн “Уламжлалт анагаах ухааны эмчилгээний эмийн сан”-г шинээр байгуулах | 2016-2020 | ЭМГ, ЭМБ, ЭХБ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Эм зүйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ. | Уламжлалт анагаах ухааны эмийг Улаанбаатар хотын эм ханган нийлүүлэх байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, эмээр ханган ажиллаж байна. Уламжлалт анагаах ухааны эмчилгээний эмийн санг нээх нээлттэй тендерийг зарлаад байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн УСЗТасагт хэвтэн эмчлүүлэх 6 оронд нийт 40 гаруй нэр төрлийн эм тангаар үйлчилж байна. Цаашид амбулаториор үйлчлүүлэгчид тан авах боломжтой гадуур эмийн сангийн борлуулалт шаардлагатай байдаг. | 40 |
| | 60 | 1.2.6.3. Орон нутагт хувийн хэвшлийн эмийн сангуудыг шинээр байгуулахад дэмжлэг үзүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох | 2017-2020 | НБХ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Эм зүйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ. | Дашинчилэн сумын “ШИЖҮД ФАРМ”, Баяннуур суманд “Юмка фарм” хувийн хэвшлийн эмийн сангуудад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг шинээр олгосон. | 70 |
| **/12/** 1.2.7. Эмнэлгийн мэргэжилтэнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах хүний нөөцийн хөгжлийн аймгийн бодлогыг тодорхойлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж | 61 | 1.2.7.1. “Булган аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв | Эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг 95.0 хувьд хүргэнэ. | Булган аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2017-2020 онд хөгжүүлэх бодлого”-ыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 42 тоот тогтоолоор батлуулсан. Бодлогыг 2017 онд хэрэгжүүлэх 26 зүйл заалт бүхий төлөвлөгөөг Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 79.6%-тай байна. Төлөвлөгөөнд тусгаснаар энэ онд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| халааг бэлтгэнэ | | | | | | | төрийн сангийн санхүүжилтээр суралцуулахаар салбарын 36 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулж, сургалтад элсүүлэн, 5 их эмчийг ажлын байрны солилцох сургалтад хамруулан сэлгэн ажиллуулсан. | |
| | 62 | 1.2.7.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараахь сургалтын чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ, ЭМБ-ууд | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Жилд 1-ээс доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагажуулна. | Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” мөрийн хөтөлбөрт тусгагдсан чиглэл, ЭМБ-уудын нэн тулгамдаж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 7 чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаадын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар захиалгыг ЭМХТ-д хүргүүлсэн. Гадаад улсад мэргэшүүлэх сургалтад чих, хамар хоолой, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2 төрийн албан хаагчийг суралцуулсан. | 40 |
| **/13/** 1.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулан, мэдээллийн технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 63 | 1.2.8.1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасаг, Баян-Агт, Баяннуур, Дашинчилэн, Хялганат, Гурванбулаг сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийх | 2016-2020 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв-56.2 сая ₮ | Иргэдэд ээлтэй орчин бүрдэж, сэтгэл ханамж нэмэгдэнэ | Эрүүл мэндийн сайдын багцаас орон нутагт эрх шилжиж ирснээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Мэс заслын тасаг”-ийн их засварыг 56.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж хүлээн авсан. 2018 онд Могод, Баяннуур, Гурванбулаг сумд, Хялганат тосгоны ЭМТ-үүдэд Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр их засвар хийлгэх саналыг хүргүүлсэн | 70 |
| | 64 | 1.2.8.2. Булган суманд 30 ортой халдварт Сүрьеэгийн тасаг, Орхон, Могод сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилгыг шинээр барих. | 2017-2020 | АЗДТГ, ГХБХБГ, ЭМГ | Улсын төсөв, ОНХС, Хандив, тусламж | Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгын тоо нэмэгдэнэ. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн 30 ортой эмнэлгийн зураг төсвийг боловсруулж, 2018 оны улсын төсөвт 975 сая төгрөгийн эх үүсвэр шийдэгдсэн. | 100 |
| | 65 | 1.2.8.3. Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартын шаардлагад нийцсэн орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх | 2017-2020 | АЗДТГ, ЭМГ | Улсын төсөв-3.6 сая ₮ | Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ. | 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн тэргэнцэр, УВЧ аппарат, хэт ягаан туяаны аппарат, хүчилтөрөгч, өтгөрүүлэгч, өвчтөний ор зэрэг нийт 97.6 сая, Дэлхийн зөн ОУБ-с 29.7 сая, бусад хандив тусламжаар 22.6 сая нийт 149.9 сая төгрөгийн 30 гаран нэр төрлийн техник, тоног төхөөрөмжөөр аймгийн Нэгдсэн эмнэлэг болон 16 сумын Эрүүл мэндийн байгууллагуудыг хангасан. | 70 |
| | 66 | 1.2.8.4. Бугат, Сэлэнгэ, | | АЗДТГ, | Улсын | Түргэн | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Могод, Хялганат, аймгийн Нэгдсэн эмнэлгийг яаралтай түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах | | ЭМГ | төсөв - 150.0 сая ₮ | тусламжийн автомашины парк шинэчлэлтийг 100 хувьд хүргэнэ. | Нэгдсэн эмнэлэг, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр сумдын "Сум дундын эмнэлэг", Дашинчилэн Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон, Баян-агт, Сэлэнгэ сумд, Хялганат тосгоны Эрүүл мэндийн байгууллагуудад 267.6 сая төгрөгийн үнэтэй түргэн тусламжийн автомашин нийлүүлэгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бугат, Могод сумдын Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 85.0 сая төгрөгийн үнэтэй эмнэлгийн түргэн тусламжийн автомашин нийлүүлэгдсэн. | |
| **1.3 Нийтийн биеийн тамир, спорт**<br>***Үндэсний спортын өв, соёл, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэлгэрүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгоно.*** | | | | | | | | |
| **/14/** 1.3.1. Тамирчдын хөгжих, уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд анхаарч, амжилт гаргах, алдаршуулахад бодлогоор дэмжиж ажиллана. | 67 | 1.3.1.1. Тамирчдын уралдаан тэмцээн, шагнал урамшуулал болон спортыг дэмжигч Аж ахуйн нэгж, холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ | Улс, ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр, Хандив, тусламж | Тамирчид, багш, дасгалжуулагчдын идэвх санаачлага дээшилж, амжилтын тоо ахисан байна. | 2017 онд тэмцээн уралдааны нэгдсэн график төлөвлөгөөний дагуу Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 14 төрлөөр, насанд хүрэгчдийн тэмцээнийг 7 төрлөөр, нийт 21 төрлөөр зохион байгуулж 2663, нийтийг хамарсан 10 арга хэмжээг зохион байгуулж 2176, нийт 4839, улсын аварга шалгаруулах тэмцээнд 1163 тамирчныг оролцуулж нийт 24.7 сая төгрөгийг спортын арга хэмжээний зардалд зарцуулсан байна. Сумдад спортын төрлүүдийг сурталчлан, хүүхэд залуучуудын спортоор хичээллэх сонирхлыг нь дэмжих зорилгоор аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 6 суманд хамтран зохион байгуулсан. Ази тивийн аварга, дэлхийн аварга, олон улс, улс, бүс, олон хотын тэмцээнүүдэд баг тамирчид нийт 43 удаагийн арга хэмжээнд оролцож алтан медаль 52, мөнгөн медаль 42, хүрэл 44 нийт 139 медаль хүртсэн амжилттай байна. Азийн аварга, дэлхийн аварга, олон улс, Улсын аварга болон бусад арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөцөөс 69.9 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Мөн 2017 онд Олимп, тив, дэлхийн аварга, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медальт байранд шалгарсан тамирчдын материалыг журмын дагуу бүрдүүлээд байна | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 68 | 1.3.1.2. Хүүхдийн, Ахмадын, Үндэсний спортын, Бүх ард түмний спортын наадмуудыг зохион байгуулах, улсын тэмцээнд тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ | Улс, ОНХС, Спорт холбоодын хөрөнгө оруулалт | Хүмүүсийн оролцоо нэмэгдэж амжилт сайжирсан байна. | Боксын залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2 хүрэл медаль хүртсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Raw classic пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 25 байгууллагын 385 тамирчдаас багийн дүнгээр I байр эзэллээ. Өсвөрийн гүйлтийн тэшүүрчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож алт 10, мөнгө 9, хүрэл медаль 8, нийт 27 медаль хүртэж багийн дүнгээр III байранд орсон. Самбо бөхийн Өсвөр үеийн УАШТэмцээнд 2 медаль, 4 шагналт байранд орж амжилттай оролцсон. Аймгийн Засаг даргын 2017 оны А/216 дугаар захирамжийн хүрээнд "Булган марафон-2017" хагас марафон гүйлтийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж тус тэмцээнд 50 байгууллага, 4 сум /Орхон, Тэшиг, Хангал, Сайхан/ Булган сумын хэмжээнд нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн нийт ажилтан ажиллагсдын 32.6 хувь, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 32.9 хувь буюу нийт 1167 тамирчин хамрагдсан байна. Булган аймгийн Тэшиг сумын харъяат Монгол улсын ардын багш, гавъяат дасгалжуулагч Д.Бандийн нэрэмжит бага насны улсын аварга шалгаруулах "Олимпийн гараа" боксын тэмцээнийг зохион байгуулж, 37 багийн 427 тамирчид оролцож, Булган аймаг тэргүүллээ. Мөн Ахмадын теннисний улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. | 70 |
| | 69 | 1.3.1.3. Үндэсний бөх, хурдан морь, сур, шагайн спортыг дэмжиж, улсын алдар цолтой хүмүүсийн нэрэмжит тэмцээнийг уламжлал болгон тогтмолжуулах, сурталчлах ажлыг үе шаттайгаар хийх | 2016-2020 | АЗДТГ, НБХ БТСГ, Спортын холбоод | ОНТөсөв, хөтөлбөр, Спорт холбоодын хөрөнгө оруулалт | Алдартнуудаа сурталчилж үндэсний спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. | Булган аймгаас төрөн гарсан алдар цолтой бөхчүүд болон тамирчдаа сурталчлан алдаршуулах зорилгоор нэрэмжит арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион явуулж байна. МУ-ын арслан **Б.Жамьяндоржийн нэрэмжит** үндэсний бөхийн барилдааныг 09 дүгээр сард Сайхан суманд зохион байгуулсан. Мөн МУ-ын Заан Н.Түвшинбаяр, МУ-ын начин Д.Тамир, Б.Бат-Эрдэнэ нарын "Цолны мялаалга наадам"-ыг хамтран зохион байгууллаа. Тэшиг сумын харъяат Монгол улсын ардын багш, гавъяат | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дасгалжуулагч Д.Бандийн нэрэмжит бага насны улсын аварга шалгаруулах “О**лимпийн гараа**” боксын тэмцээнийг улсын хэмжээнд зохион байгуулж **37** багийн **427** тамирчид оролцсон байна. Биеийн тамир, спортын байгууллага үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойн нэрэмжит Үндэсний бөх, Үндэсний сурын харваа, Волейбол, Сагсан бөмбөг, Шагайн харваан тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа. “**Монгол нум сум”** дэд хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлснээр сум болон сургуулиудад үндэсний спортын талаар сурталчлан, тэмцээн уралдаанд оролцогчдын тоо болон хичээллэгсдийн тоо нэмэгдэж байна. 2017 оны 10 дугаар сард аймгийн хэмжээнд “Отго харваа-2017” үндэсний сурын харвааны тэмцээнийг анх удаа зохион байгуулж, насанд хүрэгчид, хүүхэд нийт 34 харваач цэц мэргэнээ сорин өрсөлдлөө. Өвлийн улиралд 11 дүгээр сараас эхлэн Үндэсний сурын харвааны Заалны бэлтгэл оруулахаар хуваарийг гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд “**Шагайн харвааг**” хөгжүүлэх тал дээр анхааран дэмжин тусалж, БТСГ-ын “А” зааланд өрөө танхимтай болгож, Шагайн клуб байгуулан тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулж байна. Мөн аймгийн гоц мэргэн Д.Галбадрахаар 11 дүгээр сараас эхлэн ЕБС-ийн сурагчдын дунд Шагайн харвааны секц дугуйланг хичээллүүлэхээр төлөвлөгөөнд тусгаад байна | |
| | 70 | 1.3.1.4. Ерөнхий боловсролын сургуулиудад Олимпийн сургалт, сурталчилгааны танхимуудыг байгуулан, үзүүлэн таниулах материалаар үе шаттай хангах | 2016-2020 | АЗДТГ, НБХ БТСГ, ЕБС, “Москва” олимпийн зөвлөл | МҮОХо рооны Төсөл, хөтөлбөр | Хүүхдүүдийн спорт Олимпизмийн мэдлэг зохих түвшинд дээшилсэн байна. | Аймгийн хэмжээнд “Москва“ олимп судлалын төв үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 16 сум болон Булган сумын 4 сургуульд олимпийн сурталчилгааны танхим байгуулан үзүүлэн таниулах материалаар хангаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |
| ***/15/*** 1.3.2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх таатай орчин нөхцлийг | 71 | 1.3.2.1. Аймаг, сумын төвүүдийн гудамж, нийтийн эзэмшлийн талбайд ахмад настан, | 2016-2020 | АЗДТГ, НБХ, Булган СЗДТГ | ОНХС | Ард иргэдийн нийтийн биеийн тамираар | Аймгийн хэмжээнд орон сууц болон багуудын гадаа талбайд хүүхэд, залуучуудад зориулсан тоглоом, спортын талбайг сум, орон нутгийн төсвөөр байгуулаад байна. Мөн Хүүхэд, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| бүрдүүлнэ. | | хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудад зориулсан ногоон байгууламж бүхий гүйлт, дугуйн зам, спорт тоглоом, мөсөн гулгуурын талбай байгуулах ажлыг эхлүүлэх | | ГХБХБГ БТСГ | | чөлөөтэй хичээллэх боломж бүрдсэн байна. | залуучууд, иргэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэмцээн уралдааныг зохион байгуулах тал дээр анхаарч жил бүр өвлийн улиралд өөрсдийн хүчээр Төв цэнгэлдэх хүрээлэнд 400 метрийн мөсөн гулгуурын талбайг байгуулан олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулж байна. Булган аймгийн Сагсан бөмбөгийн холбоотой хамтран Булган суманд сагсан бөмбөгийн талбайг байгуулахаар зураг төсөв хийгдэж байна. Хүүхэд, залуучуудын паркын тохижилтын хүрээнд 1-р үе шатны бүтээн байгуулалтын ажлыг аймгийн 80 жилийн ойг угтан хийхээр 2018 оны ОНТ-т тусгаад байна. | |
| | 72 | 1.3.2.2. Хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, эрүүл амьдралын дадал, хэвшилд сургах чиглэл бүхий нийтийн биеийн тамирын сайн дурын танхим, клуб, хамтлагуудыг дэмжиж ажиллах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, Агентлагийн удирдлага, СЗДТГ | Улс, ОНХС | Албан байгууллагын ажиллагсдын идэвх санаачлага нэмэгдэж эрүүл амьдралын дадал, хэв маяг хэвшсэн байна. | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын даргын А/82 дугаар тушаалаар "Хамтлаг байгуулах дүрэм" шинэчлэгдсэнтэй холбогдуулан сум байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дүрэм журмыг хүргүүлэн спортын хамтлагуудыг байгуулсан. Сум болон байгууллагуудын орон тооны бус арга зүйч, биеийн тамирын багш нарт Спортын хамтлаг байгуулах, сорил судалгааг авах аргачлал, холбогдох хууль, тогтоомжуудын талаарх сургалтыг зохион байгуулан 14 сум, 18 байгууллагын 40 хүн хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд одоогоор 50 гаруй спортын хамтлаг байгуулагдаад байна. Байгууллага, аж ахуйн нэгж, сургууль, цэцэрлэгүүдэд бие бялдраа хөгжүүлэх, эрүүлжин чийрэгжих, эрүүл мэндээ дэмжин хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа явуулж спортоор хичээллэх орчин нөхцлийг нь бүрдүүлэн ажиллаж байна. Усан спорт сургалтын төв байгуулагдсанаар фитнессээр 132, усан спортоор хичээллэгсдийн тоо 2017 онд давхардсан тоогоор нийт 749 болсон байна. Фитнессийн танхим нь сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, ямар ч насны хүн хичээллэх орчин нөхцлөөр бүрэн хангагдсан. | 100 |
| **/16/** 1.3.3. Спортын | 73 | | 2016- | АЗДТГ, | Аймаг, | Эрийн гурван | "Монгол нум сум" дэд хөтөлбөрийг аймгийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| тодорхой төрлүүдийг /үндэсний сур, цана, тэшүүр, бөхийн төрлүүд, волейбол, хөнгөн атлетик, бокс, буудлага, таеквандо, сагсан бөмбөг г.м/ түлхүү хөгжүүлнэ. | | 1.3.3.1. Үндэсний наадгай сур харвааг хөгжүүлэх зорилгоор “Монгол нум сум” хөтөлбөр хэрэгжүүлэх | 2020 | НБХ, БТСГ, БСУГ | ОНТөсө в | наадмын нэг үндэсний наадгай сурын харвааг хөгжүүлж, хичээллэгсди йн тоо нэмэгдсэн байна. | ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 19 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд үндэсний сурын харвааны сумдын сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтыг 2017 оны 04 дүгээр сард зохион явуулж 40 сургагч багш бэлтгэгдсэн. Бүх сумдад ажлын хэсгийг байгуулж, ихэнх сум наадмаараа “Үндэсний сурын харваа”-ны тэмцээнийг зохион байгууллаа. 2017 оны аймгийн баяр наадмаар сургалтын нумаар харвуулж тэмцээнийг өргөн хүрээтэй явуулж түрүүлсэн харваач нарт “Аймгийн мэргэн”-ий тэмдэг, үнэмлэхийг олгож эхлээд байна. Мөн сонирхогчдын дунд сургалтыг явуулж, тэмцээн уралдааныг зохион байгуулснаар сонирхон хичээллэгсдийн тоо аймгийн хэмжээнд 400 гаруй болсон байна. “Монгол нум сум” дэд хөтөлбөрийн хүрээнд сум бүрт 2ш нум, 10 сум, БТСГазарт 4ш нум, СДС-1 , ЭӨЦС-1, 1-р сургуульд-1 нумыг сумны хамт гардуулсан. Монголын үндэсний сурын холбооноос хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт Булган аймгийн Үндэсний сурын холбоо хамрагдаж сумдуудыг хэрэглэл материал, гарын авлага, сургалтаар ханган ажиллаж байна. Булган аймгийн ҮСХ-ноос 8 суманд 10.8 сая төгрөгийн өртөг бүхий /Могод, Сэлэнгэ, Орхон, Гурванбулаг, Хутаг-Өндөр, Бугат, Хангал, Булган сум/ хэрэглэл материалыг хүлээлгэж өгсөн. Аймгийн хэмжээнд сурын холбоотой хамтран өвлийн улиралд заалны үндэсний сурын харвааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| | 74 | 1.3.3.2. Шагай харвааг хөгжүүлэхийн зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх холбоо, багуудыг дэмжиж ажиллах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ | Аймаг, ОНТөсө в | Шагай харвааг хөгжүүлж, хичээллэгсди йн тоог нэмэгдүүлж, Хангинахын шугуйн шагайн тойрмын хамрах | Аймгийн хэмжээнд БТСГ-ын “А” зааланд өрөө танхим гарган өгч “Шагайн харваа”-г хичээллэх, спортын тэмцээн уралдаан явуулах орчин нөхцөлийг нь бүрдүүлэн хамтран ажиллаж байна. Нэрэмжит тэмцээн болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг хуваарь, төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж хичээллэгсдийн тоо нэмэгдсэн. Аймгийн Шагайн холбоо, БОАЖГ-тай хамтран “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг 4 дэх жилдээ уламжлал болгон амжилттай зохион байгуулж, | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээг тэлж улмаар жуулчдын анхаарлыг татсан эвент арга хэмжээ болгосон байна | 28 багийн 200 гаруй шагайчид цэц мэргэнээ сорилоо. Мөн “Мөсний шагай”-н харвааг хөгжүүлэн, дэлгэрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд анх удаа “Мөсний шагай-2017” тэмцээнийг Тэшиг суманд зохион байгуулж, 20 багийн 40 харваачид оролцсон байна. БТСГ үүсч хөгжсөний 70 жилийн ойд зориулан шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулан 6 багийн 50 гаруй шагайчид оролцлоо. | |
| | 75 | 1.3.3.3. Цана, тэшүүр, бөхийн төрлүүд /самбо, жудо, чөлөөт, үндэсний бөх г.м / гар бөмбөг, сагсан бөмбөг, бокс, буудлага, хөнгөн атлетик, таеквандо, ширээний теннис зэрэг спортыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр дэмжих | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БТСГ, Спортын холбоод | ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Орон нутгийн брэнд төрлүүд болон хөгжсөн байна. | Өсвөрийн шигшээ багийг спортын 11 төрлөөр байгуулан, хэрэглэл материал, заал талбайгаар хангаж, дасгалжуулагч багш нарыг спортын төрлийн дагуу сургалтад хамруулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөгөө боловсруулан, секц дугуйланг хичээллүүлж байна. 2017 онд баг тамирчид Азийн аварга, олон улс, улс, бүс, олон хотын тэмцээн уралдаанд амжилттай оролцсон байна. 2017 онд боксын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн, мөн ахмадын ширээний теннисчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг орон нутагтаа амжилттай зохион байгууллаа. | 100 |
| **/17/** 1.3.4. Спортын салбарын материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | 76 | 1.3.4.1. Спортын шинэ ордны дээвэр, халаалтын иж бүрэн засварыг хийж гүйцэтгэх | 2016-2020 | БСШУСЯ АЗДТГ, НБХ, БТСГ | “Авзага трейд” ХХК-ийн санхүүжилт | Улсын комисс хүлээн авсан акт гаргуулсан байна. | ГХБХБ-ын газраас холбогдох мэргэжилтнүүд газар дээр нь ирж танилцан зургийн даалгавар хийгдэж зургийн даалгаврын дагуу 774.5 сая төгрөгийн зураг төсөв хийгдсэн. 2018 оны улсын төсөвт 524.5 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдэгдсэн. | 100 |
| | 77 | 1.3.4.2. Хялганат тосгоны спорт заалыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хангах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, СЗДТГ | Улс, ОНХС | Хялганат тосгоны ард иргэд нийтийн биеийн тамираар хичээллэх таатай орчин нөхцөлтэй болсон байна. | 1.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Хялганат тосгоны сургуулийн спорт заалын бүтээн байгуулалтад улсын төсвөөс 2017 онд 296.6 сая төгрөгийн хөрөнгө шийдэгдэж ашиглалтад орсон. Цаашид хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 3 хүний орон тоо, урсгал зардлыг шийдүүлэхээр 2018 оны төсөвт саналаа хүргүүлээд байна. | 100 |
| | 78 | 1.3.4.3. Спортын ордны Б заалны их засварыг хийх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, | ОНХС | Орчин, нөхцөл | Спортын “Б” зааланд урсгал засварыг хийж спортын секц, дугуйлан хичээллэх, тэмцээн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | СЗДТ | | сайжирсан байна. | уралдаан явуулах, тамирчдын хичээллэх тав тухтай орчин нөхцөлийг нь бүрдүүлэн ажиллаж байна. Гадна талбайд шинээр хайс хийн талбайг цементлэн гадна, дотор пасадыг хийж заал, өрөөнүүдэд иж бүрэн засвар хийлээ. Мөн хяналтын камер суурилуулан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Урсгал засварт нийт 9.2 сая төгрөгийг зарцуулсан. | |
| | 79 | 1.3.4.4. Спортын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттай нэмэгдүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, СЗДТ | Улс, ОНХС | Спортын секцүүдийн үйл ажиллагаа сайжирч, хичээллэгсдийн тоо өсч, спортод гаргах амжилт ахисан байна. | Бокс, таеквондо, сагсан бөмбөг, волейбол, усан спорт, фитнесс зэрэг спортын төрлүүдэд шинээр 3.1 сая төгрөгний тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг авч тамирчдын хичээллэх орчин нөхцөлийг сайжруулсан. "Монгол нум сум" хөтөлбөрийн хүрээнд бүх сум, сургуулиудад 2 ширхэг нум сумыг хүлээлгэж өглөө. Монголын үндэсний сурын холбооноос хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт Булган аймгийн Үндэсний сурын холбоо хамрагдаж эхний 8 суманд нум 4ш, сум 20ш, агсуурга 2ш, эрхийвч 5ш, хасаа 1 ком, гарын авлага 4ш, нийт 1 суманд 1350000 төгрөг, нийт 8 суманд 10.8 сая төгрөгний хэрэглэл материалыг өгсөн. | 100 |
| **1.4 Соёл, урлаг**<br>***Үндэсний өв уламжлал, орчин үеийн дэвшилтэт соёлыг шингээсэн иргэдийг төлөвшүүлж, урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэн, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ.*** | | | | | | | | |
| **/18/** 1.4.1. Соёл урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээг шинэ шатанд гаргаж, Соёл урлагийн ажилтнуудыг сургах, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулах, мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлнэ. | 80 | 1.4.1.1. Аймгийн "Соёл, урлагийн бодлого"-ыг боловсруулж, хэрэгжүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ | ОНТөсөв | Соёл, урлагийн бодлого хэрэгжиж орон нутгийн түвшинд соёлын чиг хандлага тодорхойлогдож, соёл урлагийн үйлчилгээ шинэ шатанд хүрсэн байна | 2016-2020 онд хэрэгжүүлэх "Соёлын бодлого"-ыг боловсруулахад холбогдох соёл урлагийн байгууллагуудаас санал авч, 16 сум 1 тосгоны иргэний танхимаар хэлэлцүүлсэн. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 45 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү бодлогын баримт бичгийн чиг хандлага нь үндэсний уламжлал өв соёлоо дээдлэн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, соёл урлагийн салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангахад оршиж байна. Соёл урлагийн байгууллагуудын боловсон хүчний хангалт 2016 онд 44 хувьтай байсан бол 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 53 хувьтай болж нэг жилийн хугацаанд 9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| | 81 | 1.4.1.2. Сумдын соёл, | 2016- | АЗДТГ, | ОНТөсө | Сум, орон | Булган сумын Соёлын ордон соёл урлагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | урлагийн өдрүүдийг тогтмол зохион байгуулж, урлаг соёлын үйлчилгээ, эд өлгийн зүйл, сум орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргах | 2020 | НБХ, БСУГ Сумдын ЗДТГ | в | нутгийн бусдаасаа ялгарах онцлогийг харуулж, орон нутгаа сурталчлах, сумдын соёлын брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлно. | өдрүүдийг зохион байгуулах ажлын хүрээнд “Булган хотын хавар” урлагийн наадмыг зохион байгуулсан. Мөн аймгийн “Ардын урлагийн их наадам”-д соёлын төвүүд үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж, сум, орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэн дэлгэн толилууллаа. | |
| | 82 | 1.4.1.3. Аймгийн “Ардын урлагийн наадам”-ыг 2 жил тутам зохион байгуулж, шилдэг уран бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгох | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ | ОНТөсөв | Булган нутгийн уран бүтээлчдийн бүтээл олон нийтэд танигдсан байна. | Аймгийн “Ардын урлагийн наадам”-ын эхний шатны шалгаруулалтыг сумын хэмжээнд 10 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 2 дугаар шатны шалгаруулалтыг 2017 оны 11 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус наадамд 16 сум 1 тосгоны нийт 356 ардын авьяастнууд, 10 төрлөөр оролцсоноос багийн дүнгээр Булган сум 1-р байр, Хялганат тосгон 2-р байр, Хутаг-Өндөр сум 3-р байрыг тус тус эзэллээ. | 100 |
| | 83 | 1.4.1.4. Амьд хөгжмийг сурталчлах, дэлгэрүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, Булган СЗДТГ, Булган сумын Соёлын ордон | ОНТөсөв | Амьд хөгжмөөр хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. | Булган сумын Соёлын ордоны хөгжмийн багш амьд хөгжмийн сургалтыг Хялганат тосгонд шат дараатай зохион байгуулж, одоогоор 3 хамтлаг байгуулаад байна. Мөн Булган сумын Соёлын ордоны дэргэд амьд хөгжмийн дугуйлан тогтмол хичээллэж байна. | 70 |
| | 84 | 1.4.1.5. Гадаад улсын Элчин сайдын яамдтай хамтран, тухайн орны урлаг, соёл, кино өдрүүд зохион байгуулах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ Булган СЗДТГ, Булган сумын Соёлын ордон | ОНТөсөв | Соёлын үйлчилгээний төрөл, чанар нэмэгдэнэ. | Өвөр Монголын Бугат хоттой харилцан соёл урлагийн өдрүүд арга хэмжээг зохион байгуулах талаар зөвшилцөж байна. | 40 |
| **/19/** 1.4.2. Соёлын | 85 | 1.4.2.1. ХЖТ, аймгийн | 2016- | АЗДТГ, | Улс, | Аймгийн | Номын сангийн өргөтгөлийн барилгын зураг | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, зарим сумдын Соёлын төвүүдийг шинээр барих, их засвар хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлнэ. | | Төв номын сангийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэх | 2020 | НБХ, БСУГ | ОНТөсөв | Хөгжимт жүжгийн театр, Номын сан орчин үеийн стандартад нийцсэн барилгатай болж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үйлчилгээнд чанарын ахиц гарсан байна. | төсвийг Улаанбаатар хотын “Өрх” ХХК-иар 800.000 төгрөгөөр шинэчлэн хийлгүүлсэн. Номын сангийн дээврийн төмрийг 3.4 сая төгрөгөөр шинэчилсэн.<br>Аймгийн Хөгжимт жүжгийн театрын шинэ барилгад 40 сая төгрөгийн урсгал засвар хийгдэж, шинэ театр барих асуудлаар холбогдох яамдад саналаа хүргүүлж, зураг төсөв хийлгэх хөрөнгийг 2018 оны төсвийн төсөлд тусгуулаад байна. | |
| | 86 | 1.4.2.2. Аймгийн музейн барилгад өргөтгөл, шинэчлэл хийж, Баруун замын тусгай ангийн штаб-музейн барилга, Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхныг засварлаж, тохижуулах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей | Улс, ОНТөсөв | Музейн үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдэж үйлчлүүлэгчдийн тоо эрс нэмэгдсэн байна. | Аймгийн 80 жилийн ойг угтаж музейн барилгад дээвэр болон хана, таазны засварыг хийхэд 72.8 сая төгрөгийн тооцоо судалгааг гаргаад байна. | 40 |
| | 87 | 1.4.2.3. Баяннуур сумын “Шороон бумбагар”-ын бунхант булш, ханын зургийг хамгаалах сэргээн засварлах, Баян-Агт сумын Шивээт-Улааны түүхийн дурсгалт газрыг аялал жуулчлалын төв болгох | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ Аймгийн музей | Улс, ОНТөсөв | Түүх соёлын үнэт олдворыг олон нийтэд таниулж, орон нутгаа сурталчилсан байна. | Баяннуур сумын Майхан уулын “Шороон бумбагар”-ын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах ажил БСШУСЯ, Соёлын өвийн төвийн удирдлага Туркийн олон улсын ТИКА байгууллагын дэмжлэгтэйгээр хийгдэж байна.<br>Баян-Агт сумын Шивээт-Улааны түүхийн дурсгалт газрыг аялал жуулчлалын төв болгох чиглэлээр тодорхой саналуудыг Турк улсад суугаа элчин сайдын яам болон бусад холбогдох газартай хамтран ажиллахаар саналаа уламжлаад байна. | 70 |
| | 88 | 1.4.2.4. Хялганат тосгон, Баяннуур, Могод, Гурванбулаг, Хангал, Бугат, Хутаг-Өндөр сумдын соёлын төвд их засвар хийх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ | Улс, ОНТөсөв | Соёл, урлагийн үйлчилгээг таатай орчинд хүргэж, | Могод сумын Соёлын төвийн барилгын их засварыг улсын төсвийн 140.0 сая, орон нутгийн 70 сая, нийт 210.0 сая төгрөгийн өртгөөр Улаанбаатар хотын “Элэг бүс” ХХК-иар гүйцэтгүүлж, хүлээн авсан. Баяннуур, Гурванбулаг сумдын соёлын төвийн дээврийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна | засварыг Боловсрол, соёл урлагийн газар болон орон нутгийн төсвөөс 23.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж хийлгэлээ. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн халаалтын системийг 16.0 сая төгрөгөөр шинэчиллээ. | |
| | 89 | 1.4.2.5. ХЖТ, Номын сан, Соёлын төвүүдийг камержуулах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, АТНС | Улс, ОНТөсөв | Аюулгүй орчинг бүрдүүлсэн байна. | Аймгийн ХЖТ, Номын санг 2017 онд багтаан камержуулах ажил хийгдэнэ. Харин соёлын төвүүдийг ирэх онуудад шат дараатай камержуулахаар төлөвлөөд байна. | 40 |
| | 90 | 1.4.2.6. Соёлын төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр үе шаттайгаар хангах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ | Улс, ОНТөсөв | Сумдын соёл, урлагийн үйлчилгээ чанаржиж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна. | Соёл урлагийн байгууллагад нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн судалгааг гарган нэгтгэж, үе шаттайгаар зохион байгуулж байна. Аймгийн ХЖТеатр, Булган сумын Соёлын Ордон, Төв Номын сан, Рашаант сумын Соёлын төв, Хангал сумын Соёлын төвд тус бүр нэг, нийт 5 notebook 1-р улиралд олгосон. Мөн аймгийн Хөгжимт жүжгийн театрт мэргэжлийн мастер морин хуур 2 ш, Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуульд 2.1 сая төгрөгийн өртөгтэй их хуур 1 ш тус тус олгоод байна. | 100 |
| | 91 | 1.4.2.7. Сумын номын сангуудад интернэт үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ | Улс, ОНТөсөв | Үйлчилгээний таатай орчин бүрдсэн байна. | Сумын номын сангуудад интернет үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг бүрэн хийсэн хэдий ч, зарим сумдад интернетийн хурдыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. | 70 |
| ***/20/*** 1.4.3. Үндэсний уламжлал, өв соёлыг дэлгэрүүлж, музейн үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалын зүйлсийг хамгаалах, үзмэрийг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна. | 92 | 1.4.3.1. Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт, тохижилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэн, байнгын арчилгаатай болгох | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей | ОНТөсөв | Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт сайжирсан байна. | Сумдад жилд 2-оос доошгүй Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хашиж хамгаалах шаардлага, чиглэл хүргүүлэн ажиллаж байна. | 40 |
| | 93 | 1.4.3.2. “Уртын дуу, Морин хуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Уран нугаралт”-ыг сурталчлан, дэлгэрүүлэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ | ОНТөсөв | “Уртын дуу, Морин хуур” хөтөлбөр амжилттай хэрэгжиж хичээллэгсди | “Уртын дуу-Морин хуур” аймгийн дэд хөтөлбөрийн төслийг сум, орон нутгийн иргэний танхимаар хэлэлцүүлэн, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 46 дугаар тогтоолоор батлуулсан. Уртын дууны сургагч | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | йн тоо нэмэгдсэн байна. Уран нугаралтаар хичээллэгсэдтэй болсон байна. | багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, сургалтаар 20 сургагч багш бэлтгэгдлээ. Орхон, Хангал, Сайхан сумдад 2 дахь шатны сургалтыг зохион байгуулсан. Сумдад уртын дууны сургалтыг тогтмол хичээллүүлж одоогоор 115, морин хуурын сургалтад 338 суралцагч хамрагдаж байна. Сумдын морин хуурын сургагч багш нарын ур чадварыг дээшлүүлэх, аймгийн 80 жилийн ойн нээлт, хүндэтгэлийн концерт зэрэгт тоглогдох бүтээлүүдийг вакумжуулсан орчинд, түргэвчилсэн хэлбэрээр 2017 оны 11 дүгээр сарын 03-08-ны өдрүүдэд Хөгжимт жүжгийн театрт зохион байгууллаа. Тус сургалтад 15 сум, 1 тосгон, аймгийн төвийн сургуулиудын гээд нийт 21 сургагч багш нар хамрагдлаа. Мөн аймгийн Хөгжимт жүжгийн театрт уртын дууны дугуйлан 7 хоногийн 3 өдөр тогтмол хичээллэж эхлээд байна. Булган сумын Соёлын ордоны дэргэд уран нугаралтын дугуйлан хичээллүүлж 25 хүүхэд тогтмол хамрагдаж байна. Уран нугаралтын дугуйлангийн сурагчид Дундговь аймагт зохион байгуулагдсан “Өсвөрийн циркчдийн 3-р уралдаан”-д оролцож тусгай байрыг эзэлсэн амжилт үзүүлээд байна. | |
| | 94 | 1.4.3.3. Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей | ОНТөсөв | Нэгдсэн санд бүртгэсэн байна. | Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах зардал 3.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулаад байна. Соёлын биет бус өвийн улсын үзлэг, тооллого явуулах тухай нэгдсэн сургалт хийгдээгүй байна. Сургалт хийгдэж, чиглэл ирэхээр тооллогын ажил эхлэхэд бэлэн байна. | 70 |
| | 95 | 1.4.3.4. Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей | ОНТөсөв | Түүх соёлоо олон улсад сурталчлах таатай боломж бүрдсэн байна. | Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн танилцуулгыг гадаад хэл дээр хэвлэхээр эхийг бэлэн болгосон. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | танилцуулга /Монгол, Орос, Англи хэлээр/ хэвлэж сурталчлах | | | | | | |
| **/21/** 1.4.4. Номын фонд баяжилтыг нэмэгдүүлж, сумдын номын сангуудын орчин нөхцлийг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 96 | 1.4.4.1. Бүх нийтээр ном унших хөдөлгөөн өрнүүлэн, “Нүүдлийн номын сан”-гийн үйлчилгээг эрчимжүүлэх хөдөөгийн багт хувиараа номын сан байгуулах иргэдийг дэмжих | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ АТНС | ОНТөсөв | Ард иргэдийг номтой нөхөрлүүлэх ажил эрчимжиж ном уншигчдын тоо нэмэгдсэн байна. | Явуулын номын сангийн үйлчилгээг 11 байгууллагад 15 удаа хүргэж, 550 номоор үйлчиллээ. 2017 оны 05 дугаар сарын 26-нд “Номын нээлттэй өдөрлөг”-ийг Цогт хун тайжийн задгай талбайд уншигч, иргэд, хүүхэд багачуудын дунд зохион байгууллаа. Идэвхтэн уншигчдаа шалгаруулах, “Ном хандивлах аян”, Ном солилцох булан, “Гэр бүлээрээ ном унших цаг” шинэ үйлчилгээний танилцуулга, 11 төрлийн шинжлэх ухааны номын үзэсгэлэн /800 гаруй номоор/ зэргийг гарган ажиллалаа. Мөн гэрээр ном олгох үйлчилгээ, хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн, шинэ номын худалдаа, санал хүсэлтийн дэвтэр ажиллуулах, монгол ардын тоглоом наадгай сурталчлах булан, “Чанга уншлага” бага ангийн сурагчдын үзүүлэх тоглолт, хамгийн жижиг ном, хамгийн том ном, хамгийн их элэгдсэн номыг танилцуулах буланг ажиллуулж, хүүхдийн зохиолч Ц.Чинбатын нэрэмжит “Миний хайртай үлгэрийн баатрууд” дүрийн тоглолт, “Ц.Чинбатын шүлгийг хэн сайн мэдэх вэ?” уран уншлага, дууны тэмцээнийг өдөрлөгийн үеэр зохион байгуулж энэхүү үйл ажиллагаанд 1000 гаруй хүн оролцлоо. Булган сумын 2, 6-р багийн “Багийн хөгжлийн төв”-д “Явуулын номын сан”-ийн үйлчилгээг 14 хоногийн хугацаатай ажиллуулсан. МУ-ын Ерөнхийлөгчийн “Номын баяр тэмдэглэх” тухай 158-р зарлиг, аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч”, “Оюунлаг Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхэд залуучууд, ард иргэдийг номтой нөхөрлүүлэх зорилгоор 6 дахь удаагийн намрын ”Номын баяр”-ыг зохион байгууллаа. | 100 |
| | 97 | | 2016-2020 | АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ | Улс, ОНТөсөв | Уншигчдын тоо болон номын фонд баяжилтыг нэмэгдүүлсэн | 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан санхүүжилтээр 16 сум 1 тосгоны номын санд тус бүр 250.000 төгрөгний, АТНС-д 750.000 төгрөгний үнэ бүхий номоор фонд баяжилт хийгдлээ. БСШУСЯ-тай хамтран сум тус бүрт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.4.2. Аймаг, сумдын номын сангийн фонд баяжилтыг үе шаттайгаар хангах | | | | байна. | 1.0, аймгийн Төв номын санд 3.0 сая төгрөгөөр номын фонд баяжилт хийсэн. Улаанбаатар хотод бүх сум, сургуулийн номын санчдыг сургалтад хамруулж, энэ үеэр сумын номын санчид өөрсдийн номын санд нэн түрүүнд бүрдүүлэх хэрэгтэй байгаа номнуудаа сонгон авсан нь уншигчдынхаа эрэлт хэрэгцээг мэддэг номын санчдын талархлыг хүлээсэн ажил боллоо. Номын фонд баяжилтыг үе шаттайгаар нэмэгдүүлэхийн тулд Улаанбаатар хотын “OPEN MIND LLC” ТББ-тэй хамтран “Ном хандивлах 3 сарын аян” өрнүүлэн ажиллалаа. Мөн Булган сумын 11 хүн 92 ширхэг ном бэлэглээд байна. Уншигчдын тоо 4 танхимаар 1187 уншигч, 11853 иргэсдэд 15872 ном хэвлэл олгож үйлчиллээ. Лавлагаа номзүй, мэдээллийг уншлага үйлчилгээний танхимуудаар амаар, бичгээр, имэйл хаяг, утас, интернэт сүлжээн дэх нүүр хуудсаар дамжуулан 2926 иргэдэд хүргэлээ. | |
| **<u>1.5 Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал:</u>**<br>***Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоход бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.*** | | | | | | | |
| ***/22/*** 1.5.1. Аймгийн нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулан шинэ залуу боловсон хүчнийг дэмжих, төгсөгчдийг ажлын байраар хангасан хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 98 | 1.5.1.1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, МСҮТ, их дээд сургууль төгсөгчдийн судалгааг гарган, нэгтгэн мэдээллийн сан үүсгэх | 2016-2020 | АЗДТГ, НБХ, ХХҮГ, БСУГ, СЗДТГ | - | Мэдээллийн сан үүсгэн, салбар дундын хамтын ажиллагаанд ашигласан байна. | Судалгаанд нийт 14 сум 1 тосгоны 5050 хүн болон ХАА газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуйн нэгж, нийтийн үйлчилгээний чиглэлийн 12 ААН хамрагдлаа. Аймгийн их, дээд сургууль, МСҮТ төгссөн иргэдийн судалгааг гаргаж нэгдсэн мэдээллийн сантай боллоо. Судалгаагаар их, дээд, сургууль болон МСҮТ-ийг төгсөгч 558, суралцаж байгаа 1117 оюутан сурагч байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаанд хамрагдсан хувиараа болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа 2406 иргэний мэдээллийг нэгтгэх ажил хийгдэж байна. Судалгаанд ХАА газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12, нийтийн үйлчилгээний чиглэлээр 11, нийт 23 аж ахуй нэгжээс 30 ажлын байрны шаардлага байна гэсэн тоон үзүүлэлт гарсан. | 90 |
| | 99 | 1.5.1.2. Ажилгүй болон | 2016- | ХХҮГ, | Улс, | Ажил, | Зах зээлийн эрэлтийн судалгааг нийт 5050 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эмзэг бүлгийн иргэдийг МСҮТ, бусад бизнесийн төвүүдтэй хамтран, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр сургах, ажилд зуучлах | 2020 | МСҮТ, БСУГ, СЗДТГ | ОНТөсөв | мэргэжилгүй иргэдийн 80 гаруй хувийг тус чиглэлд хамруулан төгсөгчдийн 50-аас дээш хувийг ажлын байраар хангасан байна. | иргэн, 23 аж ахуйн нэгжээс авч нэгтгэх ажлыг хийлээ. Зах зээлийн эрэлтийн судалгааг нийт хүн амын тоо, хөдөлмөрийн насны хүн, эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажилгүйдлийн түвшин, ажилгүй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо, МСҮТ болон ЕБС-д суралцагчдын тоо, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо, малчид, ажил олгогч, цаашид МСҮТ-д ямар чиглэлээр суралцах хүсэлтэй байгаа болон ажил мэргэжлийн эрэлтийн чиглэлээр авч нэгтгэн Аймгийн мэргэжлийн боловсрол, сургалтын зөвлөлд хүргүүлэх ажлыг амжилттай зохион байгууллаа. Цаашид МСҮТ-үүдтэй хамтран судалгааны ажлыг нягт болгох, хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 70 |
| | 100 | 1.5.1.3. МСҮТ-д суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх боломжийг нэмэгдүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, багш нарыг давтан сургах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах | 2016-2020 | ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ | Улс, ОНТөсөв, ХЭДС | Дадлага хийх орчин нөхцөлийг сайжруулж, 2 МСҮТ-ийн зарим техник тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна. | ХАА-н МСҮТ-өөс Хангайн бүсийн арга зүйн төвийн мульт медия хичээл боловсруулах чиглэлээр 9, бүсийн арга зүйн төвийн сургалтанд 2, УБ хотод хуурай сүүний технологийн чиглэлээр 3, ХНХЯ-наас зохион байгуулсан ХАБЭА-н чиглэлээр 1 багш нийт 15 багш чадавхижуулах сургалтанд хамрагдаад байна."Булган хангай" МСҮТ-өөс Ази номхон далайн орнуудын коллежуудийн менежментийн чиглэлээр 1, УБ бүсийн арга зүйн төвөөс Цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйн чиглэлээр 1, магадлан итгэмжлэлийн сургалтанд 50, ажил мэргэжлийн лавлах мэргэжлийн стандарт боловсруулах чиглэлээр 30 , гоо заслын чиглэлээр 2 багш нийт 84 багш сургалтанд хамрагдсан байна. Нийт 2 байгууллагын 99 багшийг мэргэжлийн дагуу чадавхижуулах сургалтанд хамрууллаа. Үйлдвэр дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалтанд нийт 78 иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар Булган сумын томоохон аж ахуйн нэгжүүд болох Булган кашмер ХХК, Булган Мэээж ХХК, Долоон бар ХХК зэрэг 16 байгууллагад нийт давхардсан тоогоор 45 оюутан сурагчийг хамруулсан байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шийдэл бүхий стандартын шаардлагад нийцсэн нийтийн хоолны үйлчилгээний газар байгуулах, хувийн хэвшлийн санаачлагыг дэмжих | 2020 | СХХ | хэвшлийн хөрөнгө | газруудын орчин, нөхцөл сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. | аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 136 дугаар тогтоол, стандартчилал тохирлын үнэлгээний шаардлага хангасан Бугат сумын “Хангайн зоо” ХХК-ийн “Чингисийн монгол” амралтын газар, Рашаант сумын “Хорсбек адвентур монголиа” ХХК-ийн жуулчны баазын “Эден” бааранд шинээр согтууруулах ундаа худалдах үйлчлэх тусгай зөвшөөрөл олгож, Рашаант сумын “Ханхар хайрхан” ХХК, ”Хоёр загал жуулчин”ХХК- ийн хоол үйлдвэрлэлийн цэгийн тусгай зөвшөөрлийг сунгалаа. Дашинчилэн сумын “Дорнод монгол полимент” ХХК-ийн “Чин хайрхан” ресторан, Баяннуур сумын “Буянт”, Тэшиг сумын Синка баар, Могод сумын “Мини кафе”-д тусгай зөвшөөрөл олгож үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүллээ.<br>Булган сумын “Булган Анар” ХХК, “Анхдагч аян” ХХК-ууд зоогийн газартаа засвар тохижилтийн ажил хийж үйлчилгээний орчин нөхцөлөө сайжруулж, суудлын тоогоо нэмэгдүүллээ. Мэргэжлийн байгууллагууд хамтран “Чанартай, соёлтой, хариуцлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ” хөгжүүлэх уриалга гргаж холбогдох төрийн байгууллага, тогооч нарын холбоонд хүргүүллээ. | |
| **<u>2.4 Байгаль орчин, ногоон хөгжил:</u>**<br>**Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, хүрээлэн буй орчны доройтлыг бууруулан, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж, эрүүл, аюулгүй, ногоон хөгжлийг бий болгон, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, байгаль хамгаалах үүргийг бүх нийтийн үйл хэрэг болгоно.** | | | | | | | | |
| **/37/** 2.4.1. Байгалийн нөөц, түүний нөхөн сэргэх чадвар, хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгмийн дэвшлийг түргэтгэх шаардлагатай уялдуулан дасан зохицох, нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, орчны | 197 | 2.4.1.1. “Ногоон хөгжлийн хэтийн зорилт” бодлогын бичиг баримтыг боловсруулж, хэрэгжүүлэх | 2016-2020 | БОАЖГ | Улс, ОНТөсөв, Төсөл хөтөлбөр, | Ногоон эдийн засаг хөгжих чиг хандлага тодорхой болно | “Ногоон хөгжлийн хэтийн зорилт” бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан АИХТэргүүлэгчдийн 2017 оны 57 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| | 198 | 2.4.1.2. Хүүхэд, залуучуудад экологийн боловсролыг олгох хөтөлбөр боловсруулж, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах зан | 2016-2020 | БОАЖГ | 1600.0 | Экологийн боловсролыг нэмэгдүүлсэн байна | АИТХТэргүүлэгчдийн 2017 оны 56 дугаар тогтоолоор "Хүүхэд, залуучуудад экологийн боловрсол олгох хөтөлбөр, төлөвлөгөө"-г батлуулан сумдад хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ЕБС-иудын дунд “Эко сургууль” шалгаруулах болзолт уралдааныг 02-р сарын 01-нээс 10-р сарын 01-ний хооронд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| бохирдлыг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | үйлийг хэвшүүлж, байгальд ээлтэй сургуулиудыг бий болгох батлуулах | | | | | зарлаж, 1-р байранд Бүрэгхангай бүрэн дунд сургууль, 2-р байранд Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургууль, 3-р байранд Тэшиг сумын бүрэн дунд сургуулиуд тус тус шалгаран өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн "Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл"-ийн "Эко сургууль" хөтөлбөрт Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургууль, 1-р 12 жил, Хишиг-Өндөр, Могод сумдын ЕБСургуулиуд хөтөлбөрт хамрагдаж, тус сургуулиудын багш, сурагчдад 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | |
| | 199 | 2.4.1.3. Агаар, хөрсний бохирдлын судалгаа шинжилгээг тогтмолжуулж, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Агаарын бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ | Агаар, хөрсний бохирдлын судалгаа шинжилгээг хөтөлбөрийн дагуу тогтмол хийж байна. 2017 оны эхний 10 сарын байдлаар агаар бохирдуулагч хүхэрлэг хий /SO2/-ийн 531 сорьц, азотын давхар исэл /NO2/-ийн 531 сорьц, нийт 1062 сорьцонд шинжилгээ хийгдсэн. Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжилт шинжилгээний дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй байна. Агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллогыг жил бүрийн 9-11-р саруудад зохион байгуулдаг бөгөөд аймгийн хэмжээнд тооллогын ажлыг явуулж дуусаагүй байна. 2017 онд 6 сумын 25 зогсоол, цэг дээр цөлжилтийн судалгааны ажил хийгдсэн. | 100 |
| | 200 | 2.4.1.4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг бодлогоор дэмжих | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Агаарын бохирдлыг бууруулж, эрчим хүчийг тодорхой хэмжээгээр хэмнэнэ | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болох "Гэрийн илч газ" ХХК, "Дашваанжилд" ХХК-иудад БОНБЕҮнэлгээг хийж, үйл ажиллагааг нь дэмжин ажиллалаа. | 70 |
| | 201 | 2.4.1.5. Иргэдийн байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, уламжлалт зан үйл, зөв дадал | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Байгаль орчноо хайрлан хамгаалах дадал соёл | Булган сумын иргэдэд байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, зөв дадал зуршлыг олгох зорилгоор "Хаягдал ус-Нөөц баялаг" уриан дор "Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт", "Усны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зуршлыг сэргээн хөгжүүлэх сургалт сурталчилгааг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, байгаль орчныг хамгаалах үүргийг бүх нийтийн үйл хэрэг болгох | | | | ухамсар нь дээшилсэн байна | сав ба эрүүл мэнд", "Усны бохирдол", "Ус хэмнэх аргууд", "Сургуулийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй" зэрэг сэдвээр сургалт, мэдээлэл хийлээ. Мөн хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, эргүүлэн ашиглах талаар амралт, рашаан сувилал ихтэй Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг сумдад ажиллаж, хуулийн шинэчилсэн найруулагыг 80 гаруй төрийн албан хаагч, иргэд болон 58 аялал жуулчлалын чиглэлийн аж ахуйн нэгжид сурталчилан танилцуулж, гарын авлага, тараах материалыг өглөө. | |
| | 202 | 2.4.1.6. Аливаа төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүүлсний үндсэн дээр дараагийн шатны үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлэх | 2016-2020 | БОАЖГ | Хувийн хэвшлийн хөрөнгө | Орчны сөрөг нөлөөлөл багасна | Сумдын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд шинээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ болон шаарлагатай төсөл арга хэмжээнүүдэд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэхээр тусгаж өгсөн. 2017 оны байдлаар 48 төсөл арга хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлээ. | 100 |
| | 203 | 2.4.1.7. Орчны бохирдлыг бууруулах, хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, байгальд халгүй аргаар устгах дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, аймгийн төвийн гэр хорооллын айл өрхийг хог төрөлжүүлэн хийх хогийн савтай болгон хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийг эхлүүлэх | 2016-2020 | БОАЖГ | 265000.0 | Орчны бохирдлыг бууруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. 4-өөс доошгүй хүнийг ажлын байраар хангана | Булган сумын 400 айл өрхөд хог төрөлжүүлэн хийх хогийн савыг айл өрхийн хашаанд суурилуулж өглөө. Ачуут голоос Орхон гол хүртэлх голын гольдролын 10 км газрын хог хаягдлыг Булган сумын Тохижолт үйлчилгээний анги хариуцан хийж, орон нутгийн ажилгүй 15 иргэнийг түр ажлын байраар хანган 20.5 тн хог хаягдлыг цэвэрлүүлж, 171500 төгрөгний шатахуун зарцуулсан. Мөн Булган сумын төвлөрсөн хогийн цэгийн 22 га талбайн хур хог хаягдлыг цэвэрлэн байгальд халгүй аргаар дарж булах ажлыг хийж гүйцэтгэлээ. | 100 |
| | 204 | 2.4.1.8. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Орчны бохирдлыг бууруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих ажлын зураг төсөв хийгдсэн бөгөөд санхүүжилтийн асуудлыг шийдэхээр ажиллаж байна. | 40 |
| **/38/** 2.4.2. Усны нөөцийг хэмнэх, | 205 | 2.4.2.1. Гидрогеологийн дунд масштабтай | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Газрын доорх усны нөөцийг | Баяннуур сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорхи усны ашиглалтын | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хуримтлуулах, зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангана. | | зураглал хийлгэж, Хишиг-Өндөр, Баяннуур, Баян-Агт, Гурванбулаг сумдын газрын доорх усны ашиглалтын нөөцийг нарийвчлан тогтоох | | | | шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглана | нөөцийг тогтоох саналыг 2017 оны төсөвт оруулсан боловч хөрөнгийн асуудлыг 2018 онд шийдвэрлэхээр хойшлогдсон болно. | |
| | 206 | 2.4.2.2. Хүн амын усан хангамжийн 40 худагт эрүүл ахуйн шаардлага хангасан ус нөөцлөх сав суурилуулах | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Хүн амын усан хангамжтай эрүүл ахуйн нөхцөл сайжирна | Сумдын 10 худагт эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус нөөцлөх сав суурилуулах саналыг 2017 оны төсөвт оруулсан боловч хөрөнгийн асуудлыг 2018 онд шийдвэрлэхээр хойшлогдсон болно. | 0 |
| | 207 | 2.4.2.3. Рашаант, Дашинчилэн суманд хур бороо, цасны усыг хуримтлуулах, хөв цөөрөм шинээр байгуулах, Могодын хөв, цөөрмийг сэргээн засварлах | 2017-2020 | БОАЖГ | 30000.0 | Бэлчээр, газар тарилангийн усан хангамж нэмэгдэж газрын доорх усыг хэмжинэ | Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 29.3 сая төгрөгийн хөрөнгөөр Дашинчилэн, Могод, Рашаант, Сайхан сумдад хөв цөөрмийн зураг, төсөл боловсруулах ажлыг "Жишиг проект" ХХК, "Гидроком байгууламж" ХХК-иуд хийж гүйцэтгэлээ. 2018 оны төвсийн санал дээрх ажлын зардлыг тусгасан болно. Мөн Могод сумын хөв цөөрмийг сэргээн засварласан. | 100 |
| | 208 | 2.4.2.4. Хануй, Хульж, Цагаан гол, Их булаг зэрэг рашааны ордуудын нөөцийг тогтоож, хамгаалалтын асуудлыг оновчтой шийдвэрлэх | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Рашааны найрлага, нөөцийг тодорхойлон шинжлэх ухааны үндэслэлтэй эмчилгээ сувилгаанд хэрэглэнэ | Могод сумын Хульжийн халуун рашааныг хашиж хамгаалан усны нөөцөд орж буй өөрчлөлтийг хянах хяналтын цооногийг гаргаж тоноглосон. | 100 |
| | 209 | 2.4.2.5. Хүн амын усан хангамжид зориулж 20-оос доошгүй худаг шинээр гаргах | 2017-2020 | БОАЖГ | 120000.0 | Хөдөөгийн хүн ам, бэлчээрийн усан хангамж нэмэгдэнэ | Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 117.2 сая төгрөгийн хөрөнгөөр хөдөөгийн хүн ам, бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар шинээр 10 худаг гаргалаа. | 100 |
| | 210 | 2.4.2.6. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хил заагийг тэмдэгжүүлж, дэглэмийг мөрдлөг болгох | 2017-2020 | БОАЖГ | 24000.0 | Усны сан бүхий газрыг бохирдлоос хамгаална | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын ЗДТГ болон Сэлэнгэ, Туул голын сав газрын захиргаад хамтран усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд 100 ширхэг самбар байрлуулан, дэглэмийг сурталчилан таниулах ажлыг хэрэгжүүлж байна. | 100 |
| | 211 | 2.4.2.7. Татарсан нуур, | 2017- | БОАЖГ | ОНТөсө | Нуур, цөөрөм, | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цөөрөм, гол, горхины усны түвшинг нэмэгдүүлэх судалгаа, шинжилгээ хийх | 2020 | | в | гол, горхины ус багасаж ширгэж байгаа шалтгаан болон усны түвшинг нэмэгдүүлэх арга зам тодорхойлогдсон байна. | Сэлэнгэ, Хануй, Туул, Орхон голын сав газрын захиргаад хамтран усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгууллаа. Усны тооллогоор татарсан болон усгүй болсон 4 гол горхи, 82 булаг шанд, 2 рашаан, 9 нуур бүртгэгдлээ. | |
| | 212 | 2.4.2.8. Ачуут, Дал, Баян, Тал булаг зэрэг голууд, 40-өөс доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаалах | 2016-2020 | БОАЖГ | 40000.0 | Усны нөөцийг нитрат, нитрит, аммиак, нян, вирусээр бохирдохоос хамгаалж, урсац нэмэгдсэн байна. | Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 35.3 сая төгрөгийн хөрөнгөөр Баян-Агт суманд 2, Хишиг-Өндөр суманд 3, Гурванбулаг суманд 3, Орхон суманд 1, Хутаг-Өндөр суманд 1, нийт 10 булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлыг "Өвөлжөөн булаг" ХХК, "Хурмастын хүлэг" ХХК-иуд хийж гүйцэтгэлээ. | 100 |
| ***/39/*** 2.4.3. Ойн нөөцийн менежментийг сайжруулж, зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. | 213 | 2.4.3.1. Ойжуулалтыг 300 га-аас доошгүй талбайд зураг төсвийн дагуу хийж, дэвшилтэт технологи бүхий бортоготой тарьцаар ойжуулалт хийх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | 2016-2020 | БОАЖГ | 194869.2 | Нөхөн сэргээлтийг шаардлагатай газарт хийж, ойн сан нэмэгдсэн байна. | Ойжуулалтын ажлыг "БУЦС" нөхөрлөл Хишиг-Өндөр сумын Нарийны аманд 100 га-д, "Хөвөнтөн ой" ХХК Сэлэнгэ сумын Баруун голын эхэнд 100 га-д, "Ойн таксаци" ХХК Хутаг-Өндөр сумын Тахилтад 50 га, Шар хавтгайд 50 га, нийт 300 га талбайд хийж тарилтын болон ургалтын үеийн хяналтыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн Засаг даргын А/531 тоот захирамжаар ойжуулалт, ногоон хэрмийн туслах зурвасын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь тооллого явуулж амьдралтын 40-75,7 хувьтай аймгийн комисст хүлээлгэн өглөө. | 100 |
| | 214 | 2.4.3.2. Ойг цэвэрлэх, арчлах, хамгаалах санаачлагыг өрнүүлж, уг ажлыг гүйцэтгэсэн иргэн, нөхөрлөлийг бодлогоор дэмжих | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа идэвхжинэ | "Ойн цэвэрлэгээ" хөтөлбөрийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдээр мод бэлтгүүлж, нэгдсэн захаар дамжуулан олгохоор шийдвэрлэж, модны үнийг 50 хувь хөнгөлж иргэн, нөхөрлөлийг дэмжин ажиллалаа. Мөн "Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх" төсөлтэй хамтран Хутаг-Өндөр, Орхон, Бугат, Хангал, Сэлэнгэ сумдын 25 ойн нөхөрлөлд 120 га талбайд ойн арчилгааны огтлолтын зардлыг олгож Сум дундын ойн анги мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч гүйцэтгүүллээ. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 215 | 2.4.3.3. Ойн сан бүхий сумдад ойн хуурайшилт хортон шавжаас хамаарсан сөрөг үзэгдлийг нарийвчлан судалж, шаардлагатай тохиолдолд модлогийн таваарлаг чанар алдахаас өмнө ашиглах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Ойн хортны голомтыг багасгаж, ой эрүүлжинэ | Сум дундын ойн анги жилд бэлтгэх модны хуваарийг ой зохион байгуулалт болон ойн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан байгалийн гамшигт үзэгдэл цас, шуурганд унасан, ойн хортон шавжинд идэгдсэн модны судалгаанд үндэслэн дараа жилд бэлтгэх төлөвлөгөөнд тусгаж өгсөнөөр модлогийн таваарлаг чанар алдахаас өмнө ашиглаж байна. Төлөвлөгөөнд тусгасаны дагуу Сум дундын ойн ангиуд 1280 га талбайд тусгаарлалтыг хийж 57222 м3 модыг цэвэрлэж сум орон нутгийн хэрэгцээнд олгосон байна. | 100 |
| | 216 | 2.4.3.4. Ойн хортон шавжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлж, жил бүр 40000-аас доошгүй га талбайд биологийн болон байгальд сөрөг нөлөөгүй аргаар тэмцэх | 2016-2020 | БОАЖГ | 159796.0 | Ойн хэв шинж хадгалагдана | Ойн хортны судалгааны ажлыг “Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачлага” ТББ ой бүхий сумдын 100000 га талбайд судалгааны ажлыг явуулж, судалгааны ажлын үндсэн дээр ойн хортны тэмцлийн ажлыг “Гранд форест” ХХК 16800 га талбайд Хангал, Хутаг-Өндөр, Орхон, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Баян-Агт сумдад хийж гүйцэтгэлээ. Ойн хортны тэмцлийн ажилд сум дундын Ойн ангиуд хяналт тавин ажилласан. | 100 |
| | 217 | 2.4.3.5. Модыг орлох түлш, барилгын материал, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Модон бүтээгдэхүүний хэрэглээ зохистой хэмжээнд байж, нөөц хамгаалагдана | Аймгийн хэмжээнд 4 шахмал түлшний үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Булган сумын "Билгүүн дэлгэрэх" ХХК нь Булган сумын иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор 72 тн шахмал түлшийг хийгээд байна. НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас хэрэгжүүлж байгаа "Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх" төслөөс шахмал түлш үйлдвэрлэх бага оврын тоног төхөөрөмж, хусны нүүрс шатаах зуухыг олгож, Байгал орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, Сум дундын ой ангийн дарга, Хөдөө аж ахуйн харъяа мэргэжил сургалт үйлдвэрлэлийн сургуулийн багш нарыг хусны нүүрс шатаах сургалтанд хамруулан дадлагажууллаа. | 100 |
| | 218 | 2.4.3.6. Ойн үрийн аж ахуйг өргөжүүлж, сайн чанарын үрийн нөөцийг | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Сайн чанарын тарьц | Баян-Агт сумын Задгай, Тэшиг сумын Наран, Хангал сумын Чулуут, Орхон сумын Сүүдэр зэрэг газруудын үрийн талбайг арчилан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бий болгох | | | | суулгацаар хангана | хамгаалж байна. | |
| **/40/** 2.4.4. Цөлжилтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах, хортон мэрэгчидтэй тэмцэх, усжуулах, байгалийг аясаараа нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ. | 219 | 2.4.4.1. "Ногоон хэрэм" байгуулах болон "Цөлжилт"-ийг бууруулах зорилгоор ойн зурвасыг жил бүр 10-аас доошгүй га газарт байгуулах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Цөлжилт, элсний нүүдэл, хөрсний доройтол тодорхой хэмжээгээр буурсан байна. | “Хөвөнтөн ой” ХХК нь 2016-2017 онд хийгдсэн цөлжилт болон ногоон хэрмийн туслах зурвасын ажлын дутуу 5 га талбайд нөхөн тарилт хийж, амьдралтын 69,7-72,8 хувьтай аймгийн комисст хүлээлгэн өглөө. | 100 |
| | 220 | 2.4.4.2. Төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж, ногоон байгууламжийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Ногоон байгууламжийн хэмжээ 3 дахин нэмэгдүүлсэн байна | Аймгийн Засаг даргын захирамжаар бүх нийтээр мод, бут тарих ажлын төлөвлөгөөг гарган сумдад хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу тарьц, суулгацны үзэсгэлэн худалдааг хавар, намар зохион байгуулж, Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнд 9728 ширхэг мод бутыг тарьсан. Аймгийн хэмжээнд хавар, намрын тарилтаар 522 аж ахуйн нэгж, байгууллагын 10532 иргэн, 318732 ширхэг мод, бутыг тарьж, 201.2 м2 цэцгийн мандал байгуулсан. Байгууллага болгон өөрийн тарьсан модыг услан арчилж байна. | 100 |
| | 221 | 2.4.4.3. Цөлжилт, бэлчээрийн талхлалтыг сааруулах, гол горхи, булаг шандны урсацыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих хөдөлгөөн өрнүүлэх | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Бэлчээрийн даац нэмэгдэж, цөлжих үйл явц саарсан байна | Цөлжилт, бэлчээрийн талхлалтыг сааруулах зорилгоор гол горхи, булаг, шандны эхэнд мод бут тарих талаар аймгийн Засаг даргын 2017 оны 1/148 тоот албан бичгийг урд бүсийн 4 суманд хүргүүлсэн. Мөн элсний нүүдэл болон иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор Чацаргана төслийг хэрэгжүүлж хоршоо, нөхөрлөл, бүлэгт хавар намар нийт 265.4 га талбайд 219006 ширхэг чацаргана тариуллаа. | 100 |
| **/41/** 2.4.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, газар болон газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 222 | 2.4.5.1. Баян-Агт сумын Ханчуй, Цагаан гол, Шаргын нуур, Сайхан сумын Хунтын рашаан, Могод сумын Хульжийн рашаан, Хутаг-Өндөр сумын Их булгийн рашааны орчимд хамгаалалтын бүс | 2017-2018 | БОАЖГ | ОНТөсөв | Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хамгаалалтын горим мөрдөгдөж эхэлсэн | Баян-Агт сумын Ханчуй, Цагаан гол, Шаргын нуурын хамгаалалтын бүс тогтоох, орон нутгийн хамгаалалтад авах ажлыг сумын Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, сумаас хамгаалалтын бүсийг тогтоох саналыг боловсруулан сумын ИТХ-д оруулах ажлыг хийж байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоож, орон нутгийн хамгаалалтад авах | | | | байна. | | |
| | 223 | 2.4.5.2. Түүх, соёл, байгалийн цогцолбор газрын судалгааг гаргаж, улсын болон орон нутгийн хамгаалалтад авч, мэдээллийн сүлжээнд хамруулах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдсэн байна | Түүх, соёл, байгалийн цогцолбор газрын судалгааг гаргахаар сумдад аймгийн Засаг даргын 2017 оны 1/198 тоот албан бичгийг хүргүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. | 40 |
| | 224 | 2.4.5.3. Улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбартай болгох | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын мэдээллийн санг бүрдүүлж, хууль бус үйл ажиллагаа хязгаарлагдсан байна | Ханжаргалант, Уран тогоо, Намнан ууланд тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар байрлуулахаар 2017 онд төлөвлөсөн боловч хөрөнгийн асуудлаас хасагдсан учир 2018 оны төлөвлөгөөнд оруулахаар санал өгсөн. | 0 |
| | 225 | 2.4.5.4. Эвдэрсэн газрын тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, төв суурин газрын болон уул уурхайн олборлолт, зам, барилгын ажилд ашигласан, эзэнгүй орхигдсон газрыг ээлж дараатайгаар нөхөн сэргээх, хамгаалах | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээж, байгалийн унаган төрхөд ойртсон байна | Эвдэрсэн газрын тооллогыг 2018 онд хэрэгжүүлэхээр аймгийн төсвийн төсөлд 20 сая төгрөгийг тусгуулахаар санал орууллаа. | 0 |
| ***/42/*** 2.4.6. Амьтан, ургамлын удмын санг хамгаалж, нөхөн сэргээх замаар өсгөн үржүүлэх, үр өгөөжийг дээшлүүлнэ | 226 | 2.4.6.1. Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авч, ан амьтдын өсч, торних нөхцлийг бүрдүүлэх | 2016-2020 | БОАЖГ | 6000.0 | Биотехникийн арга хэмжээг чанартай, үр дүнтэй зохион байгуулна | Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авахаар хамгаалалтын захиргаадтай гэрээ байгуулан ажиллалаа. | 70 |
| | 227 | 2.4.6.2. Гол мөрөн, нуур, цөөрмийг түшиглэсэн загас, шувуу, бусад төрлийн амьтдыг өсгөн үржүүлэх аж ахуй байгуулах санаачлагыг | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Тодорхой нэр төрлийн амьтдын нөөц хамгаалагдсан байна | Хутаг-Өндөр сумын иргэн Баасандорж загас үржүүлэхээр хүсэлт ирүүлсний үндсэн дээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийж, заавар зөвлөмж өгч ажиллалаа. Мөн бусад төрлийн амьтдыг өсгөн үржүүлэх аж ахуй байгуулах талаар Эрдэнэт үйлдвэрт санал | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжих | | | | | тавиад байна. | |
| | 228 | 2.4.6.3. Ургамлын тооллого, судалгаанд үндэслэн 2-оос доошгүй ховор, нэн ховор ургамлыг орон нутгийн хамгаалалтад явах | 2016-2020 | БОАЖГ | 5000.0 | Ховор ургамал хамгаалагдсан байна | Ургамлын тооллого, судалгаанд үндэслэн 2-оос доошгүй нэн ховор, ховор ургамлыг орон нутгийн хамгаалалтанд авахаар сумдын Засаг дарга нарын гэрээнд тусгаж өгсөнөөр "Чихэр өвс", "Бүрнүс", "Заан хүж", "Дүмбэрэй" зэрэг ургамлыг орон нутгийн хамгаалалтанд аваад байна. | 100 |
| | 229 | 2.4.6.4. Ашиглалтын нөөцтэй зарим ургамлыг зохистой ашиглах, нэн ховор, ховор ургамлыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Нэн ховор, ховор ургамлыг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээ авагдана | Баян-Агт суманд ургаж буй нэн ховор ургамал болох "Заан хүж" ургамлыг хамгаалж, идэвхтэн байгаль хамгаалагчийг ажиллуулж байна. | 100 |
| | 230 | 2.4.6.5. Сумдад байгаль орчны хэсэг байгуулж, байгаль хамгаалагчдын ажиллах орчин, нөхцлийг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Хяналт шалгалтын ажил эрчимжиж, үр дүнд хүрсэн байна | Сумдад байгаль орчны хэсэг байгуулж, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байна. | 100 |
| ***/43/*** 2.4.7. Ус, цаг уурын урьдчилсан мэдээний чанар шуурхай байдал, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 231 | 2.4.7.1. Сумдад цаг уурын автомат станцыг ээлж дараатайгаар суурилуулах | 2017-2018 | УЦУОШГ | ОНТөсөв, Төсөл, Хөтөлбөр | Цаг уурын ажиглалтын давтамж нэмэгдэж хүнээс шалтгаалах алдаа багасна. | Бүрэгхангай, Бугат, Сайхан, Хишиг-Өндөр, Орхон, Баян-Агт, Хангал, Баяннуур сумдын Засаг дарга нарт цаг уурын харуулуудын ажиглалтын талбайг томосгох, цахилгаанд холбох ажлыг 2018 оны хийсэн байх талаар Аймгийн Засаг даргын албан тоотыг 2017-03-03-нд хүргүүлсэн. | 100 |
| | 232 | 2.4.7.2. Ажиглалтын талбайн тусгай хэрэгцээний газрыг тодотгож, 100 метрийн радиуст хамгаалалтын бүс тогтоох | 2016-2020 | УЦУОШГ, ГХБХБГ | - | Монгол улсын УЦУОХШ-ний тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлсэн байна | Сумдын газрын даамал нарт 2017оны 03 дугаар сарын 30-нд хамгаалалтын бүсийн талаар зааварчлага өгч хуулийн дагуу ажиллахыг зөвлөв. | 100 |
| | 233 | 2.4.7.3. Байгаль орчны шинжилгээний лабораторийг | 2016-оноос | БОАЖГ ГХБХБГ | Улс, ОНТөсөв | Лаборторийн хүчин чадал нэмэгдэж, | Итгэмжлэлд хамруулах бичиг баримт боловсруулах ажил хийгдэж байна. Шаардлагатай багажаар хангуулах талаар | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | итгэмжлэлд хамруулж, шаардлагатай багажаар хангах, барилгын өргөтгөл барих, цэвэр бохирын шугамд холбох | | | | чанар дээшилнэ | Байгаль орчин, аялал жуулчлалын газарт судалгаа мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна. | |
| | 234 | 2.4.7.4. Тэшиг сумын Ус, цаг уур шинжилгээний өртөө, Орхон сумын Ус, цаг уурын харуулын ажлын байр барих, Сэлэнгэ сумын УЦУШ-ний өртөөний барилгад их засвар хийх | 2017-2020 | ГХБХБГ, УЦУОША | Улс, ОНТөсөв | Ажилчдын ажлын нөхцөл сайжирна | Хугацаа болоогүй | Үнэлэх боломжгүй |
| | 235 | 2.4.7.5. Шаардлагатай тохиолдолд Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2017-2020 | АЗДТГ, УЦУОШГ | Улс, ОНТөсөв | Таримал болон бэлчээрийн ургамлын ургалтыг сайжруулж, ой хээрийн түймэр гарахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ. | Таримал болон бэлчээрийн ургамлыг чийгээр хангах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас оруулах арга хэмжээ авсан боловч энэ жилийн цаг агаарын онцлог байдлаас шалтгаалан үр дүн хангалттай хэмжээнд байж чадсаагүй. | 70 |
| **<u>2.5 Аялал жуулчлал:</u>**<br>**Аялал жуулчлалыг эдийн засгийн үр өгөөжтэй, байгальд ээлтэй салбарын нэг болгон хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| **/44/** 2.5.1. Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх арга замыг судлан тогтоож, жуулчдын сонирхол, хэрэгцээг хангахуйц арга барилыг нэвтрүүлнэ. | 236 | 2.5.1.1. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулж, жуулчдад мэдээлэл өгөх, сургалт, зуучлалын цогц үйлчилгээ үзүүлэх | 2017-2018 | БОАЖГ | ОНТөсөв | Жуулчдыг мэдээллээр хангаж орон нутгаа олон улсын хэмжээнд сурталчилна | Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулахаар 2018 оны төсөвт санал хүргүүлээд байна. Одоогоор аймгийн музейг түшиглэн аялал жуулчлалын талаарх мэдээллийг өгч байна. | 70 |
| | 237 | 2.5.1.2. Аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг зохион байгуулж, салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Салбарын бодлого, зорилт тодорхойлогдоно | Аймгийн "Хөгжлийн хөтөч форум" зохион байгуулан аялал жуулчлалын салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлж, форумаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| | 238 | 2.5.1.3. Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн, эко | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн | Тусгай хамгаалалттай газар | Булган аймгийн нутаг дахь байгаль, түүх, соёлын дурсгалын болон, рашаан, аялал жуулчлалын гол бүс нутгуудыг телевиз, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аялал жуулчлалыг хөгжүүлэх | | | хэвшлийн хөрөнгө | нутгийн менежмент сайжирч, аялал жуулчлал хөгжинө | нийгмийн сүлжээ, бусад мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах, Булган нутгийн аялал жуулчлалын хөгжлийг шинэ түвшинд гаргах зорилгоор Булган аймгийн аялал жуулчлалын холбоо ТББ санаачилан "АНХДАГЧДЫН ӨЛГИЙ БУЛГАН НУТГААР” авто аяллыг зохион байгууллаа. Аяллын явцад Bike & Bandit-р үзүүлэх сургалт, рафтингийн завиар богино аялал хийх, рафтинг завьны үзүүлэх сургалт, спорт загасчлалын үзүүлэх сургалтуудыг хийж 2018 онд ТВ-ийн нэвтрүүлэг бэлтгэхээр ажиллаж байна. | |
| | 239 | 2.5.1.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг тэмдэгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байна | Түүх, соёлын үйл хөдлөх дурсгалт газар Сайхан сумын улсын хамгаалалтанд байгаа Моюнчурын дурсгал, Дашинчилэн сумын харуулын цамхагыг хамгаалах, тэмдэгжүүлж аяллын бүтээгдэхүүн болгох ажлыг 2018 оноос үе шаттай зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 40 |
| | 240 | 2.5.1.5. Улсын болон орон нутгийн авто зам дагуу аялагчдад зориулсан стандартад нийцсэн түр буудаллах цэгийг байгуулах, хувийн хэвшлүүдийг бодлогоор дэмжих | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Аялагчдын тав тухай аюулгүй орчин бүрдсэн байна | Хөвсгөл аймгийн чиглэлд аялал жуулчлалын цогцолбор байгуулахаар 2 иргэнд 4 га газрыг олгосон. Мөн БОАЖЯам Рашаант суманд түр буудаллах цогцолбор байгуулахаар гүйцэтгэгчийг шалгаруулаад байна. Мөн Хутаг-Өндөр суманд түр буудаллах цэг байгуулахаар ажиллаж байна. | 70 |
| | 241 | 2.5.1.6. Амралт, рашаан сувиллын газруудын байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах, аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, орчныг бохирдлоос хамгаалах | 2017-2020 | БОАЖГ | Хувийн хэвшлийн хөрөнгө | Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгана | Жуулчны бааз, амралт, рашаан сувиллын газруудад хийгдсэн хяналт үнэлгээгээр аж ахуйн нэгжүүдэд хог хаягдал болон бохирын асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар үүрэг даалгавар өгч ажиллалаа. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгүүлэхээр сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүллээ. | 100 |
| | 242 | 2.5.1.7. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад, дотоодын зах зээлд тогтмол сурталчилж, жуулчдын | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдэж, салбарын хөгжил | “ITM-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 16 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож аймаг, орон нутгаа сурталчиллаа. Аж ахуйн нэгжүүд давхардсан тоогоор гадаад болон дотоодын 40 гаруй тур | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоог жил бүр нэмэгдүүлэх | | | | эрчимжинэ | операторуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг байгуулан гадаадын жуулчдыг хүлээн авч байна. | |
| **/45/** 2.5.2. Байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, рашаан сувилал, дэд бүтэц зэрэг давуу талаа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлж, салбарын үйлчилгээний чанар стандартыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 243 | 2.5.2.1. Орон нутгийн онцлог, зан заншлыг харуулсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, нутгийн иргэдийг татан оролцуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Иргэдийн орлого нэмэгдэж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо нэмэгдэнэ | Байгаль орчны салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг "Ногоон хөгжлийг иргэдээс эхлье" уриан дор амжилттай зохион байгуулан ойн нөхөрлөлүүдийн гишүүдийн хийсэн бүтээгдэхүүн, гар урлалын бүтээлээр үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилдэг бүтээлийг шалгаруулан урамшууллаа. | 100 |
| | 244 | 2.5.2.2. Салбарын мэргэжлийн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Аялал жуулчлалын салбарын үйлчилгээ, ажилчдын ур чадвар сайжирна | Салбарын ажилтны ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсээс зохион байгууллаа. Уг сургалтанд 20 иргэн хамрагдаж мэргэжлийн зөөгч, бармены гэрчилгээтэй боллоо. | 100 |
| | 245 | 2.5.2.3. Аяллын маршрутыг тодотгож, тусгай сонирхлын аяллыг төрөлжүүлэн хөгжүүлэх, энэ чиглэлээр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжинө | Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах төлөвлөгөөнд жуулчны баазуудыг хамруулан орон нутгаа сурталчилах ажлыг зохион байгуулахаар тусгаж "АНХДАГЧДЫН ӨЛГИЙ БУЛГАН НУТГААР" авто аялалд "Монгол Алтай тур" жуулчны бааз, Хутаг өндөр, Дэлгэр, Цагаан нуга, Унльт зэрэг жуулчны бааз, Эмт ангийн отгууд хамтран ажилалаа. | 100 |
| | 246 | 2.5.2.4. Булган сумын "Цагаан суварга-Диваажин сүм"-ийг түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ бий болгох | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Төсөл, хөтөлбөр | Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, үйлчилгээ өргөжсөн байна | Булган сумын "Цагаан суварга-Диваажин сүм"-ийг сэргээн засварлах хөрөнгө батлагдаагүй болно. | Үнэлэх боломжгүй |
| | 247 | 2.5.2.5. Хутаг-Өндөр сумын “Хангинахын шугуй”-н шагайн тойрмын эвент арга хэмжээг зохион байгуулах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн | Үндэсний спортыг хөгжүүлж, жуулчдын тоо нэмэгдүүлэх, | “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг уламжлал ёсоор 4 дэх жилдээ зохион байгуулж, 4 аймгийн 28 баг оролцлоо. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөрөнгө | орон нутгаа сурталчилна | | |
| | 248 | 2.5.2.6. "Айрагны баяр" уламжлалт арга хэмжээг эвент болгон хөгжүүлэх | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Жуулчдын тоог нэмэгдүүлэх, орон нутгаа сурталчилах | Энэ онд аймгийн хэмжээнд зуншлага муу байсан тул "Айрагны баяр" уламжлалт арга хэмжээг зохион байгуулах ажлыг цуцалсан болно. | 40 |
| | 249 | 2.5.2.7. ОХУ-ын Буриад улсын Закамень аймагтай хамтран Эв модны наадмыг зохион байгуулах | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Хил орчмын улстай соёлын аялал жуулчлал өргөжсөн байна | ОХУ-ын Буриад улсын Закаменск районы дарга Гонжитов.С.В тэргүүтэй төлөөлөгч нар 4 дүгээр сард Булган аймагт айлчилсан. ОХУ-ын Буриад улсын Закамень аймаг байгуулагдсаны 90 ойн баяр наадамд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Батчулуунаар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй төлөөллийг оролцууллаа. Мөн аймгийн баяр наадамд Буриад улсын Закаменск районы даргын Улаан-Үд хот дахь бие төлөөлөгч Шойдоков.Д.С. тэргүүтэй 10 төлөөлөгч оролцлоо. | 70 |
| | 250 | 2.5.2.8. Баян-Агт сумын Шаргын нууранд мөсний шагайн харвааг түшиглэн жуулчдыг татах арга хэмжээг жил бүр зохион байгуулах | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Өвлийн аялал жуулчлал хөгжсөн байна | Үндэсний спортыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх зорилгоор Тэшиг сумын Харгал нууранд “Мөсний шагайн харваа-2017” арга хэмжээг аймгийн Засаг даргын тамгын газар, Тэшиг сумын Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газруудтай хамтран зохион байгуулж, 8 сумын 20 багийн 40 шагай харваачид оролцлоо. | 100 |
| | 251 | 2.5.2.9. Бугат, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Тэшиг, Булган сумдад өвлийн амралтын төв, цанын бааз байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих | 2017-2020 | БОАЖГ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Өвлийн аялал жуулчлал хөгжих нөхцөл бүрдэнэ | Бугат суманд сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр цанын баазыг байгуулаад байна. Орхон сумын Бүрэн бүст, Хангал сумын 2 амралтын газар улирлын хамааралгүй үйл ажиллагаа тогтмол явуулах боломжтой боллоо. | 100 |
| | 252 | 2.5.2.10. Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нөөц, үйлчилгээний газрын мэдээллийг шинэчилж, тохирлын үнэлгээг жил бүр хийж тогтмол хяналт тавих | 2016-2020 | БОАЖГ | ОНТөсөв | Аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо нэмэгдэж үйлчилгээний чанар сайжирна | Аймгийн Засаг даргын А/292 тоот захирамжийн дагуу 16 сум, 1 тосгонд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран хяналт үнэлгээний ажлыг зохион байгууллаа. Хяналт үнэлгээнд тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 125, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн 17, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | стандартын шаардлага хангасан 69 аж ахуйн нэгж хамрагдлаа. Хяналт үнэлгээний үр дүнд 22 иргэн, аж ахуйн нэгж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 5 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ ирүүлээд байна. | |
| **2.6 Төсөв, санхүүгийн бодлого:** **Аймгийн төсөв, санхүүг хариуцлагатай, ил тод, үр ашигтай удирдаж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.** | | | | | | | | |
| **/46/** 2.6.1. Татварын бааз суурийг өргөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. | 253 | 2.6.1.1. Хуулиар тогтоосон эрхийн хүрээнд зарим төрлийн татварын хувь хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан тогтоож, татварын бааз суурийг нэмэгдүүлэн стандарт түвшинг хангаж ажиллах | 2016-2020 | АЗДТГ, Татварын хэлтэс | - | Төсвийн орлого нэмэгдэнэ | 2016 онтой харьцуулахад татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага 81-ээр нэмэгдэж 1526, татвар төлөгч иргэн 215-аар нэмэгдэж, 708 иргэн хасагдаж, 30052 татвар төлөгч иргэнтэй боллоо. Орон нутгийн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл 19,7 тэрбум төгрөг болж, 107.9 хувь, улсын төвлөрсөн төсвийн орлогын гүйцэтгэл 1.4 тэрбум төгрөг болж, 100.2 хувиар биелэх урьдчилсан тооцоо гарлаа. | 70 |
| | 254 | 2.6.1.2. Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан цахим тайлан, цахим мэдээлэл лавлагааг нэвтрүүлж татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээ үзүүлж татвар төлөлтийг цахимжуулах | 2016-2020 | АЗДТГ, Татварын хэлтэс | - | Татвар төлөгчдөд хурдан, шуурхай үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ | 2016 оны жилийн эцэс, 2017 оны 3-р улирлын байдлаар 16 төрлийн татварын 24708 тайланг цахим болон цаасан хэлбэрээр хүлээн авч баталгаажуулж, 1924 иргэнд цахим тайлан руу нэвтрэх хэрэглэгчийн эрх үүсгэж, 187 татвар төлөгчдөд цахим тодорхойлолт гаргаж өгсөн. | 100 |
| | 255 | 2.6.1.3. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын тогтолцоог боловсронгуй болгосоноор хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх | 2016-2020 | АЗДТГ, Татварын хэлтэс | - | Эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй болж, татвар төлөгчдийн хандлага өөрчлөгдөн далд эдийн засаг буурна | Татвар төлөгчдийн эрсдэлийг ТЕГ-ын даргын баталсан Эрсдэлийн үнэлгээний журмын дагуу үнэлж, ангилан хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулан, хэрэгжүүлж ажиллаж байна. 2017 оны 10-р сарын 31-ний байдлаар 58 татвар төлөгчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 147,7 сая төгрөгийн зөрчил илрүүлж 13,1 сая төгрөгийн нөхөн татвар торгууль алдангийг татварын улсын байцаагчийн актаар ногдууллаа. | 100 |
| **/47/** 2.6.2 Орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилж хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг хангаж | 256 | 2.6.2.1. Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, хянаж үнэлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангаж ажиллах | 2016-2020 | АЗДТГ | - | Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно. | Төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn, аймгийн цахим хуудас www.bulgan.gov.mn, байгууллагын мэдээллийн самбарт байршуулан иргэд, олон нийтэд ил тод хүргэж байна. ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг иргэдэд | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ажиллана. | | | | | | | нээлттэй хэлэлцүүлж, санал авч хэвшлээ. | |
| | 257 | 2.6.2.2. Төсвийн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн систем нэвтрүүлэх | 2016-2020 | АЗДТГ | - | Төсвийн үр ашиг дээшилж, төсөв тунгалаг болсон байна. | Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн системд орон нутгийн төсвийн байгууллагууд 2017 оны батлагдсан төсөв, тодотгосон төсвөө шивж, оруулж байна. Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018-2020 оны дунд хугацааны төсвийн төслийг төсвийн төлөвлөлтийн нэгдсэн программаар боловсруулан Сангийн яаманд хүргүүллээ. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийг нэгдсэн системд оруулах бэлтгэл ажил хангагдаж байна. | 100 |
| | 258 | 2.6.2.3. Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 2016-2020 | АЗДТГ | - | Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна | Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллаж байгаа бөгөөд 2017 онд нийт 67 төсөл арга хэмжээний 7,5 тэрбум төгрөгийн хөрөрнгө оруулалт батлуулсан нь өнгөрсөн оноос 16,7 хувь буюу 1,5 тэрбум төгргөөр буурчээ. ОНТХО, ОНХС, БХС, АЗСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилж байгаа ба ОНТХО-оос 2017 оны 11-р сарын 07-ны өдрийн байдлаар 1,3 тэрбум, ОНХС-аас 927,0 сая, БХС-аас 2,4 тэрбум, авто замын сангаас 0,3 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээллийг тухай бүр шилэн дансны мэдээллийн системд байршуулж байна. Мөн ОНХСангийн гүйцэтгэлийг ОНХСангийн цахим мэдээллийн программд шивж, сумдын үлдэгдлийг тааруулан ажиллаж байна. | 100 |
| | 259 | 2.6.2.4. Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж, цахим мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх | 2016-2020 | АЗДТГ | - | Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно. | 2017 оны аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, тендер шалгаруулалтын урилгыг худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn сайтаар цахимаар зарлаж, Булган аймгийн албан ёсны цахим хуудас www.bulgan.gov.mn, өдөр тутмын Монголын үнэн сонинд тухай бүр урилгыг нийтлэн ажиллаж байна. Тендер шалгаруулалтын үр дүн, улирлын тайланг дээрх сайт, шилэн дансны нэгдсэн цахим хуудас, өдөр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тутмын сонинд тухай бүр нийтэлж худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна. ХАА-гаар 31 төсөл арга хэмжээний 4849,2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, 4 төсөл арга хэмжээг холбогдох хуулийн дагуу харьяалах сумдын Засаг даргын тамгын газарт тендер зохион байгуулах эрх шилжүүлж, үлдсэн төсөл арга хэмжээний худалдах авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсан ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 93,5 хувьтай байна. | |
| | 260 | 2.6.2.5. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах | 2016-2020 | АЗДТГ | - | Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн цэсэнд холбогдох мэдээллийг тавьж, сум байгууллагад мэдээллийг хэрхэн байршуулах, улирлын тайлан илгээх талаар заавар зөвлөгөө өгч ажиллав. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнга хяналт тавьж тайланг хагас, бүтэн жилээр гарган Сангийн яаманд хүргүүлж байна. 2017 оны хагас жилийн байдлаар шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлсэн байдал 97.2 хувьд хүрсэн. | 100 |
| **/48/** 2.6.3 Нягтлан бодох бүртгэл, аудит, дотоод хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарлагын хэмнэлтэд эерэг нөлөө үзүүлэх, бүх шатны удирдлагад санхүү эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад арга зүйн туслалцаа үзүүлнэ. | 261 | 2.6.3.1. ААНБ-д НББ-ийн хуулийн хэрэгжилтийг хангуулж, НББОУС нэвтрэлтийг эрчимжүүлж, бүртгэлийн ажилтны чадавхийг сайжруулна | 2016-2020 | АЗДТГ, СТСХ | - | Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирна | Аж ахуйн нэгж, байгууллагуудын 2017 оны 02-р улирлын санхүүгийн тайланг шалган хүлээн авч дүнг нэгтгэн Сангийн яаманд хүргүүллээ. Тайлангийн ирц 80,7 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн явцтай танилцан сургалтад хамрагдах болон санхүүгийн тайлангийн программ авах аж ахуйн нэгжийн судалгааг гарган ажиллаж байна. | 100 |
| | 262 | 2.6.3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, | 2016-2020 | АЗДТГ, СХАА | - | Төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих хяналт сайжирна. | Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу сумдын төсөв, санхүүгийн 2016 он, 2017 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, зөвлөн туслах ажлаар 13 сум, 1 тосгонд ажиллалаа. Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, төрийн сангийн үйл ажиллагаа, ил тод байдлыг шалган газар дээр нь заавар, зөвлөгөөг өгч, төсвийн байгууллагын удирдлагуудтай уулзаж, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрсдлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | | | | | тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг сонсож ажилласан. Санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Орон нутгийн Өмчийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Авто тээврийн үйлчилгээний төв, ХААН МСҮТ, 7 сумын төсвийн байгууллага, тусгай санд шалгалт хийн 104 актаар 253.3 сая төгрөгийн төлбөр тогтоож, хугацаатай албан шаардлага 20-ыг өгч, 149 хүнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| | 263 | 2.6.3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг ашиглан, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах | 2016-2020 | АЗДТГ, СТСХ, ОНӨГ | - | Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирна | Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн санд үндсэн хөрөнгийн мэдээллийг бүрэн оруулж, 2016 оны үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг Орон нутгийн өмчит 176 байгууллагаас авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүллээ. Орон нутгийн өмчит байгууллагуудын түрээсийн гэрээг хянан ОНӨГ-т танилцуулагдаагүй, хүсэлт тавиагүй 2 газрын түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, түрээсийн орлогыг аймгийн түрээсийн орлогын дансанд, нийтийн дуудлага худалдаа 8 удаа зохион байгуулж анхны үнэ 25.5 сая төгрөгийн 13 тээврийн хэрэгслийг 46,5 сая төгрөгөөр худалдан борлуулж аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд тус тус төвлөрүүллээ. Орон нутгийн өмчит ААТҮГ, ХХК-иудад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчидтэй хамтарсан шалгалт хийж, “Илчит Хутаг”, “Тэшиг ус” компанид цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлж, “Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн” ААТҮГ, “Шахмал Түлш” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, Аймгийн нөөцийн газрын статусыг өөрчлөн ААТҮГ-ын хэлбэрээр зохион байгуулан ажиллуулж байна. Булган сумын 1, 2, 3, 4, 6, 7 дугаар цэцэрлэг, Тэшиг, Хутаг-Өндөр, Сайхан, Баян-Агт сумын төсвийн байгууллагуудын 2017 оны Өмч эзэмшлийн гэрээг дүгнээд байна. | 100 |
| | 264 | 2.6.3.4. Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод | 2016-2020 | АЗДТГ | - | Нягтлан бодох | Төрийн сангийн үйл ажиллагаанд хийгдэх дотоод хяналтаар батлагдсан төсвийн дагуу эрх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах | | | | бүртгэлээр тавих хяналт сайжирна | нээсэн эсэх, төсвийн байгууллагын гарын үсгийн баталгааны маягтын дагуу хянасан эсэх, холбогдох журмын дагуу төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг хянан хүлээн авч алдаатай гүйлгээг залруулж ажиллаж байгаа эсэх, засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд мөрдөх журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа талаар дотоод хяналтаар 14 сум, 1 тосгонд зөвлөн туслахаар ажиллаж, зөвлөгөө, заавар өгсөн. Булган суманд шинээр байгуулагдсан 3-р 12 жилийн дунд сургуулийн бүртгэлийн дансыг Засгийн газрын санхүү удирдлагын мэдээллийн системд үүсгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлж, үйл ажиллагааг нь эхлүүллээ. | 100 |
| **/49/** 2.6.4 Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангана. | 265 | 2.6.4.1. Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирч болох эрсдлийг бууруулах, даатгалын ач холбогдлыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлэх | 2016-2020 | АЗДТГ | - | Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирч болох эрсдэл буурч, даатгуулагчдын тоо нэмэгдсэн байна. | Авто тээврийн үзлэг, оношилгоо, татвар хураалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулан, үзлэгийн явцад гадны дугаартай авто машинуудыг Булган дугаартай болгох ажлыг зохион байгууллаа. Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоор 268,1 сая төгрөг, авто зам ашигласны хураамжийн орлогоор 51,5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүллээ. Даатгалын компаниуд 7075 хувь хүн, хуулийн этгээдийг даатгалд хамруулан, хураамжийн орлогоор 252,3 сая төгрөгийн орлого оруулаад байна. Нийт 47 иргэн, хуулийн этгээдэд 29,5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна. | 100 |
| | 266 | 2.6.4.2. Брокерийн компани, бичил санхүүгийн /банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо/ үйл ажиллагааг дэмжин ажиллах | 2016-2020 | АЗДТГ | - | Санхүүгийн зах зээл тодорхой хэмжээгээр хөгжсөн байна. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан заавар зөвлөгөө өгч ажиллав. Аймгийн Татварын хэлтэс, Цагдаагийн газартай хамтран Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийн, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй ББС байгууллагын талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн ажиллав. Санхүүгийн зохицуулах хорооны орон нутгийн төлөөлөгч болон Хадгаламж зээлийн хоршооны дарга | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдлагууд Хадгаламж зээлийн хоршоодын хөгжлийн чуулганд оролцлоо. | |
| **ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**<br>**3.1. Зам, тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбоо, барилгын салбарыг хөгжүүлж, орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | |
| **<u>Зам, тээврийн чиглэлээр:</u>** | | | | | | | | |
| **/50/** 3.1.1. Авто замын сүлжээг сайжруулж, зарим сумын төвийн авто замыг хатуу хучилттай болгоход улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжинэ. | 267 | 3.1.1.1. Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх | 2018-2020 | АЗДТГ | Улсын төсөв /концесс/ | Босоо тэнхлэгийн авто зам, замын байгууламж барилга угсралтын ажил эхэлсэн байна. | Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын трассын дагуу эхний ээлжинд Булган-Орхон чиглэлийн 22 км замыг эхлүүлэхээр Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар 1,9 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлээд байна. | 40 |
| | 268 | 3.1.1.2. Аймаг, орон нутгийн авто замын сүлжээг сайжруулж, зарим сумын төвийн болон бусад чиглэлийн авто замыг ээлж дараатайгаар хатуу хучилттай болгох | 2017-2020 | АЗДТГ, СЗД | Улсын төсөв | Авто зам, замын байгууламж сайжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана | Нэгдсэн эмнэлгийн урдаас “НИК” ШТС-ын зүүн уулзвар хүртэлх 314,7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 0,482 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлыг “Булган-АЗЗА” ТӨХК гүйцэтгэн, 2017 оны 08 дугаар сард улсын комисс хүлээн авав. Булган сумын төв гудамжны 0,925 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг “Сэлэнгэ Есөн Эрдэнэ” ХХК 491,2 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээтэй ажиллаж байгаа ба ажлын явц 90,0 хувьтай байна. | 100 |
| | 269 | 3.1.1.3. Тэшиг сумын далан багт Эгийн гол, Хутаг-Өндөр сумын Тээл багийн Далангийн аманд гатлага онгоц байрлуулах, Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 437.02 метр урт төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулах | 2016-2017 | АЗДТГ, СЗД | ОНТөсөв | Гатлага онгоц суурилуулж, төмөр бетон гүүр ашиглалтад орсон байна. | Тэшиг сумын Далан багт Эгийн голын гаталга онгоц суурилуулах ажлыг Орхон аймгийн “Өлзий хутагын наран” ХХК гүйцэтгэж байгаа ба ажлын явц 90,0 хувьтай байна. Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 437,02 у/м төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажлыг “Хотгор зам” ХХК гүйцэтгэж, 2017 оны 09 дүгээр сард улсын комисст хүлээлгэн өгч, хөдөлгөөнийг нээв. | 100 |
| | 270 | 3.1.1.4. Эрдэнэт-Хялганатын чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох асуудлыг уулын баяжуулах Эрдэнэт | 2016-2020 | АЗДТГ, СЗД | Улсын төсөв | Тухайн чиглэлийн авто зам, замын байгууламж сайжирч замын хөдөлгөөний аюулгүй | МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.107.24 дэх заалтад тусгагдан 2018-2020 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болно. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэртэй хамтран шийдвэрлэх | | | | байдал хангагдана. | | |
| **/51/** 3.1.2. Аймгийн төвийн авто зам, замын байгууламжийг сайжруулах, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, автомашины зогсоолыг шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ. | 271 | 3.1.2.1. Авто замын зураг төсөв бүхий ажлуудыг үргэлжлүүлэн хийх | 2016-2020 | АЗДТГ, СЗД | 314,7 | Булган сумын авто замын нэвтрэх чадвар сайжирч, замын байгууламж, уулзвар, авто зогсоолын талбай нэмэгдэнэ. | Нэгдсэн эмнэлгийн урд талаас НИК ШТС хүртэлх 0,482 км хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэгчийг ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу шалгаруулсан ба "Булган АЗЗА" ТӨХК тухайн авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж 2017 оны 08 сард улсын комисст хүлээлгэн өгөв. | 100 |
| | 272 | 3.1.2.2. Дашчойнхорлин хийд-Цагаан суваргатай холбох авто зам шинээр барих | 2017-2020 | АЗДТГ, СЗД | Улсын төсөв | Аялагч, жуулчдын ая тухтай зорчих нөхцөл бүрдэнэ. | Дашчойнхорлин хийд-Цагаан суварга орчмыг ерөнхий төлөвлөгөөтэй болгож аялал жуулчлалын бүсийн иж бүрэн цогцолборын дэд бүтцийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Дашчойнхорлон хийд Цагаан суврага чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлын даалгаврыг боловсруулж, Геодезийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэв. Тухайн авто зам, замын байгууламжийн зураг төслийг гүйцэтгүүлэх хөрөнгийг 2018 оны төсөвт тусгах шаардлагатай байна. | 40 |
| | 273 | 3.1.2.3. Булган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу авто зогсоолын хүчин чадлыг ээлж дараатай нэмэгдүүлэх | 2016-2020 | АЗДТГ, АТТ | Хувийн хэвшлийн хөрөнгө | Аймгийн төвийн хөдөлгөөний нэвтрэх чадвар нэмэгдсэн байна. | Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 24 цэгт авто зогсоолын талбай байгуулахаар зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэнээс 14 цэгт 6658,1 м2 талбай бүхий авто зогсоол байгуулав. Үлдсэн 10 зогсоолын талбай байгуулахад 206,8 сая төгрөг шаардлагатай байна. | 100 |
| | 274 | 3.1.2.4. Булган хотын төв зам дагуух орц, гарцууд дээр "Хүндэтгэлийн хаалга" хийх | 2016-2020 | АЗДТГ, Булган сум | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Шинээр 2 хаалга барьж, 1 хаалгыг сэргээн засварлана. | Тулгат хөшөө барихаар зураг төсөл нь шалгарсан, хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай байна. | 40 |
| **/52/** 3.1.3. Булган суманд нийтийн тээврийн үйлчилгээг тогтмолжуулж, алсын сумдад хүргэх шуудангийн | 275 | 3.1.3.1. Нийтийн зорчигч тээврийн "Авто вокзал"-ын барилга барих | 2016-2019 | АЗДТГ, ГХБХБГ | Улсын төсөв | "Нийтийн зорчигч үйлчилгээний цогцолбор" ашиглалтад орсон байна. | Зураг, төсөв хийгдэж, улсын экспертизээр баталгаажуулагдсан. Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санал ирээгүй байна. Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хандав. | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. | 276 | 3.1.3.2. Хөвсгөл-Булган-Улаанбаатар хооронд зорчих урсгалыг нэмэгдүүлэх | 2016-2020 | АЗДТГ, АТТ | Хувийн хэвшлийн хөрөнгө | Шинээр маршрут нээгдэж, үйл ажиллагаа тогтворжсон байна | Аймгийн зорчигч, шуудан тээврийг зохицуулах зөвлөлийн хурлаар Булган-Улаанбаатар чиглэлийн шинэ маршрут нээх асуудлыг хэлэлцэж, Зам, тээврийн хөгжлийн яаманд саналаа уламжлаад байна. | 0 |
| | 277 | 3.1.3.3. Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулах | 2016-2020 | АЗДТГ, СЗД, АТТ | ОНТөсөв, Хувийн хэвшлийн хөрөнгө | Нийтийн тээврийн автобусны үйлчилгээ тогтмолжсон байна. | Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулах асуудлаар Автотээврийн төв, Булган сумын ЗДТГ-т чиглэл болгоод байна. Тус үйлчилгээг тогтмолжуулах талаар сонирхогч этгээдээс санал ирээгүй байна. | 40 |
| | 278 | 3.1.3.4 Алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | 2016-2020 | АЗДТГ, СЗД, АТТ, ШҮГ | Хувийн хэвшлийн хөрөнгө | Алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоо нэмэгдсэн байна. | Алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх асуудлаар "Монгол шуудан" ТӨХК-ийн Булган аймаг дахь салбарт чиглэл хүргүүлэв. | 40 |
| **<u>Эрчим хүчний чиглэлээр:</u>** | | | | | | | | |
| ***/53/*** 3.1.4. Аймгийн төв болон сумдад бий болох шинэ суурьшлын бүсүүдэд эрчим хүчний асуудлыг шат дараатай-гаар шийдвэрлэж, эрчим хүчний хангамж муутай, доголдолтой газ-руудад шинэчлэл хийж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгоно. | 279 | 3.1.4.1. Булган сумын Дулааны станцыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах | 2016-2017 он | "Энержи Плас" ХХК АЗДТГ, ГХБХБГ | Орон нутгийн хөгжлийн сангийн 430,6 сая төгрөг, хувийн хэвшлийн хөрөнгө | Байгаль орчны бохирдол буурч иргэдийн аюулгүй тухтай амьдрах нөхцөл сайжирсан байна. | Дулааны станцын 2017 онд хэрэгжих барилга угсралтын ажлыг 6 дугаар сараас эхлэхээр төлөвлөгөө, график гарган гүйцэтгэгч "Энержи плас" ХХК, Эрчим хүчний хөгжлийн төвөөс ирүүлсэн боловч станцын барилга угсралтын ажил 9 дүгээр сар хүртэлх хугацаанд зогсонги байдалтай байсан. Дулааны станцын барилга угсралтын явцын талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулга, мэдээлэл хийж, Монгол улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төвд дулааны станцыг 2017 онд багтаан ашиглалтад оруулах асуудлыг тавьсан. Үүний үр дүнд Монгл улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 258 дугаар тогтоолоор дулааны станцыг ажиллагаанд залгахад 800.0 сая төгрөгийг шийдвэрлэж, "Энержи Плас" ХХК барилга угсралтын ажлыг 9 дүгээр сарын 13-нд эхэлсэн. Хөрөнгө оруулагч "Энержи Плас"-ын ажлын явцад Эрчим хүчний хөгжлийн төвөөс хяналт тавьж байна. 2017 оны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 10 дугаар сарын 24-ны байдлаар КИП автоматик, цахилгаан хангамжийн ажлыг бүрэн гүйцэтгэж, барилга угсралтын ажил 85.0 хувь, дулааны станцын 1 дүгээр зуухыг ажиллагаанд залгахад бэлэн болсон. Дулааны станцыг ашиглалтад орохтой холбогдуулан орон нутгийн хөгжлийн сангийн 430.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулаан дамжуулах 3 төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. “Альянс тех” ХХК дулаан дамжуулах 3 төвийн ялтсан бойлер, түүний тоног төхөөрөмжийг суурилуулах, 1 дүгээр хэлхээг холбох ажил хийж байна. 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дулаан дамжуулах төвийн цахилгаан хангамж, 2 дугаар хэлхээг холбох ажлыг гүйцэтгэхээр төлөвлөөд байна. | |
| | 280 | 3.1.4.2. Аймгийн төв, сумдын эрчим хүчний хуучирсан, шугам сүлжээ, эрчим хүчний хангамж муутай, доголдолтой газруудад шинэчлэл хийх | 2017-2020 он | “ЭБЦТС” ТӨХК, АЗДТГ, ГХБХБГ | “ЭБЦТС” ТӨХК-ийн хөрөнгө оруулал-таар 2016 оны 193,4 сая 2017 онд 220,0 сая төгрөг | Эрчим хүчний найдвартай ажиллагаа хангагдана | 2016 онд Баян-Агт сумын 10 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Бүрэгхангай сумын 35 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Булган сумын “Балгас”, “Зүүн түрүү”, “Буриадын хороо”, “Хөрөө рам”-ын 0,4 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг засварласан. 2017 онд “ЭБЦТС” ТӨХК-ий 220.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон, Могод Дашинчилэн, Баяннуур, Тэшиг сумын 0.4, 0.22 квт-ын ЦДАШ, Орхон Сайхан, Тэшиг сумын 10 квт-ын ЦДАШ, Дашинчилэн сумын 35 квт-ын дэд станцыг засварлаж, Булган сумын 6Д хороонд дэд станц барьж, Хутаг-Өндөр сумын дэд станцаас Тэшиг сумын гаргалгааг вакум таслуураар сольсон. | 100 |
| | 281 | 3.1.4.3. Дулааны станцын цахилгаан хангамжийг сайжруулан, нэг хэлхээ газрын кабелиар аваарын нөөц цахилгаан эх үүсвэртэй болгох | 2016-2017 | АЗДТГ, “ЭБЦТС” ТӨХК | Орон нутгийн хөгжлийн сангийн 8,0 сая төгрөг | Дулаан станцын хэвийн үйл ажиллагаа хангагдана | Булган сумын дулааны станцын цахилгааны нөөц эх үүсвэрийн барилга байгууламж барих ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Шаардагдах 375,0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв, “Дэлхийн банкны эрчим хүчний 2 дугаар төсөл”-д санал хүсэлт тавиад байна. | 40 |
| | 282 | 3.1.4.4. Зарим сумдын цахилгаан дамжуулах | 2017-2020 | АЗДТГ, “ЭБЦТС” | | Эрчим хүчний найдвартай | Булган сумын төвийн одоо байгаа модон тулгуурт агаарын 0,4 кв-ийн хуучирсан шугамыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | агаарын шугамыг бетонон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэх | | ТӨХК | "ЭБЦТС" ТӨХК-ийн хөрөнгө оруулалт 105,4 сая төгрөг | ажиллагаа сайжирна | төмөр бетон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэх ажлыг Дэлхийн банкны зээлээр хэрэгжих "Дэлхийн банкны эрчим хүчний 2 дугаар төсөл"-өөр хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлж, аймгаас шаардлагатай тооцоо, судалгааг гарган, хамтран ажиллаж байна. Шугам сүлжээ, барилга угсралтын ажил 2018 оны 4 дүгээр сард эхлүүлэхээр болсон. 2017 онд "ЭБЦТС" ТӨХК-иас Булган сумын Нисэх, Орхон чиглэлийн агаарын шугамыг бетонон тулгуур болгон шинэчилж, Булган сумын 6Д хороонд дэд станц барьж, ашиглалтад оруулсан. | |
| | 283 | 3.1.4.5. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг гудамж хорооллын гэрэлтүүлэгт ашиглаж, зарим төвлөр-сөн багийг цахилгааны эх үүсвэртэй болгох | 2017-2020 | АЗДТГ, "ЭБЦТС" ТӨХК | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт | Гэр хорооллын амьдрах орчин сайжирч, цахилгааны эх үүсвэр нэмэгдэнэ | Орхон сумын нутаг "Домын дэвсэг" орчимд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар 84 га газрыг сонгож, төлөвлөөд байна. | 0 |
| | 284 | 3.1.4.6. Булган сумын орон сууцны айл өрхүүдийг ээлж дараатайгаар хэрэглээний халуун устай болгох | 2017-2020 | АЗДТГ, ГХБХБГ | Төр, хувийн хэвшлийн хөрөнгө | Хэрэглэгчийн сэтгэл ханамж нэмэгдэж, найдвартай ажиллагаа хангагдана | Булган сумын орон сууц, албан байгууллагуудыг хэрэглээний халуун усны шугамд холбох, барилгын дотор системийг шинэчлэх зураг төслийг хийлгэхээр Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 247.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах шатанд явж байна. Уг бүтээн байгуулалтын зураг төслийг хийлгэснээр "Булган Мэээж" ХХК болон бусад оролцогчдыг ашиглагч иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах нөхцлийг дараагийн шатанд зохион байгуулна. | 70 |
| **<u>Мэдээлэл, холбооны чиглэлээр:</u>** | | | | | | | | |
| **/54/** 3.1.5. Хэрэглэгчдэд сүүлийн үеийн дэвшилтэт технологийн гурвалсан болон шилэн кабелийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | 285 | 3.1.5.1. Өндөр хурдны сүлжээнд холбогдсон сумдын төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, айл өрхөд шилэн кабель хүргэж, интернетэд холбогдох боломжийг бүрдүүлэх | 2016-2020 | МТШХХГ, ХХЗХ | Улсын төсөв | Шилэн кабельд холбогдоогүй сумдын холбогдох хэрэглэгчид үйлчилгээ авсан байна. | Шинээр ашиглалтад орж буй барилгыг шилэн кабельд холбох арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Харилцаа холбоо, мэвээллийн технологийн газарт 2017 оны бүх нийтийн сангийн хөрөнгө оруулалтад тусгах саналаа хүргүүлсэн ба Хишиг-Өндөрөөс бусад сумд шилэн кабельд холбогдоод байна. | 70 |
| | 286 | 3.1.5.2. Аймаг, сумын | 2016- | МТШХХГ | Улсын | Аймаг, сумын | "МЦХ" ХК-ийн тус аймаг дахь салбар 2017 онд 8 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвүүдэд болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернетэд холбогдох WI-FI орчныг нэмэгдүүлэх | 2020 | , ХХЗХ | төсөв | төвүүдэд болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернетэд холбогдох WI-FI орчин нэмэгдсэн байна. | суурин газарт WI-FI төхөөрөмж суурилуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба аймгийн төвийн Цаг уур, 6а хорооны 1-р гудамж, Баян-Агт сумын Хануй рашаан, Бугат, Дашинчилэн, Рашаант, Баяннуур, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумд болон Хялганат тосгонд нийт 20 ш WI-FI төхөөрөмжийг суурилуулав. | |
| | 287 | 3.1.5.3. Өндөр хурдны телевизийн дохио дамжуулах "IPTV" технологи нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийн гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих | 2016-2020 | МТШХХГ, ХХЗХ | Улсын төсөв | Сүүлийн үеийн дэвшилтэт технологийн гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх боломж бүрдсэн байна. | Аймгийн Засаг даргын 2017 оны 01/ тоот албан бичгээр "Юнивишн" ХХК-д "Иргэдийн ая тухтай ажиллах амьдрах боломжийг бүрдүүлэх, мэдээллийг цаг алдалгүй УБ хотын иргэдтэй ижил түвшинд хүртээмжтэй авч байх үүднээс танай компаний гурвалсан үйлчилгээг эхний ээлжинд Булган суманд нэвтрүүлэх" хүсэлт хүргүүлэв. Гурвалсан интернетийн үйлчилгээг 2017 оны 2 дугаар улиралд нэвтрүүлж эхлээд байгаа ба 2017 оны 3 дугаар улирлын байдлаар "Гэр интернет"-ийн хэрэглэгч 570 гаруй болоод байна. | 100 |
| | 288 | 3.1.5.4. Үүрэн холбооны оператор компаниудад 4G технологи нэвтрүүлэх ажлыг дэмжих | 2016-2020 | МТШХХГ, ХХЗХ | Улсын төсөв | 4G технологи нэвтэрсэн байна. | 4G технологийг "Юнивишн" ХХК, "Мобиком" ХХК-ууд нэвтрүүлээд байна. | 100 |
| **Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:** | | | | | | | | |
| **/55/** 3.1.6. Баригдаж дуусаагүй барилга байгууламжуудыг дуусгахад анхаарал хандуулж, орон сууцны хорооллыг байгуулж, иргэдийн амьдрах орчинг сайжруулна. | 289 | 3.1.6.1. Аймгийн төв болон сумдад баригдаж байгаа дуусаагүй барилга, байгууламжийг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах | 2016-2020 | АЗДТГ, ГХБХБГ | Улс, ОНТөсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Дуусаагүй барилга ашиглалтад орсон байна | 2016 онд "Сумын төвийн шинэчлэл" төслөөр Хутаг-Өндөр сумын инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг иж бүрнээр барих ажлыг улсын төсвийн 4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд халаалтын зуухны барилгыг засварлаж, 1.2 мВт-ын 2 ширхэг тогоо, 1.4 мВт-ын 1 ширхэг тогоо, 2.6 км дулаан, цэвэр, 2,6 км бохир усны шугам, 50 $м^3$ багтаамжтай усан сан, цэвэр усны 2 худаг, цэвэрлэх байгууламж барьж, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглалтад оруулсан. “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Могод суманд 220 метр дулааны шугам сүлжээ шинээр барьж, үйлчилгээний 6 газрыг нэгдсэн халаалтад холболоо. 2016 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Бугат сумыг нэгдсэн халаалтад шилжүүлж, Орхон сумын халаалтын тогооны барилга, халаалтын тогоо, тоног төхөөрөмжийг шинэчлэн ашиглалтад оруулլаа. 2017 онд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Рашаант суманд төвлөрсөн халаалтын зуух, дулааны шугам сүлжээ барьж, ашиглалтад оруулсан. Мөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө орууулалтаар Хялганат тосгонд иж бүрэн инженерийн байгууламж барьж ашиглалтад оруулав. Үүний үр дүнд 4 сум иж бүрэн инженерийн шугам сүлжээтэй болж, 11 сум төвлөрсөн халаалттай болсон. 2018 онд Хялганат тосгоны ОБГ-ын харьяа гал унтраах 50 дугаар анги, Эрүүл мэндийн төв, Үйлдвэр технологийн паркийг төвлөрсөн цэвэр усан хангамжид холбоход 107,5 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. | |
| | 290 | 3.1.6.2. Орон сууц барихад дэмжлэг үзүүлж, 200-аас доошгүй айлын орон сууц ашиглалтад оруулах | 2016-2020 | АЗДТГ, ГХБХБГ | Улс, ОНТөсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 200-гаас доошгүй айлын орон сууц баригдсан байна | Булган сум болон инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн Бүрэгхангай, Тэшиг, Хутаг-Өндөр зэрэг сумдад нийтийн орон сууц барих нөхцөл бүрдсэн. Холбогдох заавар зөвлөмжийг газрын даамлуудад чиглэл болгон гарын авлага хэлбэрээр өгч байна. Бүрэгхангай суманд шинээр баригдаж буй 12 айлын нийтийн орон сууцны барилга барихад шаардлагатай мэдээллийг тус сумын удирдлагуудад өгсөн бөгөөд энэ онд барилгын суурийг хийсэн, 2018 онд ашиглалтад оруулна. Мөн Булган сумын 5-р багт баригдаж буй 25 айлын Аваргууд хотхон 2018 оны 12 дугаар сард ашиглалтад орно. | 40 |
| | 291 | 3.1.6.3. Аймаг, сумын төвүүдийн гэр хорооллын гудамж, нийтийн | 2017-2020 | АЗДТГ, ГХБХБГ | Хувийн хэвшил, ОНТөсө | Гэр хорооллын гудамжны | Булган 3 дугаар багийн 3-ын б хэсгийн 8 дугаар гудамжны урд, 5 дугаар баг 1 дүгээр сургуулийн хойд тал, 1 дүгээр багийн хийдийн зүүн талд, 2 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эзэмшлийн талбайг иргэдийн санаачлага, оролцоонд тулгуурлан гэрэлтүүлэг, тоглоомын талбайтай болгож, хаягжуулах, тохижилтын асуудлыг цогцоор шийдвэрлэх | | | в | өнгө үзэмж хаягжилт сайжирч, иргэдийн санаачлага, оролцоонд тулгуурлан жишиг гудамж бий болгоно | дугаар багийн Б, В хэсгийн дунд сумын орон нутгийн хөгжлийн сангаас нийт 10 сая төгрөгөөр 4 байршилд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг зохион байгууллаа. 2018 онд орон нутгийн төсвөөр гэр хорооллын гудамж бүрийг гэрэлтүүлэгтэй болгохоор зураг төслийн тедерийг зарлаад байна. | |
| | 292 | 3.1.6.4. Аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэнг шинэчлэх | 2017 оны 10 сар | АЗДТГ, ГХБХБГ | 1,5 тэрбум төгрөг | Өнгө үзэмж багтаамж нэмэгдсэн байна | Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд Цэнгэлдэх хүрээлэнг засварлах ажлын зургийг “ББСМО” ХХК-т санал тавьсны дагуу ажлын зураг төсвийг хийлгүүлсэн. Төсөвт өртөг 250 сая төгрөг. Тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах шатандаа байна. | 40 |
| | 293 | 3.1.6.5. Сумын төвүүдийг төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр, бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | 2017 оны 10 сар | АЗДТГ, ГХБХБГ | 358 849 411 төгрөг | Иж бүрэн инженерийн шугам сүлжээтэй болж, оршин суугчдын ажиллаж амьдрах орчин сайжирна | Хялганат тосгоны цэвэр усан хангамжийн ажилд Улаанбаатар хотын “Туст Эр” ХХК шалгарч 358 849 411 төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2017 оны 11 сард ашиглалтад оруулна. Хялганат тосгонд 25 м3/хоног хүчин чадалтай биологийн цэвэрлэх байгууламжийг Орхон аймгийн “Борхууд” ХХК 183 583 455 төгрөгөөр гүйцэтгэж туршилт тохируулгыг хийлээ. Булган сумын ЭӨЦС-ийн халаалтын зууханд 2 ширхэг, Үйлдвэр, 36 айл, МСҮТ, Шүүхийн зууханд тус тус 1, нийт 6 тогоог шинэчилж, үйлдвэрийн зуухнаас “Дэвшилт” ХХК хүртэлх 225 метр, Андууд төвийн 180 метр, 8 дугаар байрны 40 метр дулаан, цэвэр усны шугамыг шинэчилж, Залуус хорооллын 15 дугаар ус түгээх байр, “Дэлгэрэх Өргөө” хотхоны орон сууцыг цэвэр усны төв шугамд холбох ажлыг “Булган Мээж” ХХК-аар гүйцэтгүүллээ. | 100 |
| | 294 | 3.1.6.6. Булган хотын үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдэд инженерийн дэд бүтэц байгуулах | 2017 оны 8 сар | АЗДТГ, ГХБХБГ | Улс, ОНТөсөв | Үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдийн цахилгаан, цэвэр усны хэрэгцээ | Судалгааны ажил хийгдэж байна. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангагдана | | |
| | 295 | 3.1.6.7. Булган сумын үерийн ус зайлуулах суваг, даланг шинэчлэх | 2017 оны 10 сар | АЗДТГ, ГХБХБГ, ОБГ | Улс, ОНТөсөв | Үерийн усны учирч болох эрсдлээс иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг хамгаалагдах | Булган сумын үерийн ус зайлуулах суваг, даланг шинэчлэх зураг төслийг “Гидросоружение” ХХК боловсруулсан. Уг зураг төслийн дагуу эхний ээлжинд /2017 онд/ 1-р багийн 6.0, 6.1, 6.2, 6.4, 6-р багийн 2.0, 2.1 трассын үерийн байгууламжийг “Туруун бүтээмж” ХХК гүйцэтгэж улсын комиссоор хүлээн авав. | 70 |
| ***/56/*** 3.1.7. Иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглана. | 296 | 3.1.7.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах | 2017 он | АЗДТГ, ГХБХБГ | Улс, ОНТөсөв | Газар ашиглах, хамгаалах асуудал оновчтой байгуулагдсан байна | 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн аймгийн ИТХ-ын IV хуралдааны 04/03 дугаар тогтоолын хүрээнд аймгийн ИТХ-ын 2006 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангалттай хэрэгжсэн, цаашид мөрдөж ажиллах шаардлага хангах боломжгүй гэж дүгнэж “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэн хийлгэхийг аймгийн Засаг даргад даалгасан тогтоол гаргасан. 2018 оны аймгийн төсөвт газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх хөрөнгийг суулгуулахаар БХБЯ-наас баталсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотголтой нийцүүлж, газар ашиглалтын зориулалт бүрээр газрын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох” техник, эдийн засгийн үндэслэл ашиглан тооцоог гаргаж аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т 2017.09.15-ны 01/615 албан бичгээр хүргүүллээ. /Төсөвт өртөг-743 402 911 төгрөг/ | 70 |
| | 297 | 3.1.7.2. Газрын шинэтгэлийн ажлыг эрчимжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад газар эзэмшүүлэх ажлыг 20 хувиар, газрыг иргэн бүрт үнэ төлбөргүй өмчлүүлэх ажлыг 25 хувиар өсгөж, эдийн засгийн эргэлтэд | 2017 он | АЗДТГ, СЗД, ГХБХБГ | ОНТөсөв | Газар эзэмшүүлэх ажил 20 өмчлүүлэх ажил 20 хувиар өссөн байна. | 2017 оны 3-р улирлын байдлаар **571** иргэн өргөдөл ирүүлснээс **267** иргэнд **36** га газрыг өмчлүүлж өссөн дүнгээр **13794** иргэн өргөдөл ирүүлснээс **13495** иргэнд **2264.38** га газрыг өмчлүүлж төлөвлөгөөний биелэлт **19%**-тай, статистикийн хүн амын 2016 оны **61149** иргэнд харьцуулахад **22%**-тай газар өмчлөлийн ажил явагдаж байна. Сумдаар авч үзвэл: Баян-Агт сум 1 иргэнд 0,08, Баяннуур сум 2 иргэнд 0.23, Бугат сум 3 иргэнд 0.82, Булган сум 127 иргэнд | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулах боломжийг бий болгох | | | | | 16,1, Бүрэгхангай сум 12 иргэнд 1,08, Гурванбулаг сум 26 иргэнд 2,32, Дашинчилэн сум 31 иргэнд 3,64, Могод сум 6 иргэнд 0,54, Сайхан сум 11 иргэнд 1,39, Сэлэнгэ сум 6 иргэнд 0,86, Тэшиг сум 24 иргэнд 6,21, Хангал сум 8 иргэнд 0.96, Хишиг-Өндөр сум 5 иргэнд 0,42, Хутаг-Өндөр сум 5 иргэнд 1,34 га газрыг тус тус өмчлүүллээ. Орхон, Рашаант сумд газар өмчлөх шийдвэр гаргаагүй байна. Газар өмчлөлийн ажил удааширалттай явагдаж байгаатай холбогдуулан газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллах талаар сумдын Засаг дарга нарт 2017 оны 9-р сарын 28-ны өдрийн А/644 дүгээр албан тоотоор чиглэл хүргүүлэв. Аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр Булган сумын багуудад ажиллахдаа газар өмчлөлийн гарын авлага 80 гаруй иргэдэд тараан, иргэдийн асуултад хариулт өгч заавар, зөвлөмж өгч ажиллаа._Түүнчлэн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр иргэдийн оролцоонд тулгуурлан төлөвлөх, зөв зохистой ашиглаж хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд анх удаа Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2017 оны 12 дугаар сардаа багтаан боловсруулж ИТХ-ын тогтоолооор батлуулж ажиллах талаар мэргэжлийн байгууллага “Вектор мэп” ХХК-тэй 31.324 мянган төгрөгөөр гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| | 298 | 3.1.7.3. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, “Лэнд менежер” программ хангамжийг нэвтрүүлэх | 2017 он | ГХБХБГ | ОНТөсөв | 15 суманд "Газрын кадастрын мэдээллийн сан"-гийн "Ланд менежер" програмыг нэвтрүүлнэ. | Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2017 оны 9 дүгээр сарын 16-наас 20-ны хооронд 15 сум, 1 тосгоны газрын даамал нарт газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн сургалтыг зохион байгуулж 2650,0 мянган төгрөгний өртөгтэй тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч, ГЗБГЗЗГазрын даргын 2017 оны А/221 дүгээр тушаалаар 2017 оны 9 дүгээр сарын 25-наас эхлэн ЛМ2 программ хангамжийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн хэмжээнд 100 хувь нэвтрүүлэн иргэдэд газрын талаарх үйлчилгээг цахимаар хүргэж эхэллээ. | |
| | 299 | 3.1.7.4. Төвлөрсөн зам дагуух аймгийн хилийн цэсийг баталгаажуулж, Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбаруудыг босгох, газрыг аялал жуучлал, худалдаа үйлчилгээ, фермерийн зориулалтаар олгох асуудлыг шийдвэрлэх | 2017 он | АЗДТГ, ГХБХБГ | ОНТөсө в | Аялал жуулчид мэдээлэл авах, тэдний түр амрах нөхцөл бүрдэхээс гадна фермерийн аж ахуйн хөгжил дээшилнэ | МУ-ын хаягжуулалтын тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө хаягжуулах" журмын дагуу тус ажлыг "Геокад" ХХК хийж гүйцэтгэснийг 16 сумдад хүлээлгэн өгч, хаягжуулах үйл ажиллагааны дагуу сумдын хаягийн самбар, тэмдэг зэргийг байрлуулахад шаардагдах зардлыг сумынхаа төсөвт суулгуулан ажиллах чиглэлийг хүргүүлж тус ажил бүрэн хийгдсэн. Мөн 2018-2020 оны аймгийн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтанд 2018-2020 оны хооронд хаягын тэмдэг, самбарыг байрлуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төсөв тооцоог гарган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т 2017.09.15-ны 01/615 тоот албан бичгийн хавсралтаар хүргүүллээ. /Төсөвт өртөг-375 409 000 төгрөг/ | 100 |
| | 300 | 3.1.7.5. Газрын төлбөрийн орлогын зохих хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээнд зарцуулах асуудлыг жил бүр төлөвлөн баталгаажуулж, хэрэгжилтийг хангах ажиллах | 2017 он | АЗДТГ, ГХБХБГ | 6 сая төгрөг | Хуулийн хэрэгжилт хангагдана | Аймгийн ИТХ-ын 2016 оны 03/13 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2017 оны төсвийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд сумын газрын даамлуудыг GPS-ээр хангахаар тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргаар "Гэрээ байгуулах эрх олгох тухай" 2017 оны А/236 дугаар захирамжийг гаргуулан газрын даргын 2017 оны А/26 тушаалаар ажлын хэсэг байгуулж GPS нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, "Аянчин" Аутфиттерс ХХК-ийг шалгаруулж нийтдээ 6 сая төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг GPS-ийг худалдан авах гэрээ байгуулан 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдөр бүтээгдэхүүнийг актаар хүлээн авч сумдад хүлээлгэн өглөө. | 100 |
| **ДӨРӨВ. ЗӨВ ЗАСАГЛАЛ**<br>**4.1.Төрийн албаны уламжлал шинэчлэлийг хослуулан, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шинжилгээ, дотоод аудит тогтмолжсон, эдийн засгийн үр өгөөжтэй гадаад харилцааг бэхжүүлэн, ИРГЭНДЭЭ ОЙР, МЭРГЭШСЭН, ТОГТВОРТОЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| **/57/** 4.1.1. Зөв бодлогыг үр дүнд | 301 | 4.1.1.1. Иргэдийн санал, санаачлагаар | 2016-2020 | АЗДТГ | - | Иргэдийн санал, | Аймгийн Засаг даргын Зөвлөхөөр ахлуулсан төслийн нэгж 9 иргэний төслийг хүлээн авч, | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хүргэхийг зорьж ажиллана. | | дэмжигдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах төслийн баг томилж ажиллуулах | | | | санаачлагыг байнга сонсдог түүнийг хэрэгжүүлдэг төслийн баг ажиллаж хэвших | Англи, Хятад хэл дээр орчуулсан. Цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай холбон санхүүжилтийг шийдвэрлэх боломжийг судалж байна. 2017 оны аймгийн хэмжээний төсөл, хөтөлбөрийн суурь судалгаануудыг хийж дуусган, цаашид мэргэжлийн байгууллагуудад нь хариуцуулж ажиллуулах болсон тул Төслийн багийг татан буулгасан. | |
| | 302 | 4.1.1.2. Орхон аймагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах | 2016-2020 | АЗДТГ | - | Гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Орхон аймагтай 2016-2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулан, 58 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 2017 оны байдлаар 30 хувийн хэрэгжилттэй байна. Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. | 70 |
| | 303 | 4.1.1.3. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах | 2016-2020 | АЗДТГ | ОНТ, Хандив туслам ж | Тусгай төлөвлөгөөни й дагуу зохион байгуулагдаж , ой тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтан хэрэгжүүлэх бүтээлч 80 ажлын жагсаалтын хүрээнд 4 бүлэг 267 арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Ажлын хэсгийн нэгдсэн хуралдаан 5, салбар хороодын хурлыг 6 удаа хийсэн. Бэлтгэл ажлын явцын талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцсэн. 2017 оны 11 сарын байдлаар төлөвлөгөө 57.4 хувийн хэрэгжилттэй байна. | 70 |
| | 304 | 4.1.1.4. Анхдагч алдартнуудын ойг тэмдэглэн өнгөрүүлэх /Чин ван Ханддорж-150, мэргэн сайд А.Амар-130, Төр, нийгмийн зүтгэлтэн Д.Дамба-110 жил, Ардын Хатанбаатар Магсаржав-140 жил г.м/ | 2016-2020 | АЗДТГ | ОНТ, Хандив туслам ж | Анхдагч алдартнуудаа р бахархсан ажил зохион байгуулагдса н байна. | Б.Түвдэндорж аваргын 100 жилийн ойг 2016 онд Улаанбаатар хотод зохион байгуулан Бөхийн өргөөнд 256 бөхийн барилдаан зохион байгуулсан. Залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн 105 жилийн ойн хүрээнд 2017 оны 11-р сард Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан. Чин ван Ханддоржийн 150 жилийн ойг 2018 оны 04-р сард, Д.Дамбын 110 жилийн ойг 9-р сард, Хатанбаатар Магсаржавын 140 жилийн ойг 2019 онд тус тус тэмдэглэнэ. | 100 |
| **/58/** 4.1.2. Төрийн албанд, ахмад үеийнхээ мэдлэг чадвар, дадлага туршлага, арга барил, хандлагыг тусган авч, | 305 | 4.1.2.1. Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг жил бүр хийж, гарсан санал зөвлөмжийг | 2016-2020 | АЗДТГ, ТАЗ | ОНТөсө в | Мэдлэг, чадвар, арга туршлага нэмэгдсэн байна. | Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг 2 удаа зохион байгууллаа. Уулзалтаас гарсан санал зөвлөмжийн хүрээнд ХУРДТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, ХЯНАЛТТАЙ төрийн албыг төлөвшүүлэх уриалгыг “Төрийн албан хаагчдын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ахмад, дунд, залуу үеийн 3 цагийн хэлхээсэнд хамтран ажиллана. | | хэрэгжүүлэх | | | | | нэгдсэн зөвлөгөөн"-өөр хэлэлцэн баталж, хэрэгжүүлж байна. | |
| | 306 | 4.1.2.2. Төрийн албанд шинэ бүтээлч санаачлагыг уламжлалт арга барилтай хослуулан хэрэгжүүлэх | 2016-2020 | АЗДТГ | ОНТөсөв | Төрийн албан хаагчийн шинэ, бүтээлч санааг дэлгэрүүлж, орон нутагт хэрэгжүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын бүтээлч хандлагыг нэмэгдүүлж, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор "Шинэ санаачлага-Тэргүүн туршлага" болзлыг зарлан хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд "Шинэ санаачлага-Тэргүүн туршлага" болзлыг сум, байгууллагын түвшинд зарлан, дүгнэх заалтыг тусгайлан тусгасан. Болзлын хүрээнд төрийн албан хаагчид өөрийн эрхэлж буй ажлын чиглэлээр сүүлийн 5 жилийн судалгааг гаргаж, **"Чанарын удирдлагын тогтолцоо"**-г нэвтрүүлэхээр бэлтгэж байна. | 70 |
| | 307 | 4.1.2.3. Аймгийн Засаг даргын дэргэд орон тооны бус ахмадын зөвлөлийг байгуулах | 2016-2020 | АЗДТГ | ОНТөсөв | Ахмадуудын санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгасан байна. | Багийн Засаг дарга, эмч, байгаль хамгаалагч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан. | 100 |
| **/59/** 4.1.3. Засаг, захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг бүх талаар дэмжиж, бэхжүүлнэ. | 308 | 4.1.3.1. Хангал, Баяннуур, Рашаант, Булган сумын зарим багийг "Багийн хөгжлийн төв"-тэй болгох | 2016-2020 | Аймаг, сумын ЗДТГ | ОНТөсөв | Мэдлэг, чадвар, арга туршлага нэмэгдсэн байна. | Булган аймгийн 2018-2020 онд хийгдэх Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтад Рашаант, Дашинчилэн, Бугат сумдыг Багийн хөгжлийн төвтэй болгох саналыг тусгаад байна. Тэшиг сум Далан багийн төвөө "Галт Алтгана" ХХК-ийн 43 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, Хужирт, Эрэн багийн төвдөө их засварын ажил хийсэн. | 40 |
| | 309 | 4.1.3.2. Багийн ИНХ-ыг жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | 2016-2020 | Сумын ЗДТГ | ОНТөсөв | Төрийн албан хаагчийн шинэ, бүтээлч санааг дэлгэрүүлж, орон нутагт хэрэгжүүлсэн байна. | Сумдууд багийн ИНХ-аа улирал бүр зохион байгуулж хэвшсэн. Багийн ИНХ-аар аймаг, сумдын удирдлагууд иргэдэд цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, мэдээллийн хуудас, гарын авлага, "Хөгжлийн хөтөч" сонинг түгээн, үйл ажиллагаагаа мэдээлж, сурталчилж байна. Уулзалтын үеэр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн хариуг өгч ажиллаж байна. Булган суманд багийн ИНХ-ыг 3, 6, 9 дүгээр саруудын 25-30-ны хооронд тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Бусад сумд улирал бүр зохион байгуулж хэвшсэн. Олон | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийтийн ажлыг баг дээр зохион байгуулснаар иргэдийн идэвх оролцоо нэмэгдэж байна. | |
| | 310 | 4.1.3.3. Багийн Засаг дарга, эмч, ИНХ-ын дарга, байгаль хамгаалагч нарын зөвлөгөөнийг жил бүр хийж, гарсан санал, уриалгыг анхан шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах | 2016-2020 | АЗДТГ | ОНТөсөв | Ахмадуудын санаа бодлыг үйл ажиллагаанд аа тусгасан байна. | Багийн Засаг дарга, эмч, байгаль хамгаалагч нарын зөвлөгөөнийг зохион байгуулж, цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, чадавхжуулах сургалтууд хийгдсэн. Багийн Засаг дарга нарын уулзалтаас гарсан санал, хүсэлтийг шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Багийн Засаг дарга, эмч, ИНХ-ын дарга, байгаль хамгаалагч нарын уулзалтыг сар бүр хийж хэвшсэн. | 100 |
| **/60/** 4.1.4. Төрд тангараг өргөж, хариуцлага хүлээсэн бүх шатны төрийн албан хаагчдаа үнэнч шударга, ёс зүйтэй, тогтвор суурьшилтай, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, хүний нөөцийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын соёл, хандлагыг төлөвшүүлнэ. | 311 | 4.1.4.1. Төрийн албан хаагчдын “Хүний нөөцийн бодлого”-ыг боловсруулан, хэрэгжүүлэх | 2016-2020 | АЗДТГ | ОНТөсөв | Бодлого боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | Булган аймгийн “Төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх бодлого” /2016-2020/-ын төслийг боловсруулан “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлээд байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-ын чуулганаар хэлэлцэн батлагдахтай холбогдуулан бодлогыг дахин хэлэлцэх эсэх асуудлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. | 70 |
| | 312 | 4.1.4.2. Төрийн албанд мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт хийж, ажил үүргийн хуваарийг оновчтой болгох | 2016-2020 | АЗДТГ | - | Төрийн албаны үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, байгууллагуудад ажлын байрны үзлэг шалгалтыг зохион байгуулж байна. Үзлэгийн дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүллээ. Үзлэгийн дүнд үндэслэн төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллуулж буй зөрчлийг арилгахаар үүрэг даалгавар хүргүүлсний дагуу 6 сумын ЗДТГ-ын дарга, 2 агентлагийн даргын сонгон шалгаруулалт, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг төрийн албаны тухай хууль, тогтоомжийн дагуу явуулж, удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй зөрчлийг арилгасан. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт сайжирсан. | 100 |
| | 313 | 4.1.4.3. Төрийн байгууллага ажил, үйлчилгээний онцлогт | 2016-2020 | АЗДТГ | - | Төрийн байгууллагын үйлчилгээний | Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь Иргэдэд үйлчлэх нэгдсэн байр нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдэд хүргэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тохирсон соёл, хандлагыг тодорхойлох | | | | соёл тодорхойлогдсон үйлчилгээг эрхэмлэсэн төрийн алба бий болсон байна. | үйлчилгээг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Угтах үйлчилгээ”-г бий болголоо. Угтах үйлчилгээг явуулснаар төрийн үйлчилгээний шуурхай байдал нэмэгдэж, иргэдийн сэтгэл ханамж дээшилж байна. Булган аймгийн цахим хуудас www.bulgan.gov.mn –аар дамжуулан үйл ажиллагааны үнэлгээг иргэдээс авч, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. | |
| | 314 | 4.1.4.4. Алслагдсан сумдад ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор, суурьшилтай ажиллуулах үүднээс гэрээ байгуулж, ажиллах нөхцөл боломжийг хангаж, ажлын байр болон дотоод, гадаадын сургалтад хамруулж, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж нөхцлийг дэмжих | 2016-2020 | АЗДТГ | - | Чухал шаадлагатай мэргэжлийн судалгаатай болж, гэрээ байгуулах нөхцлийг бий болгосон байна. | Алслагдсан сумдад ажиллаж буй их эмч, багийн эмч, байгаль хамгаалагч, багш нарыг дотоодын сургалтад тогтмол хамруулж байна. Булган аймгийн Төрийн албаны хүний нөөцийн бодлогод алслагдсан сумдын албан хаагчдыг дэмжих, дотоод, гадаадын сургалтад хамруулахаар зорилт дэвшүүлээд байна. Япон улсын Ибараки мужийн Морияа хотын Кэйжү эмнэлэгт сувилагч нарыг солилуулан ажиллуулахаар төлөвлөж байна. | 40 |
| | 315 | 4.1.4.5. Сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад урсгал болон их засварыг үе шаттайгаар хийх | 2016-2020 | АЗДТГ, ГХБХБГ | Улс, ОНТөсөв | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна. | Булган аймгийн 2018-2020 онд хийгдэх Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтад Могод, Баян-Агт сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр, Хангал, Тэшиг, Дашинчилэн, Сайхан сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад их засвар хийх тухай саналыг тусгаад байна. ЗГХЭГ-т Могод, Баян-Агт сумдын ЗДТГ-ын барилгыг шинээр бариулах тухай хүсэлтийг 2 удаа хүргүүлсэн. Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны барилгын урсгал засварт 5,5 сая, Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварт 45 сая, Булган сумын Засаг даргын Тамгын газрын барилгын гадна засварт 96.4 сая төгрөгийг зарцуулаад байна. | 40 |
| **/61/** 4.1.5 Нутгийн удирдлагын байгууллагын үйл | 316 | 4.1.5.1. Төрийн байгууллагуудын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, | 2016-2020 | ХМОНХА | - | Иргэд мэдээллийг хурдан | Албан ёсны цахим хуудас bulgan.gov.mn, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, 80 жил 80 бүтээлч ажил фэйсбүүкийн хуудсуудад | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдэд хүргэх мэдээллийг өргөжүүлж, цахим хэлбэрээр мэдээлэл, үйлчилгээ авах боломжийг, нөхцлийг сайжруулна. | | цахим мэдээллийг иргэдэд хүргэдэг шинэ арга барилыг бий болгох | | | | шуурхай авдаг болно. | мэдээ, мэдээллүүд тогтмол тавигдаж байна. Сайт болон фэйж хуудсуудын баяжилтыг тухай бүрт нь хийж, сошиол мэдээг идвэхжүүлж байна. | |
| | 317 | 4.1.5.2. Төр, захиргааны байгууллагын удирдлагууд иргэддээ улирал тутам хийсэн ажлаа тайлагнаж, санал хүсэлтийг сонсдог графикт тогтолцоог хэвшүүлэх | 2016-2020 | ХМОНХА | - | Төр нь иргэддээ ажлаа тайлагнадаг тогтолцоо хэвшинэ. | Аймгийн Засаг дарга болон холбогдох хэлтэс, байгууллагын удирдлагууд Булган сумын ТББ, иргэд, байгууллага, аж ахуй нэгжүүд, сонирхлын бүлгүүдтэй уулзалт зохион байгуулж хийсэн ажлаа тайлагнадаг арга хэлбэрт шилжээд байна. Хоёр сар тутамд “Хөгжлийн хөтөч” сонин хэвлэгдэж, мэдээ мэдээлэл, ярилцлага, ажлын тайланг иргэдэд мэдээлж байна. | 70 |
| | 318 | 4.1.5.3. Аймгийн албан ёсны цахим хуудсыг шинэчилж, баяжуулах журмын хэрэгжилтийг сар бүр хангаж ажиллах | 2016-2020 | ХМОНХА | ОНТөсөв | Мэдээллийн хүртээмж сайжирна. | www.bulgan.gov.mn цахим хуудасны шинэчлэлтийг хийж дуусгалаа. Сум, агентлагуудтай эргэх холбоо тогтоон сар бүр мэдээ, мэдээлэл авч байна. Сайтын баяжилтыг сумдаас ирүүлсэн болон Булган аймагт болсон үйл явдлын мэдээ мэдээллээр баяжуулж байна. Мөн нутаг ус, түүхэн хүмүүс зэрэг сонирхолтой мэдээллүүдээр сошиол хандалтыг нэмэгдүүлж байна. | 100 |
| | 319 | 4.1.5.4. Төрийн үйлчилгээний “Нэг цэг”-үүдийг тогтворжуулж, Угтах үйлчилгээг нэвтрүүлэх | 2016-2020 | ХМОНХА | ОНТөсөв | Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ. | Хангал, Бугат, Гурванбулаг, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Булган, Орхон сумд “Нэг цэг”-ээр иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. “Инээмсэглэн угтаж баярлуулан үдье” сарын аяны хүрээнд сум, байгууллагууд угтах үйлчилгээг нэвтрүүлэн тогтмолжуулж байна. Аймгийн ЗДТГ угтах үйлчилгээний ажилтантай болсноор иргэд төрийн үйлчилгээний мэдээллийг түргэн шуурхай авч, аймгийн удирдлагууд, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзах хүсэлт, хүлээлт багасч байна. | 70 |
| | 320 | 4.1.5.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүсэл санаачлагыг дэмжин хамтран ажиллаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлах | 2016-2020 | ХМОНХА | ОНТөсөв | Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. | “Булганы мэдээ” сонинтой гэрээ байгуулан сар бүр “Тамгын газраас мэдээлж байна” нүүр бэлтгэн уншигчдад хүргэж байна. “Сайхан Монгол” телевиз үйл ажиллагаагаа эхлүүлж байгаатай холбогдуулан бэлтгэсэн мэдээ мэдээлэл, нэвтрүүлгүүдээ өгч байна. Мэдээ мэдээллийн time.mn, montsame.mn, ulsturch.mn сайтууд, Үндэсний олон нийтийн телевиз, “Малчин” телевизүүдтэй хамтран ажиллаж | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн багтаамж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | байна. Мөн хоёр сар тутамд "Хөгжлийн хөтөч" сонинг хэвлэн гаргаж, мэдээ мэдээлэл, ярилцлага, ажлын тайланг иргэдэд мэдээлж байна. | |
| **/62/** 4.1.6. Аливаа шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн зөв бодлого гаргаж, хэрэгжүүлнэ. | 321 | 4.1.6.1. Хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж хэвшүүлэх | 2016-2020 | АЗДТГ, Төрийн байгууллагууд | | Шийдвэр гарах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдэнэ. | Аймгийн ЗДТГ-аас 2017 онд "Иргэний танхим"-аар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг хүргүүлж, эхний 11 сарын байдлаар 39 хэлэлцүүлэг, 6 сургалтад 866 иргэнийг хамруулж, 6 бодлогын баримт бичиг, 12 зөвлөмж, 8 дэд хөтөлбөрийг хэлэлцүүлсэн байна. Сумд хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж хэвшсэн. | 100 |
| | 322 | 4.1.6.2. Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэдийн сайн дурын нөхөрлөл, бүлгүүдийн үүсгэл санаачилгыг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг тэдгээрээр төлөөлүүлэн гүйцэтгүүлэх замаар төвлөрлийг сааруулах | 2016-2020 | Төр, иргэний нийгмийн байгууллагууд | ОНТөсөв | Төр, иргэний түншлэл сайжирсан байна. | Булган аймгийн төр, иргэний нийгмийн байгууллагын "Удирдах зөвлөл"-ийн бүрэлдэхүүн, "Удирдах зөвлөл"-ийн ажиллах журам, төр, иргэний нийгмийн түншлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай захирамжийн төслийг боловсруулсан. Мөн төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх 96 ажлын жагсаалтыг батлан гаргаад байна. | 40 |
| **/63/** 4.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого боловсруулах, төлөвлөлтийн явцад тусгах, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгон олон нийтийн оролцоог хангах, санхүүжүүлэх арга замыг тодорхойлон, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлнэ. | 323 | 4.1.7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого төлөвлөлтийн шатанд тусгах, бодлогын нөлөөллийн үнэлгээ хийх, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгох | 2016-2020 | АЗДТГ, Төрийн байгууллагууд | ОНТөсөв | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлөвлөсөн бодлогын хэрэгжилт сайжирна. | Сумын ЗДТГ болон газар, хэлтэс, байгууллагуудын 2016 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнгийн талаар сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, байгууллагуудын дарга нарт танилцуулж тайлангийн бүтэц, агууллагад анхаарч цаашид төлөвлөлтийн шатанд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, гүйцэтгэл, үр дүнд ач холбогдол өгч ажиллахыг зөвлөв. Аймгийн Засаг даргын 2017 оны А/280 дугаар захирамжаар "Бодлогын бичиг баримтын хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг шинэчлэн батлуулж, сум байгууллагуудын удирдах ажилтан нар болон хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 70 |
| | 324 | 4.1.7.2. Үр дүнд | 2016- | АЗДТГ, | ОНТөсө | Төрийн | Үйл ажиллагааны тайланг сум байгууллагуудаас | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга ажиллагааг төр, төсвийн байгууллагуудад нэвтрүүлэх, цахим тайлангийн үйл ажиллагааг жигдрүүлэх | 2020 | Төрийн байгууллагууд | в | бодлогын чанар хүртээмж сайжирна. | цахимаар авч байна. Аймгийн Засаг дарга, Тамгын газрын 2016 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хугацаанд нь гаргаж Засгийн газрын ХЭГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын газарт хүргүүллээ. Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны үнэлгээг 91,3 хувь буюу 4,6 оноотойгоор үнэллээ. Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын удирдлагын “Able” программаар авч хэвшиж байна. | |
| | 325 | 4.1.7.3. Бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бүх үе шатанд олон нийтийн оролцоог хангах, хэлэлцүүлэг зохион байгуулах, санхүүжүүлэх арга замыг тодорхой болгох | 2016-2020 | АЗДТГ, Төрийн байгууллагууд | ОНТөсөв | Төрийн бодлого олон нийтэд нээлттэй болж, төрийн бодлогод олон нийтийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сайжирч, итгэл үнэмшил нэмэгдсэн байна. | Хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж байна. Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын 2017 оны А/50 дугаар захирамжаар холбогдох газар, хэлтэс, сум, байгууллагуудад хувиарлан өглөө. Мөн аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд хөтөлбөрүүдийг боловсруулахдаа иргэдээс санал авч, иргэний танхимаар хэлэлцүүлж, хөтөлбөрүүдийг хэрэжүүлэх санхүүжилтийг орон нутгийн төсвөөс тодорхой төсвийг батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. | 70 |
| | 326 | 4.1.7.4. Аймаг, сумын хэмжээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр авах, хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг иргэд олон нийтэд хүргэх арга зүйг сайжруулах | 2016-2020 | АЗДТГ, Төрийн байгууллагууд | ОНТөсөв | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлөвлөсөн бодлогын хэрэгжилт сайжирна. | Булган сум, Рашаант, Хишиг-Өндөр, Хангал сум, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс зэрэг 16 агентлаг, суманд ажиллаж хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр зөвлөмж өглөө. Цагдаагийн газарт төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр 68 болон цаасаар 87, нийт 155 иргэнээс авсан. Судалгаагаар гэмт хэргийн илрүүлэлтийг судалгаанд оролцогчдын 58,7 хувь нь | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хангалттай болон сайн гэж үзсэн боловч үйлчилгээний сэтгэл ханамж, алба хаагчдын зан харилцаа, ёс зүй, мэдлэг чадварыг үнэлэх асуултуудад 59,2 хувь нь дутагдалтай гэж хариулсан байна. Сум, агентлагийн хяналт шинжилгээ үнэлгээний 2016 оны дүнг аймгийн ВЕБ сайт болон МОНЦАМЭ агентлаг, “Булганы мэдээ” сониноор олон нийтэд сурталчиллаа. | |
| | 327 | 4.1.7.5. Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулж хийлгэх | 2016-2020 | АЗДТГ, Төрийн байгууллагууд | ОНТөсөв | Төрийн бодлого олон нийтэд нээлттэй болж, төрийн бодлогод олон нийтийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сайжирна. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Дэлхийн банкны МАСАМ төсөл хамтран хэрэгжүүлж байгаа “Хэрэглэгчийн үнэлгээ”-г авах туршилтын судалгаанд манай аймаг сонгогдон хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж байна. Хэрэглэгчийн үнэлгээ авах төрийн бус байгууллагаар аймгийн Залуучуудын холбоо шалгарч ажлаа эхлүүлээд байна. | 100 |
| **Уламжлалт харилцаат** | | | | | | | | |
| **/64/** 4.1.8. Гадаад харилцааг өргөжүүлж шинэ шатанд гарган, бизнес эрхлэгчдийг холбож өгнө. | 328 | 4.1.8.1. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хот, Закамень аймагтай боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллах | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ | | Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ. | ОХУ-ын Буриад улсын Закамень аймгийн төлөөлөгчдийг Булган аймагт хүлээн авч, ажил хэргийн уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар өмнөх жилүүдэд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэн, цаашид хөдөө аж ахуй, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцож, шинээр байгуулах гэрээний төсөлд санал хүргүүлээд байна. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хот, Закамень аймаг Бугат сумтай хамтран ажиллах гэрээ байгуулан сумын 200 орчим иргэдэд зүрх судас, нүд, хүүхэд, дотрын чиглэлээр үзлэг хийсэн. Эрүүл мэндийн газар нь тус аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Улан-Үдэ хотын ХАА-н жимс жимсгэний хүрээлэнтэй суулгац үржүүлэх талаар хамтран ажиллаж, тус аймгийн ХАА-н Агропаркад 8 нэр төрлийн жимс, жимсгэний суулгац үржүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 329 | 4.1.8.2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанхад хоттой Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хамтран ажиллах | 2016-2020 | АЗДТГ, ХХААГ | | Хамтын ажиллагаа хөгжсөн байна. | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанхад хоттой өмнө тогтоосон харилцаагаа сэргээхээр ажиллаж байна. Монгол-Хятадын 2 дахь удаагийн Экспо 2017 оны 9-р сарын 26-30-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдаж, тус аймгаас Засаг даргын зөвлөх, ХХААГ-ын дарга, Булган сумын Засаг дарга, 3 аж ахуйн нэгж оролцсон. Шилийн гол аймгийн Ажил мэргэжлийн сургуультай ХАА-н болон бусад мэргэжлийн дадлага эзэмших, сургах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | 40 |
| | 330 | 4.1.8.3. БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ | | Хамтын ажиллагаа хөгжсөн байна. | БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй өмнө тогтоосон харилцааг сэргээхээр судалж байна. | 0 |
| | 331 | 4.1.8.4. Турк улстай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтран ажиллах | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ ХХААГ | | Хамтын ажиллагаа хөгжсөн байна. | Монгол улсын БСШУ-ны яам, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /Тика/-тай хамтран хэрэгжүүлж буй "Улаан хэрмийн шороон бумбагар Түрэгийн үеийн бунхант булшийг сэргээн засварлах, авран хамгаалах төсөл"-ийг Булган аймгийн Баяннуур сумын нутагт хэрэгжүүлж эхэлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хийгдэх засварын ажлыг 70 сая төгрөгөөр хийж дууссан. Мөн 45 сая төгрөгний тоног төхөөрөмж худалдан авахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хангал сумын "Эко хан буян"хоршоонд даршны ургамлын тариалалт хийгдсэн. | 100 |
| | 332 | 4.1.8.5. Гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой хамтран ажиллах | 2016-2020 | АЗДТГ | | Хамтын ажиллагаа хөгжсөн байна. | Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой хамтран ажиллаж байна. Тус холбооны Япон улс дахь Гамшгаас сэргийлэх хорооны 15-р хуралд аймгийн Засаг дарга, Онцгой байдлын газрын даргын хамт оролцож, орон нутгийн гамшгаас сэргийлэх чадавхыг сайжруулсан. | 70 |
| **<u>Шинээр харилцаа тогтоох</u>** | | | | | | | | |
| | 333 | 4.1.8.6. ОХУ-ын Красноярск мужтай эдийн засаг, нийгэм, | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ, | | Эдийн засгийн үр ашигтай | ОХУ-ын Красноярск мужийн Хөдөө аж ахуйн их сургууль, "Зүүн Сибирийн төв шинэлэг, нано технологийн "Үйлдвэрлэл нэвтрүүлэх" ХХК-тай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах | | ХХААГ | | гадаад харилцааг хөгжүүлнэ. | байгуулсан санамж бичгийн хүрээнд ОХУ-ын Красноярск хотын ХАА-н их сургуультай хамтран 3 бүсэд Сибирийн сортуудыг турших гэрээ хийгдэж, Сэлэнгэ сумын “Ингэттолгой” ХК, Тэшиг сумын “Шинэ амжилт” ХХК-иуд 3 сортын буудайг турших тариалалт хийв. | |
| | 334 | 4.1.8.7. Европын өндөр хөгжилтэй Холбооны бүгд найрамдах Герман, Бүгд найрамдах Австри улсуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарт хамтран ажиллах, нөхцлийг судлах | 2016-2020 | АЗДТГ, ХХААГ | | Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна. | Гадаад харилцааны сайд болон бусад холбогдох байгууллагуудад Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Бүгд Найрамдах Австри улсуудтай хамтын ажиллагааны харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. Гадаад харилцааны яамнаас Герман, Австри улсуудтай харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэн судалж байгаа талаар хариуг ирүүлсэн. Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 5 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ХБНГУ-ын зарим мужтай шууд харилцаа тогтоож хамтран ажиллахаар тусгагдаад байна | 70 |
| | 335 | 4.1.8.8. Азийн өндөр хөгжилтэй Япон улстай хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ | | Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна. | Япон улсын Ибараки мужийн Морияа хотод аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Э.Түвшинмөнх тэргүүтэй сумдын Засаг дарга, зарим агентлагийн дарга, мэргэжилтэн болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг албан хэргээр ажиллаж, хөдөө аж ахуй, нийгмийн салбарт туршлага судаллаа. Монгол улсад анх удаагаа “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг Японы хамтын ажиллагааны “Жайка” Олон улсын байгууллагаас 2016-2020 онд Булган аймагт хэрэгжүүлэхээр сонгон, амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд энэ онд 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 164 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулаа. “Жайка” ОУБ-ын сайн дурын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 336 | | | | | | гишүүдийн “Солонго” бүлгэмтэй хамтран “Сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах” сэдэвт сургалтыг Нэгдсэн эмнэлгийн 56 сувилагч, эх баригч, Орхон аймгийн БОЭТ-ийн 12 эх баригч, сумын Эрүүл мэндийн байгууллагуудын 15 эх баригч нийт 83 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. | |
| | 336 | 4.1.8.9. АНУ-тай боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах | 2016-2020 | АЗДТГ, БСУГ, ЭМГ | | Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна. | АНУ-ын Элчид сайдад албан хүсэлт хүргүүлсэн. Элчин сайдаас зөвлөмжилсний дагуу АНУ-ын эгч дүү хотуудын олон улсын байгууллагад аймгийн мэдээллийг хүргүүлэн цахим мэдээллийн санд байршуулаад байна. АНУ-ын Монтана их сургуулийн “BIOREGIONS” хөтөлбөрийн “Эрүүл мэндийн баг”-тай хамтран “Эрүүл мэндийн ажилтныг чадавхижуулах” сургалтыг зохион байгуулан ЭМГ, аймгийн НЭ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд, сум, өрхийн ЭМТ, СДЭ-ийн сургалтын арга зүйч, багийн эмч нарыг хамруулансан. “BIOREGIONS” хөтөлбөрийн “Эрүүл мэндийн баг”-ийнханд аймгийн НЭ-ийн үйл ажиллагааг танилцууллаа. | 70 |
| **ТАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ**<br>**5.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийтийн албаны ёс зүйг өндөржүүлэн, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар төрийн албаны сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. Хууль хяналтын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, иргэний аюулгүй АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ зорилгоор эрсдэлд суурилсан удирдлага, шуурхай бэлэн байдлыг хангана.** | | | | | | | | |
| **/65/** 5.1.1. “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум байгууллагад эрх зүйч мэргэжилтэн, иргэний эрх зүйн хөтөч бэлтгэн, хууль зүйн туслалцааг иргэд, байгууллагад үзүүлэх | 337 | 5.1.1.1. Сум, байгууллагуудад төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтнийг эрх зүйн ажилтнаар, багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарыг “Эрх зүйн хөтөч”-өөр бэлтгэх | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Иргэнд хууль зүйн туслалцааны үйлчилгээ ойртоно. | Эрх зүйн хөтөч, сургагч багш нарын сургалтыг 3 удаагийн давтамжтайгаар зохион байгуулж 50 гаруй албан хаагчдийг хамруулсан. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар “Эрх зүйн баг”-ийг 22-ны бүрэлдэхүүтэйгээр байгуулж хууль, эрх зүйн сургалтыг зохион байгуулж байна. | 100 |
| | 338 | 5.1.1.2. Тусгайлан бэлтгэсэн гарын авлага, сэдвийн дагуу сум, баг, байгууллагад эрх зүйн зайны сургалтыг зохион байгуулах | 2016-2020 | Сумын ЗДТГ, ХЭЗХ | ОНТөсөв, Төсөл хөтөлбөр | Нэгэн зэрэг олон оролцогчтой сургалтыг зохион байгуулдаг болно. | Хууль зүйн дотоод хэргийн яамнаас ирүүлсэн зайны сургалтыг гарын авлага болон шинээр батлагдсан хууль болон хуулийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах эрх зүйн зайны сургалтыг 16 сум, 1 тосгонд 4 удаа нэгдсэн зохион байгуулалтаар ажиллаж 4300 гаруй иргэдэд сургалтыг зохион | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллаа. | |
| | 339 | 5.1.1.3. Сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан хууль сурталчлах | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Эрх зүйн мэдээлэл иргэдэд ойр болно. | Хэрэглэгчийн эрх ашигийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хэрэглэгчийн өдрийг долоо хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулж хэвшлээ. Уг өдрөөр хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл, хууль сурталчлах сургалт, мэдээллийн дэвтэрийг аялуулж байна. 2017 оны эхний 10 сарын байдлаар хэрэглэгчийн эрх ашигийг хөндсөн гомдол мэдээлэл ирээгүй байна. 2017 онд хэрэглэгчийн боловсролын төвд нийт 20 удаа сургалтыг зохион байгуулж 370 гаруй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөөд байна. | 100 |
| | 340 | 5.1.1.4. “Хэрэглэгчийн боловсрол” төвийн үйл ажиллагааг дэмжин, хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх | 2016-2020 | ХЭЗХ, ТББ | ОНТөсөв | Хэрэглэгчийн боловсрол дээшилсэн байна. | Иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, өмгөөлөлийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд хууль зүйн туслалцааны төв болон Хууль, эрх зүйн хэлтэст 2017 оны 10 дугаар сарын байдлаар хуулийн зөвлөгөөг 580 гаруй иргэнд өгсөн байна. Мөн хууль зүйн туслалцаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээг 120 иргэнд үзүүлсэн байна. | 100 |
| | 341 | 5.1.1.5. Хуульчийн мэргэжлийн холбоо, өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран, иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах | 2016-2020 | Сумын ЗДТГ ХЭЗХ | ОНТөсөв | Иргэд хууль зүйн туслалцаа авах боломж бүрдэнэ. | Хүний эрхийн мэдлэг дээшлүүлэх, хүний эрхийг дээдлэн ажиллах талаар сургалтыг 12 байгууллагын 210 гаруй албан хаагчдад хийсэн байна. Мөн сумдад өөрсдийн хүрээнд хүний эрхийн өдрийг угтан цуврал сургалтыг зохион байгуулж 2000 гаруй иргэдэд хүний эрхийг хангах, дээдлэх талаар мэдлэг олгосон байна. | 100 |
| | 342 | 5.1.1.6. Хүний эрхийн боловсрол олгох сургалт, судалгаа, мэдээллийн арга хэмжээг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Хүний эрхийн мэдлэг хандлага нэмэгдэнэ. | Аймгийн хэмжээнд сум, байгууллагуудаас авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөөг авч нэгтгэн аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан нэгтгэж аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Булган аймгийн авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөөг 5 бүлэг, 26 зорилт дэвшүүлэн хэрэгжиллтийг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| **/66/** 5.1.2. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны | 343 | 5.1.2.1. Сум, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтүүдийн | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | ТБ-ын шударга байдлын үнэлгээ өссөн | Аймгийн хэмжээнд сум, байгууллагуудаас авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөөг авч нэгтгэн аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан нэгтгэж аймгийн Засаг даргын захирамжаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулж хяналт тавих, байгууллагын шударга түвшний үнэлгээг нэмэгдүүлэх | | хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх | | | | байна. | батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Булган аймгийн авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөөнд 5 бүлэг, 26 зорилт дэвшүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. | |
| | 344 | 5.1.2.2. Сум, байгууллагын шударга түвшний үнэлгээг олон нийтийн оролцоотой хийх | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж хэвшинэ. | Байгууллагуудын шударга түвшины үнэлээг төрийн бус байгууллагаар хийлгэх саналыг танилцуулан хөдлөнгийн баг байгуулах, ажиллах чилэл, үйл ажиллагаандаа мөрдөх журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас Булган аймгийн шударга түвшиний үнэлгээг хийх үүднээс 3 иргэн сонгогдож холбогдох сургалтад хамрагдсан. Дээрх үнэлгээний дүн жилийн эцэст тооцогдох юм. | 100 |
| | 345 | 5.1.2.3. Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчил болон авлигын шалтгаан нөхцөлд хийсэн судалгааны дүнд үндэслэсэн сургалт мэдээллийг хийх | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Олон нийт авлигын эсрэг ойлголт хандлагатай болно. | 2017 онд эхний хагас жилийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалтыг аймгийн төвийн 10 байгууллага, 356 албан хаагч, 16 суманд өөрсдийн бэлтгэсэн гарын авлага материалаар 58 удаа 520 гаруй төрийн албан хаагч, иргэдэд сургалтыг зохион байгуулсан байна. | 100 |
| | 346 | 5.1.2.4. Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэрт судалгаа хийж, шийдвэрийн системчлэл хийх | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Шийдвэрийн уялдаа холбоо сайжирна | 2017 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн Засаг даргын 900 гаруй захирамж, тамгын газрын даргын 100 гаруй тушаалын хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаа. Мөн Сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын гаргасан тушаал зэргийн хууль, эрх зүйн үндэслэл, хэрэгжилтийг хянаж арга зүйн зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байна. Мөн 10 сумын 1200 шийдвэрийг хянаж арга зүйн зөвлөмжийг хүргүүлсэн. | 100 |
| **/67/** 5.1.3. Нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагын оролцоонд түшиглэн зохион байгуулж, | 347 | 5.1.3.1. Булган сумын нийтийн эзэмшлийн зам талбай, уулзвар гарц болон улсын чанартай авто замын хяналтын постуудыг камераар тоноглох | 2016-2020 | ХЭЗХ, ЦГ | ОНТөсөв | Гэмт хэргийн шуурхай илрүүлэх боломж бүрдэнэ. | Баяннуур сумын Замын хяналтын пост, Эгийн голын гүүрэн гарцыг хяналтын камераар тоноглож үйл ажиллагаанд ашиглаж байна. Булган сумын камерын системжийг өргөтгөх санал бэлтгэсэн. | 70 |
| | 348 | 5.1.3.2. Шатахуун түгээх станц болон онцгой | 2016-2020 | ЦГ, СХЗХэлт | Сумын Засаг | Урьдчилан сэргийлэх, | Аймгийн хэмжээнд 34 шатахуун түгээх станц үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ. | | барилга объектууд, олон нийтийн үйлчилгээний заал бүхий аж ахуйн нэгжүүд, төр, төсвийн байгууллагуудын дунд орчин тойрноо хяналтын камераар тоноглох хөдөлгөөн өрнүүлэх | | эс, иргэн, ААН | дарга, иргэн, ААН | аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ. | Цагдаагийн газраас нэгдсэн шалгалт хийж үүрэг чиглэл өгсөн. Камерын хяналтгүй үйл ажиллагаа явуулж байгаа 8 ШТС-д албан шаардлага хүргүүлж, 21 ажилтанд 3 цагийн сургалт хийсэн. | |
| | 349 | 5.1.3.3. Зарим сумдыг хяналтын камерын системтэй болгох | 2016-2020 | ЦГ, Сумын ЗД | ОНТөсөв | Бүх сумын төв камерын хяналтын системтэй болно | Сумын төвд хяналтын камер суурилуулаагүй 9 сум байснаас одоогийн байдлаар Рашаант, Тэшиг, Бугат сум, Хялганат тосгонд санал, зөвлөмж хүргүүлсэн. Гурванбулаг сум 30,0 сая, Булган сумын камерын системийн засварт 5,0 сая төгрөг зарцуулсан байна. | 40 |
| | 350 | 5.1.3.4. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналт”, “Урамшилт эргүүл” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх | 2016-2020 | ЦГ, Сумын ЗД | ОНТөсөв | Тухайн төрлийн гэмт хэрэг буурна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 он гарсаар аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээг 3 удаа зохион байгуулж багийн ахлагч, хэсгийн байцаагчаар дамжуулан мэдээлэл, зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажилласан байна. ГХУСАЗСЗ-ийн дэмжлэгээр ачаалал ихтэй саруудад урамшилт эргүүл томилон ажиллуулж байна. ГХУС ажлыг сайжруулах 45 хоногийн аяны хүрээнд Булган сумын иргэд, МСҮТ-ын оюутнуудыг хамруулсан “100 эргүүл”, “Иргэн-Цагдаагийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулав. | 70 |
| | 351 | 5.1.3.5. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Хяналт шийдвэрлэлт” арга хэмжээ болон бүсийн хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах | 2016-2020 | ХЭЗХ, ГХУСАСЗ, сумын Засаг дарга | ОНТөсөв, ГХУССан | Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт өснө. | ГХУСАСЗ-тэй хамтран малын хулгайтай тэмцэх бүсийн хамтарсан зөвлөгөөний Өвөрхангай аймагт зохион байгуулан аймгийн Цагдаагийн газраас төлөөлөл оролцсон. 2017 оны 2 дугаар сард Хяналт шийдвэрлэлт нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралаал хэлэлцүүлсэн. Мөн 2017 оны 11 дүгээр сарын 03-наас эхлэн тус арга хэмжээг зохион байгуулж байна. Үр дүнг хэлэлцэх болоогүй. | 100 |
| | 352 | 5.1.3.6. Мал хулгайлах гэмт хэрэг, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрсдэл | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв, ГХУССан | Иргэд, малчдын оролцоотойгоор үр дүнд | Өвөрхангай аймагт болсон хил залгаа аймгуудын хамтарсан зөвлөгөөнд оролцож, зөвлөгөөнөөс гаргасан 12 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцон ажиллаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ихтэй "Нэг сум", "Нэг баг"-ийг сонгон иргэд, малчдын оролцоотой урьдчилан сэргийлэх аргачлалыг нэвтрүүлж үр дүнг тооцох | | | | хүрсэн туршлага, аргачлал бий болно. | байна. Баян-Агт, Бүрэгхангай, Могод, Сайхан, Дашинчилэн, Гурванбулаг, Орхон, Хангал сумдын 17 багийн 180 иргэнийг хамруулсан сургалт зохион байгуулж, "Малчдын бүлэг" байгуулах аргачлал зөвлөмжөөр хангаж, малчдын 12 бүлэг шинээр байгуулан дэмжиж ажиллах чиглэлийг сумын ГХУСАЗСЗ-д өгсөн. Хүрээлэн буй орчны эсрэг ГХУС хяналт шалгалтыг эрсдэл бүхий хугацаанд тодорхой бүс нутгийн хэмжээгээр давтамжтай зохион байгуулж илэрсэн зөрчлийг хянан шийдвэрлэж байна. Бүрэгхангай, Дашинчилэн суманд уул уурхайн үйлдвэрлэлд хяналт шалгалт хийж 1,2 тэрбум төгрөгийн хохиролтой 3 эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. | |
| | 353 | 5.1.3.7. Хутаг-Өндөр суманд Замын хяналтын постыг барьж, шаардлагатай сумдыг хурд хэмжигч багажтай болгох | 2016-2020 | ЦГ | ОНТөсөв | Зам тээврийн хэрэг, ослын гаралт буурсан байна. | Хутаг-Өндөр сумын Хяналтын постын саналыг яаманд хүргүүлж, Рашаант, Баяннуур сумын замын цагдаагийн албан хаагч нарт хурд хэмжигч багажтай болгох саналыг УИХ-ын гишүүнд уламжилсан. Одоогоор шийдвэрлэгдээгүй байна. | 0 |
| | 354 | 5.1.3.8. Орон нутгийн чанартай авто замын уулзваруудад тэмдэг, тэмдэглэгээ тавьсан ажлыг үргэлжлүүлэх, боловсронгуй болгох | 2016-2020 | ЦГ, Сумын Засаг дарга | Онцгой комисс | Иргэдэд эрсдэл учрахаас сэргийлнэ. | Аймгийн Засаг даргын А/121 тоот захирамжаар орон нутгийн шороон болон хайрган хучилттай замын тэмдэг, тэмдэглэл, замын байгууламжид үзлэг шалгалт хийсэн. Цаашид шаардлагатай газруудад тэмдэг, тэмдэглэл хийх ажлыг орон нутгийн төсөвт тусган үе шаттай шийдвэрлэнэ. Цагдаагийн газраас сумдад чиглэл өгснөөр сумын хэмжээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тэмдэгжүүлэх ажлууд хийгдсэн. | 70 |
| | 355 | 5.1.3.9. Булган сумын 6-р баг дахь Шунхлайн ШТС-ын гурван замын уулзварт хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио суурилуулах | 2016-2020 | ЦГ | ОНТөсөв | Эрсдэлгүй орчин бүрдэнэ. | Зам тээврийн үндэсний төвийн дүгнэлтээр гэрлэн дохиогоор зохицуулах бус туузан хашилтаар тоноглож хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар шийдэврлэсэн. | 40 |
| | 356 | 5.1.3.10. "Эрүүл ирээдүй" дэд хөтөлбөрийг баталж, ТББ-ын оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Гүйцэтгэгчийн урьдчилан сэргийлэх сургалт, | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв, Төсөл хөтөлбөр | Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх арга хэмжээ | Аймгийн ИТХ-ын тогтоолоор "Эрүүл ирээдүй" дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг батлуулан иргэдэд хөтөлбөрийн танилцуулга, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөлөөллийн ажлын үр дүнг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх | | | | хийгдсэн байна. | нөлөөллийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. | |
| | 357 | 5.1.3.11. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ТББ-аар гүйцэтгүүлэх | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв, Төсөл хөтөлбөр | Урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ. | Гэр бүлийн хүчирхийлээс урьчдилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. | 100 |
| | 358 | 5.1.3.12. Хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, арилгах арга хэмжээг зохион байгуулах | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Хүний эрхийн нөхцөл байдал сайжирна. | Хүний эрхийн үндэсний комисс Булган аймагт ажиллаж мэдээлэл сургалт, сурталчилгааны уулзалтуудыг зохион байгуулсан. Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөтэй зорчих эрхийн стандартыг хангах зөвлөмжийг гаргаад байна. Хүний эрхийн ОУ-ын өдөр, Авлигын эсрэг ОУ-ын өдрийг утгасан 2 сарын мэдээлэл, сурталчилгааны аян явуулж байна. | 100 |
| **/68/** 5.1.4 Хууль хяналт, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хуулийн дагуу дэмжиж /шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл/, хууль сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж иргэдийн “АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН”-ыг бүрдүүлнэ. | 359 | 5.1.4.1. Хууль зүйн салбарын байгууллагуудын нээлттэй хэлэлцүүлэг, хамтарсан эрх зүйн сургалтыг сум, багт зохион байгуулах | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг сайжирна. | Хууль зүйн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг сум, багийн иргэдэд сурталчлах ажлын хүрээнд 16 суманд 4 ажлын хэсэг томилон шинээр батлагдсан хуулийн сургалт, өөрсдийн байгууллагын үйл ажиллагааг таниулах, хамтарч ажиллах талаарх ажлыг хамтран зохион байгуулан дүнг аймгийн ГХУСАСЗ-д танилцуулаад байна | 100 |
| | 360 | 5.1.4.2. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тогтмол хянаж шалгах | 2016-2020 | МХГ | Байгаль хамгаалах сан | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багасна. | **Байгаль орчны хяналтаар:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Авто тээврийн газаруудтай хамтран хөдөлгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн илэрсэн зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан. Улсын хэмжээнд тарваган тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт хуулиар хориглосон ан агнах, зохих зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэх, тээвэрлэх, худалдах, худалдан авах, байгалийн дагалт баялгийг эрхийн бичиггүйгээр түүж, тээвэрлэх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 361 | | | | | | үйлдлийг хянаж таслан зогсоох зорилгоор 8 дугаар сарын 31-нээс 9 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал 24 цагаар Замын Цагдаагийн тасаг, Онцгой байдлын газартай хамтарч постонд гарсан. Энэ хугацаанд илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдэж, арга хэмжээ авсан. **Хүрээлэн буй орчны хяналтаар:** Булган сумын 5-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Булган-Мээж” ХХК-ны нэгдсэн халаалтын зуухнуудын яндангаар хаягдаж байгаа утааны хийн орчин, агаарын бохирдол үүсгэж байгаа байдалд хамтарсан шинжилгээ, хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар Булган сумын агаарын бохирдолыг **MNS4585:2016** стандарттай харьцуулахад азотын давхар исэл, хүхэрлэг хийн хэмжээ стандартад заагдсан хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй нь шинжилгээгээр тогтоогдсон. Шалгалтаар илэрсэн зарим зөрчлийг арилгуулах 4 заалттай улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч ажилласан. **Геологи уул уурхайн хяналтаар:** Голын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 17 аж ахуйн нэгж, иргэн шалгалтанд хамрагдсан. “Ил уурхайн үйл ажиллагааг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 15 ААН, иргэн нь их эрсдэлтэй, 2 аж ахуйн нэгж нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 4 ААН нь Эрүүгийн шинжтэй зөрчил үйлдсэн тул Цагдаагийн газарт МХГ-ын даргын албан тоотоор шалгуулах хүсэлт хүргүүлсэн. | |
| | 361 | 5.1.4.3. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, орон тооны бус зөвлөлийг чадавхжуулж, үйл ажиллагааг өргөжүүлэх | 2016-2020 | МХГ | ОНТөсөв | Хүнсний аюулгүй байдал хангагдана. | Хүнсний чанар, стандартын хяналтаар бүх сумдын орон тооны бус зөвлөлийн даргатай уулзаж, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, тайлан мэдээг хугацаанд нь ирүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй, халдвар хамгаалал, газар тариалан, үр сорт, ургамал хамгаалал хорио цээр, мал эмнэлгийн чиглэлээр нийт 58 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалт, 45 обьектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, нийт зөрчлийн 30.1 хувийг газар дээр нь арилгуулж, 46 албан шаардлага, 29 зөвлөмж хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, эрсдэлийг бууруулах зорилгоор 9 удаагийн сургалтыг зохион байгууллаа. | |
| | 362 | 5.1.4.4. Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааг бэхжүүлж, лабораторийн байр, шуурхай албанд хэрэглэгдэх тусгай зориулалтын техник хэрэгсэлтэй болоход дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | ХЭЗХ, ШША | Улс, ОНТөсөв | Ажлын орчин нөхцөл сайжирсан байна. | 2017 оны 04 дүгээр сард Шүүхийн шинжилгээний албаны байрыг өргөтгөн лабораторийн байртай болгосон. | 100 |
| | 363 | 5.1.4.5. Хаягжуулалтын тухай хуулийг хэрэгжүүлж, иргэний бүртгэлийн хаягийн өөрчлөлт хийх | 2016-2020 | УБХ | Улс, ОНТөсөв | Иргэний хаягийн бүртгэлийн давхардал, хийдэл арилна. | Хаягжуулалтын хуулийг хэрэгжүүлэх, иргэний байнгын оршин суугаа газрын хаягийн бүртгэлийг цэгцлэх зорилгоор улсын бүртгэлийн байгууллага иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад шилжилт хөдөлгөөн бүртгэл нь шилжин явсан, шилжин ирсэн гэсэн 2 шаттай байгааг шилжин ирсэн газраа бүртгүүлдэг өөрчлөлтийг оруулж байгаа. Мөн шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлдэггүй, хаягийн бүртгэлийн зөрчилтэй иргэдийн судалгааг гаргаж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | 100 |
| | 364 | 5.1.4.6. Зарим байгууллагуудын байрны асуудлыг шийдвэрлэж, үйлчилгээний нөхцлийг сайжруулах | 2016-2020 | УБХ, ШША, ЦГ, МХГ, | Улс, ОНТөсөв | Хөдөлмөр хамгаалал, хүний эрхийн нөхцөл сайжирна. | Засаг даргын Тамгын газар шинэ байранд орсонтой холбогдуулан Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтсийг Тамгын газрын хуучин ашиглаж байсан байранд оруулан байрны асуудлыг шийдсэн. | 100 |
| | 365 | 5.1.4.7. Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн технологи, программ хангамжийг нэмэгдүүлж, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахим архивт шилжүүлэх | 2016-2020 | УБХ | Төсөл хөтөлбөр | Улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний шуурхай байдал нэмэгдэнэ. | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивийг цахим архивт шилжүүлэх ажлын хүрээнд ерөнхий газартай программаар холбогдож нэгдсэн сүлжээгээр эд хөрөнгийн бүртгэлийг хийж байна. | 100 |
| | 366 | 5.1.4.8. Цагдаагийн газрын төв, хөдөөгийн тасгуудыг ажлын шаардлага хангасан | 2016-2020 | ЦГ, Сумын Засаг дарга | Улс, ОНТөсөв | Цагдаагийн албаны шуурхай байдал | Сумдын ЗД-тай байгуулсан гэрээгээр албадын шуурхай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэхийг даалгасан бөгөөд Хялганат тосгоноос сум дундын Цагдаагийн тасагт автомашин авч | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх | | | | хангагдана. | өгсөн. Аймгийн ЦГ-ын шуурхай албанд тусгай зориулалтын тоноглол бүхий пургон автомашин шийдвэрлэхээр 2018 оны төсвийн төсөлд тусгасан. | |
| | 367 | 5.1.4.9. Цагдаагийн газрын өргөтгөл, гадна фасад, сантехникийн их засвар, нийтийн байрны сантехникийг засварлах ажлыг дэмжих | 2016-2020 | ЦГ | Улс, ОНТөсөв | Ажлын орчин нөхцөл сайжирсан байна. | Цагдаагийн газрын байрны өргөтгөлийн зураг төсвийг 2018 оны төсвийн төсөлд тусгуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр уламжилсан. | 40 |
| | 368 | 5.1.4.10. Цагдаагийн хэсгийн байцаагч болон мөрдөн байцаагч нарыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах | 2016-2020 | ЦГ | Улс, ОНТөсөв | Хэргийн илрүүлэлт болон ажиллах нөхцөл сайжирна. | Цагдаагийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах саналыг ЦЕГ-т хүргүүлснээр 4 ширхэг суурин компьютер, 2 хэвлэгч шийдвэрлүүлсэн. Мөн Булган аймагт үйл ажиллагаа явуулдаг “Хас” банктай хамтын ажиллагааны хүрээнд гэрээ байгуулан шинэ хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Мэдүүлэг авах өрөө”-г иж бүрэн тохижуулан сандал, ширээ, иж бүрэн компьютер, камерийг шийдвэрлэн 4,7 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдэрлэсэн. Бугат, Хангал, Тэшиг, Сайхан сумдад бэлэн бус торгуулийн машин, драйгер, компьютер зэрэг техник хэрэгсэлд 14,8 сая төгрөг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. | 70 |
| | 369 | 5.1.4.11. ШШГБ-уудад хүмүүжиж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих, үйлдвэрлэлд ажиллуулах | 2016-2020 | ХЭЗХ, ШШГА, Хорих анги | Улс, ОНТөсөв | Хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж хүний эрх хангагдана. | Хорих ял эдэлж байгаа ялтнуудыг талх барих, мод түлээ бэлтгэх гэх мэт дотоодын аж ахуйн үйл ажиллагаанд оролцуулж байна. Хорих анги дотооддоо жижиг үйлдвэрлэл эрхлэн зах зээлд бүтээгдэхүүн гаргаж, ажлын хөлсийг нь дансанд байршуулан өгч байна. | 100 |
| | 370 | 5.1.4.12. Хилчдийн ажиллах нөхцлийг сайжруулах, хил хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих | 2016-2020 | ХЭЗХ | ОНТөсөв | Хилчдийн ажиллах нөхцөл сайжирна. | Хил орчмын гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хил хамгаалах байгууллагад нисдэг камер бэлэглэсэн. Мөн хил хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Нэг баг-Нэг агт” аяныг зохион байгуулж 56 агт, 7 сая төгрөгийг цуглуулан хил хамгаалах байгууллагад хүлээлгэн өглөө. Хилчдыг улирал бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж байна. | 100 |
| | 371 | 5.1.4.13. Төрийн архивын | 2016- | Төрийн | ОНТөсө | Ажиллах | Төрийн архивын тасаг нь аймгийн ЗДТГ-ын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тасгийн байрыг стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах | 2020 | архивын тасаг | в | нөхцөл, хөмрөгийн аюулгүй байдал хангагдана. | шинэ байранд нүүж орохтой холбогдуулан архивын байранд камер 4, галын дохиолол 6, ус мэдрэгч 4 ширхэгийг шинээр байрлуулж, 6 цонхонд төмөр сараалж бэхэлгээг хийлээ. Архивын байрыг стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангахад аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс болон ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөс нийт 2907600 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Архивын Ерөнхий газраас Архивын баримтыг хадгалах зориулалтын /нийт 18000000 төгрөг/ нягтруулсан шүүгээ шинээр 45 ширхэгийг авч байрлуулж, Архивын уншлагын танхим болон бусад өрөөг тохижуулах ажлыг зохион байгууллаа. Аймгийн төрийн архивыг "Нутгийн удирдлагын ордон"-ы шинэ байранд тусгай төлөвлөгөөний дагуу нүүлгэн шилжүүллээ. Төрийн архивыг нүүлгэн шилжүүлэхэд аймгийн Засаг дарга захирамж гарган нөөцийн хөрөнгөнөөс 2975000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |
| | 372 | 5.1.4.14. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж, цахим архивт шилжүүлэх | 2016-2020 | Төрийн архивын тасаг | Улс, ОНТөсөв | Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж дууна. | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн дөрөвдүгээр үе шатанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 5 хөмрөгийн 16 байгууллагын 1953-2013 оны 16 дансны 398 хадгаламжийн нэгжээс 26198 заалт, 105225 хүний нэр, 3037 байгууллагын нэр, 8354 газар зүйн нэр бүхий 30381 хуудас баримтыг AMS программад оруулж тодорхойлон бичлээ. Архивт байгаа 2 хөмрөгийн 3 байгууллагын 1954-2011 оны 130 хадгаламжийн нэгжийн 11330 хуудас баримтыг сканердан мастер хувийг үйлдэн тусгай файл үүсгэн хадгалах ажлыг зохион байгуулав. Архивын 5 хөмрөгийн 12 байгууллагын 1954-2013 оны 12 дансны 266 хадгаламжийн нэгжийн 22595 хуудас баримтыг фото шоп программаар засварлан ашиглалтын хувь үйлдэн /тусгай файл/ цахим мэдээллийн сан үүсгэн хадгалж байна. 5 хөмрөгийн 14 байгууллагын 1966-2013 оны 14 дансны 273 хадгаламжийн нэгжийн 17842 хуудас баримтыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | /PDF/-программад хөрвүүлэн цахим холболт хийлээ. Баримт бичгийн 1 хөмрөгийн 1 байгууллагын 1951-1998 оны 123 хөмрөгийн нэгжийн 11204 хуудас баримтанд нягтлан шалгалт хийж, 2 хөмрөгийн 9 байгууллагын 1953-2011 оны 188 хадгаламжийн нэгжийн хавтасыг шинээр сольж хавтаслалаа. | |
| **/69/** 5.1.5. Төрийн цэргийн бодлогын хүрээнд батлан хамгаалах бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлж, эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагын холбоог нэмэгдүүлж, ирээдүй болсон хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ. | 373 | 5.1.5.1. Цэргийн жинхэнэ алба болон гэрээт цэрэг, цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах | 2016-2020 | ЦШ | ОНтөсөв 4081500 | Монгол Улсын Үндсэн Хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлнэ. | 2016 оны 2 дугээр ээлжийн цэрэг халах, 2017 оны 2 дугээр ээлжийн цэрэг татах ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон цэрэг татлагын товчоо, эмч нарын комиссын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж Булган сум болон урд бүсийн 8 сумын нийт 800 шахам цэргийн насны залуучуудыг урьдчилсан болон төвийн комиссын үзлэгт хамруулж 250 шахам хүнийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн Хилийн болон Ерөнхий зориулалтын цэргийн ангиудад хуваарилан өгч, хугацаат цэргийн албыг хаалгаж байна. “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ын дагуу 6 иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон шалгаруулалтаар тэнцүүлэн Зэвсэгт хүчний ангид албыг нь үргэлжлүүлэн хаалгаж байна. Зэвсэгт Хүчний Жанжин Штабаас өгсөн гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын хяналтын тоог 100 хувь биелүүллээ. Аймгийн Засаг даргын 2017 оны А/433 дугаар захирамжаар 2017-2018 онд орон нутагт цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг ЗХ-ний 186 дугаар ангийн сургалтын төвд ОБГ болон ЗХ-ний 186 дугаар ангийн багш офицер, ахлагч нараар 112 цагийн сургалтыг 14 хоногийн хугацаатай 35 иргэнд зохион байгуулж, гүйцэтгэх үүргийн мэдлэг дадлагыг олголоо. 2017 оны ЗГ-ын 51 дүгээр тогтоолын дагуу 98 иргэнийг цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгуулсан. | 100 |
| | 374 | 5.1.5.2. Аймгийн дайчилгаа удирдлагын байрыг тохижуулж, дайчилгааны даалгаврыг | 2016-2020 | ЦШ | Улсын Төсөв 4838750 | Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих | Булган аймагт 2017 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг 2016 оны 12 дугаар сарын 10-наас 2017 оны 1 дүгээр сарын 10-ны хооронд цэргийн тоо бүртгэл зохион байгуулах | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэн, бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг орон нутагт зохион байгуулах | | | | нөхцөл бүрдэнэ. | журмын дагуу явуулж, дүнг 1 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд нэгтгэж, сумдын ЗДТГ-ын дарга нартай 2 өдрийн сургалт семинарыг зохион байгуулав. Батлан хамгаалахын Сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний дагуу 16 сумын 75 багийн Засаг дарга нартай “Цэргийн бэлтгэл” сургалтыг 5 дугаар сарын 9-нөөс 11-ний хооронд, БХЯ-аас зохион байгуулсан төвийн бүсийн аймгуудын сумдын ЗДТГ-ын дарга нарын сургалтанд 7 сарын 19-23-нд 16 сумын ТГ-ын дарга нарыг хамруулан тус тус цэргийн хэргийн мэргэжлийг дээшлүүлсэн. Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг хангах зорилгоор 2, 4 дүгээр улиралд аймгийн 16 сумдад орон нутгийн тодотголыг явуулж, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн түрүүч, байлдагч 40 хүнд шинээр мэргэжил эзэмшүүлэх сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 17-ноос эхлэн 14 хоногийн хугацаатай дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний 186-р ангийн “Сургалтын төв”-д төвлөрүүлэн зохион байгууллаа. | |
| | 375 | 5.1.5.3. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, хүүхэд залуучуудын дунд цэрэгжсэн тоглолт, спорт урлагийн тэмцээн зохион байгуулж, цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх | 2016-2020 | ЦШ | ОНТөсөв 2757500 | Цэрэг эх оронч үзэл төлөвшиж, цэргийн алба хаах сонирхол нэмэгдэнэ. | Зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги байгууллагуудад цэргийн албаа үлгэр жишээ, нэр төртэй хааж байгаа нэр бүхий 10 цэргийн албан хаагчдын ар гэрт талархлын захидал, тавгийн идээ гардуулан өгсөн. Буудлагын спорт сонирхогчид, өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, залуучуудын аймгийн аварга шалгаруулах "Хүчний-3 төрөлт" Пауэрлифтингийн тэмцээнийг тус тус амжилттай зохион байгууллаа. Булган аймагт ажиллаж, амьдарч байгаа дайнд оролцсон ахмад дайчид болон цэргийн штабаас амралт чөлөөнд гарсан ахмадуудыг хүлээн авч баярын цуглаан зохион байгуулан хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа. Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг 3-р сарын 16-ны өдөр амжилттай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгууллаа. Батлан хамгаалах яамны харьяа Монгол цэргийн музей, батлан хамгаалах төв архив, Булган аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран монгол цэргийн музейн “Түүх өгүүлсэн он жилүүд” үзэсгэлэнг зохион байгуулж, Батлан хамгаалах төв архиваас иргэдэд үнэ төлбөргүй цэргийн алба хаасан лавлагаа гаргаж үйлчиллээ. Тус арга хэмжээний хүрээнд Батлан хамгаалахын төв архивын дарга хурандаа З.Эрдэнэбат Булган аймгийн харъяат 1939 оны Халхын голын дайн, 1945 оны чөлөөлөх дайн, баруун хилийн тулгаралтанд оролцсон 1533 дайчдын нэрийн бүртгэлийг Булган аймгийн Засаг дарга З.Батзоригт гардуулан өгсөн. Цэрэг татлагын товчоо, Хил Хамгаалах Ерөнхий газартай хамтран иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд ХЦ-ийн 0243-р анги дээр эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагын гурвалсан уулзалтыг зохион байгууллаа. “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдэвт Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Энхийг сахиулах ажиллагааны зорилго, ач холбогдолыг сурталчлах ажлыг хөтөлбөрийн дагуу Бугат, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд зохион байгуулан ажиллалаа. БХЯ-ны Сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2017” тэмцээнд Цэрийн штаб Булган аймгийн ахлах ангийн сурагчдаас бүрдсэн 13 хүүхдийн бүрэлдэхүүнтэй тасаг бэлтгэж амжилттай оролцсон. Залуу жанжин Жамъянгийн Лхагвасүрэнгийн мэндэлсэний 105 жилийн ойг тохиолдуулан эрдэм шинжилгээний бага хурлыг Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн музей, Батлан хамгаалах төв архивтай хамтран зохион байгуулж түүний түүхэн амьдрал, байгуулсан гавьяаг иргэдэд сурталчилсан. | |
| ***/70/*** 5.1.6. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх | 376 | 5.1.6.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж сургалт, сурталчилгааг тогтмол зохион | 2016-2020 | ОБГ | ОНТөсөв | Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдана. | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах зорилгоор 2017 онд аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээнд 5 асуудлыг тусган хэрэгжүүлээд байна. Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| тогтолцоог орон нутагт бүрдүүлж, гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах зорилгоор олон нийтэд тулгуурласан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ. | | байгуулах | | | | | Тамгын газрын дарга нарт сургалт хийж 56 хуудас бүхий гарын авлага тарааж өглөө. Мөн 16 сум, 1 тосгоны хэмжээнд Газар хөдлөлтийн гамшгийн үед амжиж анхааруулах зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулагдаж 180 байгууллага, аж ахуйн нэгж, 76 техник, 6060 хүн хамрагдсан байна. ОБГ-ын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн 11 сумын 1400 иргэнд, удирдах бүрэлдэхүүн, орн тооны бус удирдлага штаб, мэргэжлийн анги, ажилтан, сурагчид, иргэдэд сургалт зохион байгуулж сумдын бэлэн байдлыг шалган илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаа. ЦГ, ГБХЗХГ-тай хамтран 10 сум, багуудад ажиллан иргэдэд сургалт хийж санал хүсэлтийг авч ажиллалаа. | 100 |
| | 377 | 5.1.6.2. Сумдын объектын гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулан ажиллах | 2016-2020 | ОБГ | ОНТөсөв | Орон нутагт гарсан объектын гал түймрийн хохирлын хэмжээ багасна. | 16 сум, 1 тосгоны хэмжээнд объектын гал унтраах тоног төхөөрөмжтэй болсон бөгөөд түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар төсөл боловсруулан сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт танилцуулсан. 2017 оны 5 дугаар сард ОБГ-аас 2 ажлын хэсгийг сумдад ажиллуулж галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулах ажил зохион байгууллаа. Сэлэнгэ сум өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гал унтраах үндсэн албаны автомашинтай болсон. Онцгой байдлын газраас Хутаг-Өндөр, Могод, Хангал, Тэшиг суманд гал унтраах зориулалтын автомашин хүлээлгэн өгч байршуулж, дадлага сургалт хийгдлээ. | 100 |
| | 378 | 5.1.6.3. Гал сөнөөгч, аврагч нарын ажил үүрэг гүйцэтгэх нөхцлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | ОБГ | ОНТөсөв | Гал сөнөөгч, аврагч нарын ур чадвар сайжирч, бэлэн байдал сайжирна. | Онцгой байдлын газрын нийт албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийг 2016 онд эхлүүлэн 70 хувийн гүйцэтгэлийг хийж, 2017 оны 6 сарын байдлаар барилгын дотор засвар, гадна пасадны ажлыг гүйцэтгэж, алба хаагчдын хувцас солих болон ариун цэврийн өрөөг шинээр барих ажил хийгдэж 09 дүгээр сард ашиглалтанд өглөө. | 100 |
| | 379 | 5.1.6.4. Аймгийн Онцгой комиссын чадавхийг сайжруулж, хүч | 2016-2020 | ОБГ | ОНТөсөв, Гамшга | Аймгийн Онцгой комиссын | Аймгийн Онцгой комиссоос үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 2017 онд 3 удаа хуралдаж ИТХ-ын Тэргүүлэгчдын тогтоол 1, | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгслийн нөөцөд техник тоног төхөөрөмж авч, болзошгүй гамшгийн үед бэлэн байдлыг хангах | | | ас хамгаал ах сан | болзошгүй эрсдлийн үед ажиллах чадвар сайжирна. | Засаг даргын захирамж 2, Онцгой комиссын даргын тушаал 20-ыг гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Онцгой комиссын нөөцөд 27 нэр төрлийн 206 ширхэг 95.2 сая төгрөгний эд зүйл бэлэн байдалд хадгалагдаж байна. | |

**БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,**

**ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА /Ш.БОЛДБААТАР/**

**ХЯНАСАН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА /Б.УУГАНБАЯР/**

**ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА /З.БАТЗОРИГ/**